**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМЫН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 25 өдөр Дугаар 2/01 Бүрд сум

Сумын Засаг даргын 2020-2024 оны
үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд
үнэлэлт дүгнэлт өгөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сумын Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг 85,1 хувийн биелэлтэй буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлсүгэй.

2.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан боловч хэрэгжээгүй, хангалтгүй хэрэгжсэн зорилт арга хэмжээг 2024-2028 оны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган ажиллахыг сумын Засаг дарга (З.Оюундулам)-д үүрэг болгосугай.

ДАРГА Д.ПҮРЭВ

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ /2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/**

**2024.12.02** **Бүрд**

| | ХБТББ-т тусгагдсан Зорилт, үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Нийт хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/ 2023 он | | | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая,төг) | Төсвийн гүйцэтгэл (сая,төг) | | ТГ | ИТХ |
| **ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | | | | | |
| **3.1.Ёс зүй, хариуцлагатай төрийн алба** | | | | | | | | | | | | |
| 1 | **Зорилт 1. Төрийн байгууллагуудын чиг үүргийг оновчтой тодорхойлж, давхардлыг арилгах, үйл ажиллагааны уялдааг хангах замаар үр ашигтай бүтэц бүхий мэргэшсэн чадварлаг,** | Төрийн албан хаагчийг тогтвортой ажиллах баталгааг хангаж, чадахуйн зарчимд суурилж, төрийн албаны хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, тэднийг чадвахжуулах , мэргэшүүлэхэд анхаарч ажиллана | 2021-2024 | ЗДТГ/ТГ-ын дарга/ | Байгууллагуудын батлагдсан төсөв | ТЖАХ нар нийт 9-өөс 2 ньтүр томилгоотой | ТЖАХ нарыг үе шаттайгаар УА-ын сургалтуудад хамруулна. /8 албан хаагч / | | | 2021 онд “Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт” , 2022 онд ЗГХЭГ-захиалгаар Удирдлагын академиас зохион байгуулсан "Нутгийн захиргааны байгууллагын удирдлага, зохицуулалт" сэдэвт 24 цагийн цахим сургалтанд 1 албан хаагч, Удирдлагын академаас зохион байгуулж буй Мэргэшүүлэх дунд хугацааны чиглүүлэх сургалт 1 албан хаагч хамрагдав. Мөн "Алсын хараа - 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт, онцлох ажлуудын хэрэгжилтийн явцын талаар зөвлөлдөх уулзалтад 7 албан хаагч Улаанбаатар | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **тогтвортой, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлнэ** | | | | | | | | | хотод 2 өдрийн хугацаатай тус тус оролцов. 2023 онд “Алсын хараа—2050” богино хугацааны сургалтанд давхардсан тоогоор 38 албан хаагч онлайнаар хамрагдаж сертификат авсан .Сумын хэмжээнд эрхийн хугацаанд төрийн албан хаагчдаас 4 албан хаагч баклаварын, 8 албан хаагч магистрын, 1 албан хаагч дипломын боловсрол эзэмшсэн бөгөөд ажил олгогч байгууллагаа цалинтай чөлөө олгох зэргээр дэмжлэг үзүүлж ажилласан байна.<br>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй Пүрэв гаригын 4-7-10 сургалтанд бүх төрийн албан хаагчид хамрагдаж байна. | | |
| 2 | | Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ төлөвлөгөө, ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон дүгнэж, мэдээллийн санг бүрдүүлнэ. | 2021-2024 | ЗДТГ/ТГ-ын дарга/ | Хөрөнгө шаард ахгүй | ТАХ ажлыг үнэлж дүгнэдэг. | Төлөвлөгөө ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй сахилга хариуцлага гэсэн шалгуур үзүүлэлтээр үнэлнэ. | - | | 2021-2022 оны төрийн албан хаагчдын үр дүнг үнэлж дүгнэхдээ гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, хандлага, ур чадварыг ЗГХЭГ-ийн 2020 оны 100 дугаар тушаалын 10 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтээр үнэлж байв. 2023 оноос Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл,үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам” , ЗГХЭГ-ийн 98 тушаалаар баталсан загвараар төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хагас жилээр | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ажлыг нь дүгнэн, 1,3 дугаар улирлаар явцын ярилцлага хийж ажиллаж байна. | | |
| 3 | | Төрийн албаны сонгон шалгаруулалт, хүний нөөцийн томилгоо, сахилга хариуцлага, ёс зүйтэй холбоотой шийдвэрийг бүх байгууллагад ил тод, нээлттэй болгоно. | 2021-2024 | ЗДТГ/ТГ-ын дарга/ | Хөрөнгө шаардахгүй | Сумын сайтаар дамжуулж нийтэд мэдээлэлдэг. | Сонгон шалгаруулалт, томилгоо, ёс зүйн шийдвэрүүдийг нийтэд мэдээлж хэвшинэ. | - | | 2021-2024 онуудад сумand дутагдалтай байгаа төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалын сул орон тооны захиалгыг аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж ажилласнаар, 11 ажилтныг сонгон шалгаруулалтаар авсан байна. Төрийн захиргааны албан хаагчдын сул орон тоо, ажлын чиг үүрэг, харилцах утас, цахим шуудан, албан тушаалын тодорхойлолт зэргийг сумын цахим сайтад байршуулан ажиллаж байна. Мөн төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтан , засаг даргын орлогч, төрийн захиргааны удирдах албан тушаалтан, байгууллагын нягтлан бодогчид, багийн засаг дарга зэрэг 13 хүний ХАСУМ-ыг АТГ-т хянуулсан дүгнэлтийг сумын веб сайтад байршуулсан. | 100 | |
| 4 | | Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагчийн төрийн албан дахь хөдөлмөрийн харилцаатай холбоотой шийдвэрийн эрх зүйн үндэслэлд тогтмол хяналт тавьж, зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлнэ. | 2021-2024 | ЗДТГ/ТГ-ын дарга/ | Хөрөнгө шаардахгүй | ЗДТГ хянадаг байсан. | Төрийн албан дахьхөдөлмөрийн харилцаатай холбоотой шийдвэрийн эрх зүйн | | | 2021-2023 онуудад аймгийн Хууль эрх зүйн хэлтэст сумын засаг даргын үйл ажиллагааны болон боловсон хүчинтэй холбоотой захирамж, тамгын газрын даргын үйл ажиллагааны болон боловсон хүчинтэй холбоотой тушаалыг хянуулсан бөгөөд хяналтаар тодорхой зөрчил илрээгүй. Төсвийн байгууллагын дарга нарын тушаалыг Тамгын газрын хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн жил бүр 1 удаа татан авч хянасан эрх зүйн үндэслэл | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үндэслэлд тогтмол хяналт тавиж зөрчил дутагдал гаргахгүй байх. | | | зөрчил дутагдалгүй бичиг эрхийг стандарт дээр зөрчил байсныг залруулахаар зөвлөмж хүргүүлж, хяналт тавин ажиллаж байна. | | |
| **3.2.Цахим технологид суурилсан төрийн үйлчилгээ** | | | | | | | | | | | | |
| 1 | Зорилт 1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг оновчтой арга, хэлбэрээр зохион байгуулна. | Иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар хүргэх операторын үйлчилгээг улам өргөтгөн , төрийн үйлчилгээг явуулын хэлбэрээр хүргэх үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | 2021-2024 | ЗДТГ/ улсын бүртгэгч/ | - | 85 | 200 | - | 0.1 | Иргэд харьяалал харгалзахгүй хаанаас ч төрийн үйлчилгээг нэг дороос авах нөхцөл бүрдэж 2021 онд Нийгмийн халамжийн 9 үйлчилгээ цахимд шилжиж давхардсан тоогоор 550 хүн хамрагдсан. Мөн операторын үйлчилгээнээс 277 төрлийн үйлчилгээг үзүүлэх боломжоор хангагдсан. 2021 онд 36, 2022 онд 45 хүнд бөгөөд 2023 онд 66 иргэнд төрийн төрийн үйлчилгээний нэгдсэн системээр операторын үйлчилгээ үзүүлсэн үйлчилгээг үзүүлсэн.<br>2024 онд 11 дүгээр сарын байдлаар операторын үйлчилгээгээр 402 иргэн үйлчлүүлсэн. | 100 | |
| 2 | | Төрийн үйл ажиллагааг нь ил тод болгох, | 2021-2024 | ЗДТГ төрийн бусад байгууллагуудын дарга нар | Орон нутгийн төсөв 3000,0 | | Интернет хурд сайн байх, сумын цахим сайт, | 12,0 | 9.7 | ЗДТГ-т Монголын цахилгаан холбоо ХХК-ны интернет ашиглаж байснаа 2023 оны 10 сараас Мобиком ХХК-ны интернетийг ашиглах гэрээ байгуулан ажиллаж байна. ЕБС БСШУЯ-аас, СӨББ гэр интернет , Соёлын төв, Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагууд | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төрийн байгууллагуудын интернэтийн хурд, чанар ашиглалтыг сайжруулана | | | | | пейж хуудсанд төрийн байгууллагуудын мэдээ мэдээлэл тогтмол мэдээлж байх. | | | Монголын цахилгаан холбоо ХХК-ны ашиглаж байна. Бүх байгууллагын интернетийн хурд сайн байна. | | |
| 3 | | Төрийн байгууллагуудад дотоод удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааг цахимжуулж, иргэд асуудлын шийдвэрлэлтийн явц, үр дүнг цахимаар хянах нөхцөлийг бүрдүүлнэ. | 2021-2024 | Төрийн байгууллагууд | . Хөрөнгө шаардахгүй | ТБ-уудын дотоод удирдлагын нэгдсэн систем нэвтрэх эхлэл тавигдсан | ТБ-уудын дотоод удирдлагын нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлэх | - | - | Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ЗДТГ байууллагатаа нэвтрүүлсэн, албан хаагчид ажилтануудынхаа цаг бүртгэл, албан хэрэг хөтлөлт, ажлын тайлан зэргийн системээр явуулж байна. Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, хувийн хэргийн анкетыг оруулсан. Мөн цахим орчинд төрийн байгууллагатай холбоотой гарсан санал өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэж байна. | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | | Төрийн байгууллага хооронд болон тэдгээрээс иргэдтэй харилцах мэдээллийн солилцоо, ил тод байдлыг сайжруулж, бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | 2021-2024 | Төрийн байгууллагууд | 1000,0 | | | | | Төрийн байгууллагын дарга, ня-бо нар , байгууллагуудын дотоод мэдээлэл солилцох фейсбүк групп ашиглан мэдээлэлээ түргэн шуурхай солилцож байна. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт оруулах санал, хүүхдийн тоглоомын талбайн байршил зэрэг асуудлаар иргэдээс цахимаар санал авснаас гадна “сумын төвийн дүрэм “-ээр нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав. Мөн сумын сонинг 3 удаа гаргаж иргэдийг мэдээллээр хангаад байна. | 100 | |
| 5 | | 2, 3, 4, 5 дугаар багийн төвүүдийн барилгыг шинээр барих, 1 дүгээр багийн төвийн байрыг засварлах, Багийн засаг дарга нар болон төрийн байгууллагуудын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ЗДТГ | | 1-р багийн төв шаардлага хангасан байртай | Шинээр баригдаж, засвар үйлчилгээ хийгдсэн байна. | 194,0 | 204,3 | Багийн дарга нарт 5ш, ЗДТГ-т суурин 1, зөөврийн 5, өнгөт принтер, ИТХ-д суурин 1 ш, зөөврийн 1ш компютераар хангагдсан байна .<br>2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр 2,3 дугаар багийн иргэний танхимыг шинээр барьж, 1-р багийн конторт их засвар хийсэн. | 100 | |
| 6 | | Төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа сурталчлах зардлыг жил бүр төсөвтөө тусган, мэдээллийн ил тод байдлыг хангахад хяналт тавьж, иргэдэд үнэн бодит мэдээлэл | 2021-2024 | ЗДТГ | 450,0 | Вэйб сайт хөтлөгддөг. | Жилд 2 удаа сонин гаргах, вэйб сайтыг хөтлөх | 4,0 | 8,5 | Сумын веб сайтыг хөгжүүлэхэд жил бүр 280,0 мян.төг зарцуулж байна . Веб сайт хэвийн ажиллаж байна. Сайтын мэдээллийг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн байнга нийтэд мэдээлж байна. “Бүрд” сонинг 3 удаа гаргасан. | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч, “Нэг цонхны мэдээлэл” үйл ажиллагааг үр дүнтэй нэвтрүүлнэ. | | | | | | | | | | |
| 7 | | Төрийн байгууллагуудын дотоод хяналт, шалгалтын нэгжийн үйл ажиллагааг тогтмолжуулж, гүйцэтгэлийн хяналт, үр нөлөөг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ЗДТГ | | Байгууллага бүр дотоод хяналт шалгалтын нэгж байгуулан ажиллаж байгаа | Байгууллага бүр дотоод хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагааны төвлөвлөгөө батлуулан улиралд 1-2 хяналт шалгалтыг хийсэн байна. | | | 2021-2023 ондуудад бүх төсвийн байгууллагууд өөрийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажиллаа. 2021 онд бүх төсвийн байгууллагууд дээр төсөв санхүү, үйл ажиллагаа, нийцлийн буюу эрх зүйн зохицуулалт, гадаад дотоод орчин гэсэн чиглэлээр эрсдэлийн үнэлгээ хийн тус үнэлгээн дээр тулгуурлан 4 бүлэг бүхий төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 5 удаагийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. 2022 онд Засгийн газрын 2011 оны “нийтлэг журам батлах тухай” 311 дүгээр тогтоолтой уялдуулан Дотоод хяналтын нэгжийн ажиллах журмыг боловсруулж мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн энэ онд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус 4 хяналт шалгалтыг зохион байгуулсан.<br>2023 онд Дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагууу 8 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж зөрчил дутагдлыг арилгуулахаар зөвлөмж хүргүүлэн ажилласан. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар төлөвлөгөөт хяналт | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | шалгалтыг 9 удаа, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 1 удаа зохион байгуулж ажилласан. | | |
| 8 | | Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гарсан зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах үүрэг чиглэл өгч тухай бүрт хэрэгжүүлэх арга авч үр дүнг тооцон ажиллана. | 2021-2024 | ЗДТГ | | Жилд 1 удаа ХШҮ хийдэг | Жилд 2 удаа ХШҮ хийсэн байна. | | | Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын төлөвлөөг жил бүр батлуулан хэрэгжилтийг ханган ажилдаг бөгөөд 2021 онд төлөвлөгөөт 4 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан. 2022 онд 5 удаагийн хяналт шалгалт хийж гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан ажиллах үүрэг чиглэл өгч ажилласны дагуу оны эцсийн хяналт шинжилгээ үнэлгээгээр хангалттай үнэлэгдсэн. 2023 онд 8 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллсан.<br>2024 оны 11 дүгээр сарын байдлаар төлөвлөгөөт хяналт шалгалтыг 9 удаа, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 1 удаа зохион байгуулж ажилласан. Ингэхдээ тухай бүр нь ажлын хэсэг томилж тусгай удирдамжаар хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Хийгдсэн шалгалтын талаар тухайн хариуцагч байгууллагад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар зөвлөмж хүргүүлж ажилласан. | 100 | |
| **3.3.Эрх зүйн боловсролтой иргэн, хүний эрхийг хангасан нийгэм, авлигагүй засаглал** | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Зорилт 1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг оновчтой арга, хэлбэрээр зохион байгуулна. Улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу эрхлэн хөтөлнө.** | Цахим технологид суурилсан арга хэлбэрээр хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулж, "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ЗДТГ | | | 100% | | | 2021-2024 онуудад Бүрд сумын албан ёсны пейж хуудас, ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ, байгууллагын дотоод сүлжээ зэрэг олон нийтийн сүлжээгээр дамжуулан шинээр батлагдсан хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм журмыг нийт 23 удаа цахимаар хүргэж ажилласан. 2023 онд Бүх нийтийн эрх зүйн боловсролын дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн энэ хүрээнд Сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/14 дүгээр захирамжаар хууль эрх зүйн сургалт сурталчилгааны төлөвлөгөөг боловсруулж нийт төрийн албан хаагчдад чиглэсэн 14 сургалт хийгдэхээс 9 сургалт хийгдсэн. Иргэд олон нийтэд чиглэсэн 9 сургалт хийгдэхээр төлөвлөснөөс 8 сургалт хийгдсэн. Хүүхэд залуучуудад чиглэсэн 7 сургалт зохион байгуулахаас 5 сургалт хийгдсэн. Мөн 2023 оноос "Бүрд сумын эрх зүйн хөтөч" Facebook группыг нээн ажиллуулж энэхүү группээр дамжуулан шинээр батлагдсан хууль тогтоомж болон, УИХ, Засгийн газар, яам агентлаг, аймгийн ИТХ, Засаг даргаас батлагдсан дүрэм, журам зэргээр 37 удаа мэдээлэл хүргэж ажилласан.<br>2024 оны 03 дугаар сарын 14-ны өдөр сумын Засаг даргын А/20 дугаар захирамжаар "Хууль эрх зүйн сургалт сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав. Энэ онд нийт 13 удаа хууль | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | эрх зүйн сургалт сурталчилгаа зохион байгуулж давхардсан тоогоор 291 төрийн албан хаагч, 832 иргэн хамрагдсан байна. Мөн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 7:4:10 сургалтыг ажлын байран дээрээ тогтмол хамрагдаж байна. Нийт 26 удаагийн сургалт хэлэлцүүлэгт давхарсан тоогоор 712 иргэн хамрагдсан бөгөөд 5 төрлийн сургалтын материал гарын авлагыг бэлтгэж иргэдэд хүргэсэн. | | |
| 2 | | Төрийн болон иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-үнэлгээ хийж, шийдвэр гаргахдаа аливаа хэлбэрээр ялгаварлахгүй, ашиг сонирхлын зөрчилд автахгүй, хязгаарлал, давуу байдал тогтоохыг хориглоход анхаарч ажиллана. | 2021-2024 | ЗДТГ-ын дарга | | 2 | Жилд 2 удаа | | | Засаг дарга, төрийн байгууллагын дарга Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1 / Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана./ гэсний дагуу 2021, 2022, 2023, 2024 онуудад 350 гаран удаа мэдэгдэл тайлбар гаргаж, түүнийг цахим санд бүртгэсэн байна. | 100 | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | | Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн, олон талт арга хэмжээг зохион байгуулж үр дүнг олон нийтэд мэдээлж ажиллана. | 2021-2024 | ЗДТГ | | 0 | 4 удаа | | | 2021-2024 оны байдлаар Хүний эрх эрх чөлөө зөрчсөн аливаа шийдвэр гараагүй. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг төрийн захиргааны албан хаагчдад танилцуулах хуудсаар танилцуулсан. Мөн төсөвт байгууллагуудад цахимаар хүргүүлж сурталчилж ажилласан мөн Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Хүний эрхийн үндэсний комиссын гишүүний Өвөрхангай аймагт ажилласны дараа ирүүлсэн зөвлөмж, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Хүний эрх, эрх чөлөөг хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 443 дугаар тогтоол, Монгол Улсын Их хурлын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 37 дугаар тогтоол зэргийн хяналтад аван төрийн албан хаагчидад танилцуулсан.<br>Хүний эрхийн үндэсний комиссоос боловсруулсан мэдээ мэдээллийг сумын олон дагагчтай Facebook группүүдэд болон “Бүрд сумын эрх зүйн хөтөч” хуудсанд байршуулж олон нийтэд сурталчилж ажиллсан. Нийт 13 мэдээллийн нийтэлж ажилласан байна. | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | | Суманд хэрэглэгчийн эрхийг хамгаалах, шударга бус өрсөлдөөнтэй тэмцэх үүрэг бүхий салбар зөвлөл байгуулж , хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг үйл ажиллагааг идэвхжүүлэн, бизнесийн байгууллагуудын шударга бус өрсөлдөөн, үнийн хөөрөгдөл, бүтээгдэхүүний чанар байдлыг хянаж, монополь үүсгэхээс сэргийлж ажиллана. | 2021-2024 | ЗДТГ | | Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зөвлөл байхгүй. | хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зөвлөл байгуулж хяналт шалгалтын ажлыг 2 -оос доошгүй удаа зохион байгуулна. | | | Засаг даргын захирамжаар хэрэглэгчийн эрхийг хамгаалах зөвлөл байгуулсан. Суманд үйл ажиллагаа явуулж буй 3 шатахуун түгээх, 8 нэрийн 5 дэлгүүр, 6 нэрийн 3 дэлгүүр хамруулан ажилласан.<br>Хяналтын явцад и-баримт олгогдох байдал, бүтээгдэхүүний хадгалалт, хугацаа, үнийн нэмэгдэл зэргийг шалгалаа.<br>Нийт зөрчил дутагдал: шатахуун түгээгүүрийн газрууд и-баримт олголт муу байгаа ард иргэдийг нэхэхгүй бол өгдөггүй, мөн чанарын үзүүлэлтийг үзүүлэх бичиг баримт дутуу байгаа. Хүнсний дэлгүүрүүдэд хугацаа нь хэтэрсэн хүнсний бүтээгдэхүүн илэрсэн 2022 онд Тэнгэрийн оргилго 250000, Их Бүрд 200000/ бөгөөд устгал болон буцаалтын арга хэмжээ авахыг зөвлөн бүртгэл хийсэн. 1 дэлгүүрийн агуулах хүнсний бүтээгдэхүүн хадгалах шаардлага хангахгүй байсан учир хугацаатай үүрэг даалгавар өгсөн. | 70 | |
| 5 | | Улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу эрхлэн хөтөлж , иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах. | 2021-2024 | ЗДТГ /Улсын бүртгэл/ | Хөрөнгө шаардахгүй | Иргэдэд чирэгдэлгүй үйлчилж байсан. | Иргэдэд улсын бүртгэл үнэн зөв хөтлөгдөж иргэдэд үйлчилгээг хүртээмжтэй | - | | 2021-2024 онуудад улсын бүртгэлийн үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд үзүүлж байна. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр төрөлт, үрчлэлт - , эцэг тогтоолт , овог эцэг эхийн нэр нэр өөрчлөлт, гэрлэлт , нас баралт , шилжилт хөдөлгөөн , шинэчилсэн бүртгэл , иргэний үнэмлэх олголт, төрсний гэрчилгээ дахин олголт, иргэний улсын бүртгэлийн лавлагаа-, иргэний үнэмлэх дахин олголт зэргээр | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүргэсэн байна. | | | үйлчилж байна. Мөн 2024 оноос хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 16 бүртгэл хийсэн. Үүнээс шинээр хоршоо - 12, нэмэлт өөрчлөлт–2, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа- 2 бүртгэгдсэн. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр: газар өмчлөх болон үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ авах зэргээр иргэдээс материал хүлээн авч гэрчилгээ олгосон. Хуудас эх нотлох баримтыг хуулийн хугацаанд цахимжуулж баталгаажуулсан. Эрхийн хугацаанд 1418 иргэнд тоон гарын үсэг олгосон байна. | | |
| 1 | Зорилт 2. Олон нийтийг соён гэгээрүүлэх замаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэн, тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | Авлигыг үл тэвчих үзэл хандлагын талаарх нийтлэл, нэвтрүүлгийг цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн байгууллагаар олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажил зохион байгуулна. | 2021-2024 | ЗДТГ | Хөрөнгө шаардахгүй | 15 | 60 | 0,4 | | АТГ-ын “Олон нийтийн төв”-ийн Өнөөдөр “ашиг” олж байгаа мэт санагдавч #авлигын хор уршгийг бүх нийтээрээ төлдөг... Бусдын #боломжийг_бүү_хулгайл❗, Авлигаас хэн ч хождоггүй…, Үнэний ҮНЭ үгүй болсон энэ цагт Үүргээ ухамсарлан ТА шүглээ ҮЛЭЭ... #110 #ШүглээҮлээ #ИлчилжАВАР зэрэг контентууд, 10 дугаар сарын 11-ны мэдээлэл, #Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа #110 #Гомдол_мэдээлэл_хүлээн_авах_утас, #Зөв_зөвд_шударга_зөв зурагт хуудас 2024 онд АТГ-аас гаргасан 12 ш шторкийг Бүрд сумын албан ёсны пейж хуудас, цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлсэн. | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ЗДТГ ,ЕБС,СТ, ЭМТ зэрэг байгууллагуудад авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зурагт хуудаснууд байрлуулсан, авилга ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гарын авлага материалыг 80 төрийн албан хаагчдад тарааж олгосон. | | |
| 2 | | Хүүхэд, залуучуудад авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах сургалт, сурталчилгаа зохион байгуулж, авлигыг үл тэвчих үзэл хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр боловсролын байгууллагатай хамтран олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ЗДТГ | Хөрөнгө шаард ахгүй | 2 | 4 арга хэмжээ зохион байуулсан байна. | - | | Тус сумын сургуулийн “Өвөрхангай Бүрд сумын Д.Пүрэвдоржийн нэрэмжит, аймгийн тэргүүний ЕБС” олон нийтийн сүлжээнд АТГ-ын 2 видео шторкийг байрлуулсан..<br>Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад “Дэлхийн авлигын “ эсрэг өдөр буюу 12 сарын 09 өдөр Бага ангид “Авлига миний нүдээр” дунд, ахлах ангиудад “Авлига түүний хор уршиг” сэдэвт хичээлийг зохион байгуулж, Авлигын эсрэг тухай хууль, тогтоомжуудыг байгууллагын мэдээллийн самбарт байршуулж мөн ахлах ангийн сурагчдын дунд Авлига ба шударга ёс хэлэлцүүлэг, эссэ бичлэгийг зохион байгуулж ажилласан. Нийт давхардсан тоогоор 410 сурагч хамрагдсан байна.<br>Мөн 2024 онд “Авлигын эсрэг бид хамтдаа”сэдэвт эссэ бичлэгийн уралдаан зарласан. | 100 | |
| 3 | | Сумын авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган, үр дүнг тооцон ашиг сонирхлын зөрчил гаргуулахгүй байх арга | 2021-2024 | ЗДТГ | Хөрөнгө шаард ахгүй | 1 | 1 | - | | АТҮХ-ийн 2021 оны хэрэгжилтийг 92,1%, 2022 оны хэрэгжилт 91,8%, 2023 оны 81,9%-ийн хэрэгжилттэй байна гэж дүгнэсэн. Жил бүр авилгаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийг хانган ажиллаж байна. | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээ авч хэрэгжүүлнэ. | | | | | | | | Тайлан төлөвлөгөөг аймгийн Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн. | | |
| 1 | **Зорилт 3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг сайжруулна.** | Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай" дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ | 2021-2024 | ЗДТГ - | | 70 | Хөтөлбөрийн хэрэгжилт 100% хангагдсан байна. | | 5,9 | "Амар тайван Өвөрхангай" дэд хөтөлбөрт хувийн хэрэг нээн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилт 87,1%-тай байна.<br>"Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай" дэд хөтөлбөрийг хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгааллах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, чиглэлээр иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгч, хууль сурчилаж, гудамж талбай олон нийтийн газарт төрийн алба хаагч нартай хамтраж тогтмол эргүүл хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллаж байна.<br>Цагдаагийн хэсгийн алба хаагчдын ажиллах нөхцөл бололцоог хангаж чиглэлээр сумын засаг даргын тамгын газраас Probox загварын тээврийн хэрэгслийг худалдан авч өгч, мөн сар тутамд ЗДТГазраас 50 литр шатахуун ИТХурлаас сар бүр 20 литр шатахуун, интернетийн төлбөрийг бүрэн хариуцаж байна. Мөн Хархорины цагдаагийн хэлтсээс тог цахилгааны төлбөрийн 50 хувийг хөнгөлж төлж байна. | 90 | |
| 2 | | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах ажилд | 2021-2024 | ЗДТГ | | | хөршийн холбоо, гудамжны ахлагчий | 2,8 | 6,9 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажилд 10-тын системийг байгуулан ажиллаж байна. Тус сумын төв нь 5-р багийн нутаг | 70 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөршийн холбоо, гудамжны ахлагчийг ажиллуулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн, сумын төвийн гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн зам, талбайн гэрэлтүүлэг, теле-камерын хяналтын системийг хөгжүүлнэ. | | | | | г ажиллуулсан байна.сумын төвийн гэрэлтүүлэг, камерын ажиллагаа хэвийн байна. | | | дэвсгэрт харьяалагддаг учир багийн Засаг даргын захирамжаар хөршийн холбоо, гудамжны ахлагчийг томилон ажиллуулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцуулж эхэлж байна.<br>Сумын төвд гудамжны 31 гэрэл, 4ш гэрэлт цамхаг засч байна.<br>Сумын хэмээнд нийт 25 хяналтын камераас хэвийн ажиллагаатай байна.<br>Төрийн байгууллагууд, худалдаа үйлчилгээний байгууллагууд бүгд камержсан.<br>Сумын орон нутагт гэр бүлийн хүчирхийлэл, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр урьд өмнөх 2021, 2022, 2023, онуудад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байсан, 15 айл өрхөөр сумын засаг даргын ахласан хамтарсан багийн гишүүд болон хэсгийн төлөөлөгч, цагдаа, нарын хамтаар орж, урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж, хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>Сум орон нутагт мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, чиглэлээр малчин болон мал бүхий иргэдэд малаа байнгын тогтмол хараа хяналттай маллах, чиглэлээр санамж, сэрэмжлүүлэг, яриа таниулга хийж, хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан. | | |
| 3 | | Шарлинд байрлах шатахуун түгээх станц, Хөөврийн гүүр зэрэг газруудын тээврийн хэрэгслийн зогсоолын | 2021-2024 | ЗДТГ | 3200,0<br>- | Байхгүй | Хурд сааруулагч-2 | - | | Шарлин дах ШТС-д теле камер байрлуулсан. | 70 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | цэгүүдэд теле-камер байрлуулах, хурд сааруулагчтай болгох, тээврийн хэрэгслийн улсын дугаар танигч LPR камерыг суурилуулах ажлыг аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоотойгоор шийдвэрлэнэ. | | | | | | | | | | |
| 4 | | Нийгэмд түгээмэл буй архидан согтуурах, зам тээврийн осол, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдийг бууруулах, таслан зогсоох олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ЗДТГ | Орон нутгийн төсөв | | Зохион байгуулах арга хэмжээний тоо 10 | 4,0 | | Сумын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөнд тодорхой ажил төлөвлөн ажилласан. Архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зөрчил гаргасан 59 хүнд Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авсан.<br>2021, 2022, 2023, 2024 онуудад Зөрчил үйлдсэн 69 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 5.1.2 дугаар зүйл, 5.1.1 дүгээр зүйл, 5.3.1 дүгээр зүйл хэсэгт зааснаар 1.530.000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авч ажилласан.<br>Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн: 18 иргэнийг Хархорин сум дах сум дундын шүүхээр албадлагын арга хэмжээ авахуулж 7-30 хоногоор баривчлуулсан.<br>Архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож, замын хөдөлгөөнд оролцсон 30 иргэнийг Хархорин сум дахь сум дундын шүүхээр албадлагын арга хэмжээ авахуулж 7-30 хоногоор баривчлуулсан. | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Мөн 10 жолоочийг эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж 4.000.000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Эрхийн үнэмлэхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон замын хөдөлгөөнд оролцсон 25 иргэнийг 10.000.000 төгрөгний бэлэн бус торгуулийн арга хэмжээ авч ажилласан байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осолоос урьдчилан сэргийлэх, чиглэлээр Хашаат сумын Тарны гүүрийн пост болон Есөнзүйл сумын салдаг уулзвар, гарц зэрэгт 7 хоногт 2-3 удаа Хашаат, Есөнзүйл сумын цагдаагийн алба хаагчид нартай хамтран хот хоорондын замд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, жолооч нарт хөдөлгөөнд оролцох үедээ хурдаа тохируулж явах, хамгаалах бүс бүслэж хэрэглэж хэвших, өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангаж, хөдөлгөөнд оролцох чиглэлээр санамж, сэрэмжлүүлэг, яриа таниулга хийж ажилласан. Мөн хот хоорондын зам дагуу байрлах малчин айл өрхөөр орж, малаа хот хоорондын зам дагуу бэлчээрть явуулах тохилдолд хараа хяналттай байлгах, адуу, үхэр бод малд шөнийн цагаар гэрэл ойлгогч, цацруулагч хүзүүвч зүүлгэх чиглэлээр яриа таниулга хийж, санамж, сэрэмжлүүлэг өгч ажилласан. | | |
| 5 | | Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд төрийн зарим байгууллагуудыг татан оролцуулж, мал бүрийг | 2021-2024 | ЗДТГ | . | | Малын хулгайн гэмт хэрэг | | | Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр малчдын дунд 10-тын бүлгүүд 46 байгуулагдаж, 7 хоногт 1 удаа бүлгийн гишүүд хариуцсан нутаг дэвсгэртээ | 90 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүртгэлжүүлэх, мал, махны гарал үүслийн гэрчилгээ олголтыг цахимжуулах, малчдын бүлэг, нөхөрлөлийг чадавхжуулах зэрэг цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж, мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг эрс бууруулна. | | | | | буурсан байна. | | | эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. 2020 онд малын хулгайн гэмт хэрэг 5 гарч байсан 2021 онд 3 , 2022, онд 1 , 2023 онд 2 2024 онд бүртгэгдээгүй байна. Архангай аймгийн Хашаат сум, Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын цагдаагийн алба хаагчид нартай хамтран Тарны гүүр, Хөөвөр, Шарлин, Есөнзүйлийн гарц зэрэг газруудаар хот хоорондын замд хөдөлгөөнтөөр хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, гарал үүслийн гэрчилгээгүй мал мах, тээвэрлэсэн, мал мах, худалдаалан борлуулж, худалдан авч болзошгүй буй иргэдэд хяналт шалгалтыг зохион байгуулж, мал эмнэлэгийн хөдөө аж ахуйн тасгийн алба хаагч нартай хамтран иргэдийг гарал үүслийн гэрчилгээг авч хэвших чиглэрээр ажил арга хэмжээ зохион байгуулж ажиллаж байна. | | |
| 1 | **Зорилт 4. Хууль сахиулах байгууллагын алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.** | Сумын төрийн байгууллагуудын архивыг зориулалтын өрөө тасалгаатай болгож, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд хүргэх үйлчилгээг хялбаршуулна. | 2021-2024 | ЗДТГ | | | Байгууллагуудын архивын өрөө тасалгаа г стандартын шаардлагад нийцүүлнэ. | | 3,1 | Төрийн байгууллагуудын ихэнх нь зориулалтын архивын өрөөтэй болсон. ЗДТГ скайнер, цаас зүсэгч , , баримт үдэгчийн ремен, архивын нягтруулсан шүүгээ, цонхны хөшиг , ЕБС бичиг баримт хадгалах хавтас 50ш, принтер, шат, дулаан хэмжигч, баримтын тавиур 1 ш, тоног төхөөрөмжөөр хангагдсан. ЗДТГ нь 2021-2024 онуудад Нийт 222 хүнд архивын үйлчилгээ үзүүлсэн байна. | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | | Олон нийтийн цагдааг орон тоогоор ажиллуулна. | 2021-2024 | ЗДТГ | 4500 | 1 | 1 | - | 4,0 | Тус суманд олон нийтийн цагдаа ажиллуулах зар мэдээг удаа дараа хүргэж ажилласан бөгөөд 2021 онд ажиллах иргэн бүртгүүлээгүй. 2022 онд 1 иргэн ажиллахаар бүртгүүлэн 2022 онд аймгийн Цагдаагийн газарт 1 сарын сургалтад хамрагдаж, 2023 онд 7 сар хүртэл ажилласан. | 70 | |
| 3 | | Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон тээврийн хэрэгсэл саатуулах журмын хашаатай болох. | 2021-2024 | ЗДТГ | | 0 | Журмын хамшаатай болсон байна. | | | Гэмт хэрэг зөрчил холбогдсон тээврийн хэрэгслийг саатуулах журмын хашаагүй байна.Шаардлагтай тохиодолд албаны машины граш, ЗДТГ-ын хашаанд оруулж саатуулж байна. | 50 | |
| 4 | | Сумын газар нутаг дэвсгэрт салдаг замын уулзварууд, сумын төвийг тэмдэгжүүлэх. | 2021-2024 | ЗДТГ | - | | Тэмдэглэгээ 6 ш суурилуулсан байна. | | | Сумын нутаг дэвсгэрийн салдаг замын уулзвэрууддад байрласан замын тэмдэг тэмдэглэгээнүүдэд нөхөн сэргээлт хийсэн. Нийслэлийн авто замын хөгжлийн газраас 4ш замын тэмдэглэгээг авч эвдрэл ихтэй замуудад байрлуулсан. | 100 | |
| 5 | | Сумын хэмжээнд телехяналтын камер, гэрэлтүүлэггүй газарт гэрэлтүүлэг, камер суурилуулах. | 2021-2024 | ЗДТГ | | | Гэрэлтүүлэг камер суурилуулах | 20,6 | 10,0 | 2021 онд ЕБС-ийн дотор болон гадна 28 камер, Цэцэрлэг гадна болон дотор 12, сургуулийн дотуур байранд шинээр 4 , 2022 онд ЗДТГ 4, ЭМТ 8, дотуур байрны гадна талд 1 ш камер шинээр суурилуулж, гэр хороололд 21 камерыг засаж ашиглалтанд оруулсан байна.<br>2021 онд гэр хорооллын асахгүй байсан 21 ш гэрэлтүүлгийг засварлаж, 2022 | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | онд чигчий хороололд 5 ш гэрэлтүүлэг шинээр суурилуулсан. | | |
| **3.4.Гадаад харилцаа, хамтын ажиллагаа** | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| 1 | **Зорилт 1. Сумын уламжлалт гадаад харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн тэргүүлэх салбарын харилцааг хөгжүүлнэ.** | Суманд гадаадын хот, мужуудтай харилцаа тогтоох, олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай идэвхтэй ажиллагааг өрнүүлэх, эдийн засаг, нийгэм ХАА салбарт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд сумаас дэмжлэг авах. | 2021-2024 | ЗДТГ | | | | | 66,5 | 2023 онд НҮБ-ын Даян дэлхийн байгаль орчны санхүүжилтийн Жижиг төслийн хөтөлбөртэй хамтран “Нутгийн Иргэдийн Хамгаалалттай газар нутаг ба малчин менежер” төслийн “Нүүдэлч монгол ухаан төв” НҮ ТББ-ээр дамжуулан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд тус суманд байгаль хамгаалагч 3 малчны бүлэг байгуулагдан 1 булгийн эхийг хамгаалж, ашиглалтгүй болсон 1 худгийг засварлаж ашиглалтанд оруулж, малчдын бүлгийхэнд тэдний амьдарч байгаа газар нутгийн бэлчээр, бэлчээрийн ургамал,усны эх үүсвэрийг үнэлж, бэлчээрийн даац, малын тоо толгойн зохистой хэмжээг малчин хүн өөрөө нүдэн баримжааны аргаар үнэлэх хялбаршуулсан аргыг зааж сургаснаас гадна, байгальд ээлтэй аргаар орлогоо нэмэгдүүлэх арга барилд сургаж байна. Мөн дээрх төслийн хүрээнд Нутгийн Үйлс Ухаан сургалт судалгааны төв ТББайгууллагатай хамтран “Шинэ зууны малчин” хөтөлбөрт 7-11-р ангийн 30 сурагч хамрагдаж байна. Сургалтын хөтөлбөр нь сурагчдын нас, сэтгэхүйд тохирсон, биологи, эрүүл мэнд, иргэний ёс зүйн боловсрол, нийгэм судлал, хүн ба орчин судлалын хичээлүүдтэй | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | уялдсан, амьдралд ойр агуулгаар бэлтгэж, сонгон судлах байдлаар заагдах 6 үндсэн модуль сэдэв бүхий 38 багц цагаас бүрдсэн тусгай хөтөлбөрөөр 2023-2024 оны хичээлийн жилд хичээллэж байна. Сургагч багшаар И.Гүндэгмаа. Төслөөс багш болон сурагчдын гарын авлага номоор хангасан. Сургалтыг 7 хоног тутам багш зохион байгуулж үйл ажиллагааны мэдээллээ хамтран ажиллаж байгаа хүргүүлж байна.<br>Засгийн газар, ХБНГ улсын Засгийн газар хооронд байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн хүрээнд Германы Сэргээн болсголтын зээлийн банк /KFW/-аар дамжуулан Монгол орны төв, хангай, зүүн бүсийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулах, орчны бүсийн сумдын иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих зорилго бүхий “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ” төслийн II, III үе шатанд 13 аймгийн 75 сургуульд “Эко кабинет” –ын тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, байгалийн ухааны сургалтыг дэмжих багц гарын авлага, судалгааны хэрэглэгдэхүүн бүхий хөрөнгө оруулалт болон багш нарыг чадавхжуулах сургалт, үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургууль хамрагдсан.<br>1-12-р ангийн сурагчдад “Эко кабинет”-аар дамжуулан сургалт зохион байгуулах 66,5 сая төгрөг төсөвтэй төсөл хэрэгжиж байна. | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | | Японы Насу хотын ОШИМА Форумын хүүхэд солилцооны хамтын ажиллагааг үргэлжлүүлэх. | 2021-2024 | ЗДТГ | | Жил бүр хүүхэд солилцооны хөтөлбөр хэрэгжидэг уламжлалтай | Жилд 2 хүртэл хүүхдийг хүүхэд солилцооны хөтөлбөрт хамруулна. | | | Хэрэгжээгүй | | |
| **3.5.Батлан хамгаалах, гамшгаас урьдчилан сэргийлэх** | | | | | | | | | | | | |
| 1 | **Зорилт 1. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэн, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй төлөвлөгөөний дагуу сургалт, бэлтгэлийг зохион байгуулж, үүрэг гүйцэтгэх мэдлэг, дадлага олгоно. | 2021-2024 | ЗДТГ | Хөрөнгө шаардахгүй | Хууль хэрэгжиж эхэлсэн | Томилгоот нэгжүүдэд сургалт зохион байгуулсан байна. | 1,2 | 0,2 | Орон нутгийн томилгоот нэгжийг жил бүр тодотгож байна. Аймгийн цэргийн штабтай хамтран томилгоот нэгжүүдийн бэлэн байдлыг шалгаж сургалт сумын төвд зохион байгуулав. Энэ арга хэмжээнд 25 иргэн, 5 автомашин, 5 мотоцикл хамрагдав. 2022 онд Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Орон нутгийн хамгаалалтын нэгжийн анхдагч дадлага, сургуулилт”-д сумын Засаг даргын орлогч оролцсон. | 100 | |
| 2 | | Сумын дайчилгааны төлөвлөгөө болон томилгоот байгууллага, аж ахуйн нэгжийн дайчилгааны даалгаврыг шинэчлэн боловсруулж, бэлэн байдлыг хангана. | 2021-2024 | ЗДТГ | | . Хууль хэрэгжиж эхэлсэн | Томилгоот нэгж байгууллага, аж ахуй нэгжүүд дайчилгааны | 3,0 | | Сумын дайчилгааны төлөвлөгөө болон томилгоот байгууллага, аж ахуйн нэгжийн дайчилгааны даалгаврыг шинэчлэн боловсруулж батлуулан, бэлэн байдлыг хանган ажиллаж байна. | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | даалгаврын дагуу бэлэн байдлаа хангасан байна | | | | | |
| 3 | | Ерөнхий боловсролын сурагчдад цэрэг-эх оронч үзэл хандлага төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллана. | 2021-2024 | ЗДТГ | Хөрөнгө шаардахгүй | | Жилд 2-оос доошгүй удаа шинэлэг ажил зохион байгуулсан байна. | 1,5 | 0,4 | Бүрд сумаас энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцсон цэрэг дайчид офецеруудыг алдаршуулах үйл ажиллагаа мэдээлэл бэлтгэн, сум сургуулийн цахим хуудсанд байршуулав. Мөн Монгол бахархлын өдөр зориулан Бидний өвөг дээдэс Чингис хааны үүсгэн байгуулсан Их монгол улсын талаарх үзэл бодол, хандлагыг төлөвшүүлэх, түүхэн зүтгэлтэнүүдийг танин мэдэж судлаж, үндэсний түүхээрээ бахархах, эх оронч үзэл хандпагыг түгээн дэлгэрүүлэн ажиллав. 2023 онд сургуулийн ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч хүмүүжил олгох, эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх , тэдэнд бие бялдар сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил олгож, эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх, монгол цэргийн залгам халааг бэлтгэх зорилгоор 9-11-р ангийн сурагчдын дунд цэрэг спортын “ДӨЛ” тэмцээнийг амжилттай зохион байгуулж ажилласан. | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Зорилт 2. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхийг нэмэгдүүлнэ.** | Сумын гамшгийн эрсдэлийг бууруулах үнэлгээг аюулын төрөл бүрээр эрх бүхий байгууллагаар хийлгэнэ. | 2021-2024 | ЗДТГ | 10 | Эрсдлийн үнэлгээ хийлгэ эгүй | Эрсдлийн үнэлгээ хийлгэж үйл ажиллагаандаа ашиглах | 10,0 | 10,0 | Гамшгийн эрсдлийг бууруулах үнэлгээг хийлгэх хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, Уст бэлчир компанитай гэрээ байгуулж гамшгийн эрсдлийн төлөвлөгөөг хийлгүүлсэн. | 100 | |
| 2 | | Сумын гамшгаас хамгаалах иж бүрэн сургалт, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг чадавхжуулж, зарим тоног төхөөрөмжөөр хангана. | 2021-2024 | ЗДТГ | 5,0 | 4 жилд 1 удаа гамшгаас хамгаалах команд штабын сургуулилт зохион байгуулдаг, сайн дурын хэсгийг байгуулсан. | Гамшгаас хамгаалах иж бүрэн сургалт зохион байгуулж сайн дурын хэсгийг чадвахжуулсан байна. | 5,3 | 2,5 | 2022 оны 9 дугаар сарын 26-27--ны өдрүүдэд гамшгаас хамгаалах их бүрэн сургалтыг зохион байгуулсан. Дадлага сургуулийн Хархорин сумын ОБХ-ийн дарга хошууч Н.Намхайнямбуу удирдан зохион байгуулсан. команд штабын сургуульд сумын онцгой комиссын 23 гишүүнээс 18 нь хамрагдаж, 1 өдрийн танхимын сургалт, 1 өдөр нь цагийн байдал дээр ажиллан хээрийн дадлага сургуулилалт хийж сумын онцгой комисс болоод мэрэгжлиййн зориулалттай ерөнхий ангийн гишүүд гамшиг осол тохиолдсон үед хэрхэн ямар зохион байгуулалттай ажиллах талаар мэдлэг туршлагтай болсон. Команд штабын сургуулилалт амжилттай болж 92.3 хувийн үнэлгээтэй үнэлэгдсэн. | 100 | |
| 3 | | Сумын Улаан загалмайн хороотой хамтран төрийн хүмүүнлэгийн үйл | 2021-2024 | ИТХ | | Хамтран ажиллаж төсөл, хөтөлб | Жилд 1-ээс доошгүй арга хэмжээ зохион | | 15,0 | 2021 онд Аймгийн Улаан загалмайн хороонд 700,0, 2022 онд 2,022,0 мян.төгрөгийн татвар төвлөрүүлсэн байна. 2021-2023 онд Улаан загалмайн хорооноос өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан 30 өрхөд , өрх тус бүрт | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллагааг орон нутагт хэрэгжүүлнэ. | | | | өр хэрэгжүүлдэг. | байгуулсан байна. | | | 240,0 мян.төг-ийн бүгд, 7200,0 мян.төг-ийн бэлэн мөнгө, мөн эдгээр өрхүүдэд 4538,7 мян. төг-ийн малын ашигт долооц, нүдний түхлэг, туурайн тос, амин тун бэлдмэл, загасан тос зэргийг тус тус олгосон байна. 16 өрхөд хүнсний тэжээлийн багц олгосон. Хүчтэй салхи шуурганы улмаас гэр нь нурсан 1 өрхөд шинэ гэр , 14 төрлийн гал тогооны багц олгосон байна. 7 сард болсон хүчтэй борооны улмаас гэр нь нурсан 1 өрхөд хөнжил гудас, дулаан хувцасны багц ,3 иргэнд мөнгөн тусламж тус бүр 370.0 төгрөг, 431,4 мян.төгрөгний үнэ бүхий малын эрдэс тэжээл олгосон.ЕБС-ийн англи хэлний багш, Улаан загалмайн идэвхитэн гишүүн О.Буяндэлгэр багштай 6а ангийн Өсвөрийн Улаан загалмайн гишүүд Эх үрсийн баяраар байгаль дэлхийгээ баярлуулж аман булгийн ойр орчмын хогийг түүж хүмүүнлэгийн ажил өрнүүлсэн. | | |
| **БҮЛГИЙН ДУНДАЖ 38 арга хэмжээ** | | | | | | | | | | | **88,4** | |

Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолын 3б дугаар хавсралт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ /2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/**

**2024.12.03** **Бүрд**

| | ХБТББ-т тусгагдсан Зорилт, үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Нийт хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/ 2024 он | | | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | ТГ | ИТХ |
| **ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ** | | | | | | | | | | | | |
| **2.1. Санхүү, төсөв** | | | | | | | | | | | | |
| 1 | Зорилт 1. Төсвийн төлөвлөлт, хариуцлагыг сайжруулж, цахим системийг хөгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангана. | Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавина. | 2021-2024 | Төрийн 6 байгууллага | Хөрөнгө шаардахгүй | 100 | 100 | - | | Бүх төрийн байгууллагууд хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн программтай холбосноор цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавьж байна.<br>Төсвийн байгууллагуудын системд зарим сонголтын алдаа гарч байсныг тухай бүрд нь засуулах арга хэмжээ авч ажилласнаар орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтэнд бүрэн хяналт тавьж байна. | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | | Төсвийн ил тод байдлыг хангах замаар шилэн дансны мэдээлэл байршуулалтад тогтмол хяналт тавьж, хариуцлага тооцон ажиллана. | 2021-2024 | ЗДТГ-ын төрийн сангийн мэргэжилтэн | Хөрөнгө шаардахгүй | 1152 мэдээ | Жил бүр 1152 | - | | Шилэн данс мэдээлийн системд 2021 онд төсвийн 6 байгууллаган 39 мэдээ тайлан байршуулахаас 34-ийг нь хугацаанд нь, 5-ийг хугацаа хоцроож, 1-ийг огт мэдээлэлээгүй байсан. 2022 оны 11-р сарын байдлаар төсвийн 7 байгууллагын нийт 1006 мэдээлэл байршуулахаас 100 хувь байршуулсан. Үүнээс 70 мэдээлэл хугацаа хоцроож мэдээллэсэн байна. Аймгийн засаг даргын 2022 оны б/08 дугаар тушаалын дагуу Шилэн дансны тухай хуулийг зөрчсөн албан тушаалтануудад сануулах арга хэмжээ авсан. 2023 оны 12-р сарын байдлаар төсвийн 6 байгууллагын нийт 1279 мэдээлэл байршуулахаас 100 хувь байршуулсан. Үүнээс 12 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. 2024 оны 10-р сарын байдлаар төсвийн 6 байгууллагын нийт 1043 мэдээлэл байршуулахаас 100 хувь байршуулсан. Үүнээс 17 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 90 | |
| 3 | | Сум хөгжүүлэх сан, малжуулах сангаас зээл аваад хугацаа нь дууссан боловч төлөгдөөгүй, явцын хэтрэлттэй зээлүүдийг иргэд аж ахуйн нэгжээр нь бүрэн төлүүлэх, тус сангийн хөрөнгийн | 2021-2024 | ЗДТГ-ын ЖДҮ-ийн мэргэжилтэн | Хөрөнгө шаардахгүй | СХС-ийн чанаргүй зээлийн хэмжээ 30%, хот | Бүрэн барагдуулсан байна. | - | 180,0 | Хоршоо хөгжүүлэх сангаас 2 хоршоо 4 иргэнийг дэмжээд байна. 2024 оны 11 сарын байдлаар Хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 90,081,420 төгрөг, Зээлдэгчийн тоо иргэн 11, хоршоо 2, зээлийн үлдэгдэл 177,469,367 төгрөг, хэвийн 148,305,679 төгрөг, хугацаа хэтрэлттэй 29,163,688 | 90 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ашигт байдлыг сайжруулах, эргэлтэд оруулах, бодит судалгаан дээр үндэслэн Сум хөгжүүлэх сангийн зээлийг олгоно | | | | орчим, Малжуулах сангийн чанаргүй зээл 70%тай байгаа | | | | төгрөг байгаагийн явцын хугацаа хэтрэлттэй 673,406 төгрөг, гэрээний хугацаа бүрэн дууссан боловч төлөгдөөгүй байгаа 28,490,282 төгргийн зээл байна. Хууль шүүхийн байгууллагад 4 иргэний 25,022,856 төгрөг шийдүүлэхээр өгсөн байна. | | |
| 4 | | Төрийн худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа дотоодын давуу эрхийн зөрүү тооцох замаар орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ. | 2021-2020 | ЗДТГ/санхүүгийн алба | Хөрөнгө шаардахгүй | | ААН -ийг дэмжсэн байна. | - | 235,1 | 2021 онд 8 худалдан авалтаас 6 -г нь сумынхаа аж ахуйн нэгж, олон нийтийн оролцоотой бүлэгт, 2022 онд 3 худалдан авалт хийснээс 3 худалдан авалтанд орон нутгийн давуу эрх тооцож ажилласан. 2023 оны Худалдан авах ажиллагаанд төлөвлөгдсөн 2-р багт иргэний танхим байгуулах болон сумын төв доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, ногоон байгууламжийн арчилгаа, хог хаягдлыг цуглуулах зайлуулах ажилд , 2024 онд сумын төв доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, ногоон байгууламжийн арчилгаа, хог хаягдлыг цуглуулах зайлуулах ажил болон төсвийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн шинэчлэлд хөрөнгө оруулалт хийх ажлын худалдан авалтад орон нутгийн давуу эрх тооцож, орон нутгийн аж | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ахуйн нэгж шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. | | |
| 5 | | Бүх шатны худалдан авах ажиллагаанд болон түүний гүйцэтгэлийн явцад дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж, иргэд, олон нийт, ашиглагч байгууллагын зүгээс хяналт тавьж ажиллах боломжийг бүрдүүлнэ. | 2021-2024 | ЗДТГ-ын санхүүгийн алба | Хөрөнгө шаардахгүй | | Ажил бүрийн гүйцэтгэлд дотоод хяналтыг тогтмол хийсэн байна. | - | 8,0 | 2021 оны Худалдан авах ажиллагаанаас Наадмын талбайн тохижилт, хуучин халуун усны бохир, халаалтыг засварлах, Хүүхдийн тоглоомын талбайн ажлуудад, 2022 оны худалдан авах ажиллагаанаас Хүүхдийн тоглоомын талбай, Цэцэрлэгийн тоглоомын талбай, ЕБСургуулийн биеийн тамирын талбай, Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, Малын тэжээлийн ургамал тариалах тоног төхөөрөмж худалдан авах зэрэг ажлуудад, 2023 оны худалдан авах ажиллагаанаас 2-р багт иргэний танхим байгуулах, сумын төв доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, ногоон байгууламжийн арчилгаа, хог хаягдлыг цуглуулах зайлуулах ажил, сумын төвийн хогийн цэгийг хашаажуулах, СӨББ-ын гал тогооны тоног төхөөрөмж шинэчлэх, сумын төвийн ундны усны худгийн засвар, Цөлжилтийг сааруулах зорилгоор ойн зурвас байгуулах, зэрэг ажлуудад дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж, иргэд, олон нийт, ашиглагч байгууллагын зүгээс хяналт тавьж ажилласан. 2024 онд худалдан авах | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ажиллагаанаас сумын төвд 300 м хатуу хучилттай авто зам шинээр тавих ажилд зураг төсөв боловсруулсан “Ихэр Мөнх” ХХК-тай хяналтын гэрээ байгуулж хяналт тавьж ажилласан. | | |
| 1 | Зорилт 2 Төрийн болон орон нутгийн өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ | Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл, үнэлгээ, тайланг ил тод нээлттэй болгон, хөрөнгийн тооллогыг хуулийн дагуу чанартай зохион байгуулж, өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ | 2021 -2024 | ЗДТГ/төсөв, төрийн сангийн мэргэжилтэн | Хөрөнгө шаардахгүй | Хөрөнгийн бүрэн бүтэн байдал 80% | Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжсон байна. Бүрэн бүтэн байдал 100% | - | | Төсвийн байгууллагууд нь хөрөнгө тус бүрээ эзэнжүүлж картжуулж, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулж сар бүр үндсэн хөрөнгийн элэгдэл тооцож хөрөнгийн ашиглалт хамгаалалтад анхаарч ажиллаж байна. Хөрөнгийн тооллогыг хагас жилээр чанартай зохион байгуулж, өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлж ажилласан. 8-н айлын орон сууцны оршин суугчтай жил бүр түрээсийн гэрээ байгуулж ЗДТГ өөрийн орлогоо бүрдүүлж ажиллаж байна. Санхүү бүртгэлийн программаар хөрөнгийн өдөр тутмын гүйлгээг бүртгэж ажиллаж байна. Байгууллага бүр ил тод мэдээллийн самбарт хөрөнгөтэй холбоотой тайлан мэдээг нээлттэй нийтэлж ажиллаж байна. | 90 | |
| 2 | | Төсвийн хөрөнгөөр хийгдэх барилга байгууламж, бараа, ажил үйлчилгээний төсөвт жишиг үнэ нормативт хэмжээг баримтлах, хийгдсэн ажлын чанарт хяналт | 2021 - 2024 | ЗДТГ-ын санхүүгийн алба | Хөрөнгө шаардахгүй | Зарим ажил үйлчилгээ төсөвт өртгийг тооцоо | Бүх ажил үйлчилгээний төсөвт өртгийг тооцож | - | - | Төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа барилга байгууламж, бараа, ажил үйлчилгээ хийлгэхдээ барилга байгууламжийн хувьд мэргэшсэн төсөвчнөөр, барааны хувьд зах зээлийн үнийг судлан батлуулж ажиллаж байна. 2021 онд Наадмын талбайн | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тавьж, чанаргүй гүйцэтгэсний улмаас үүссэн хохирлыг нөхөн барагдуулна. | | | | лолт 70% | баталгуужуулсан байх<br><br>100% | | | тохижилтын ажил, 2022 онд 2-р багт иргэний танхим байгуулах, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах худаг шинээр барих, малын тэжээлийн ургамал тариалах тоног төхөөрөмж худалдан авах, 2023 онд сумын төвийн хогийн цэгийг хашаажуулах болон 3-р багт иргэний танхим байгуулах 2024 онд сумын төвд 300м хатуу хучилттай авто зам шинээр тавих зэрэг бүтээн байгуулалтын ажлуудад мэргэжлийн төсөвчнөөр зураг төсөв хийлгэж ажилласан. Хийгдсэн ажлын чанарт Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, ИТХ-ын ажлын хэсгүүд хяналт тавьж байна.<br>“Ахуй үйлчилгээний барилгын урсгал засвар”-ын ажлыг гүйцэтгэх 4,800.0 мян төгрөгийн гэрээг иргэн Б.Оюунгуатай 2023 оны 6-р сарын 6-ны өдөр байгуулсан. Гэрээнд ажил гүйцэтгэх дуусах хугацааг 1 сарын хугацаатай буюу 2023 оны 7-р сарын 6-ны дотор хүлээлгэж өгөхөөр тусгасан боловч гэрээний үүргээ зөрчиж одоог болтол ажлаа хүлээлгэж өгөөгүй байна. Тухайн урсгал засварын ажлыг техникийн тодорхойлолтын дагуу чанартай гүйцэтгэж хүлээлгэж өгөх мэдэгдлийг удаа дараа хүргүүлсэн боловч одоо болтол шаардлага биелүүлээгүй тул албадлагын арга хэмжээ авч ажиллаж байна. | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | “Өрнөх мэргэн” ХХК нь сумын бизнес хөгжлийн төвийн их засварын ажлын тендерийг авч 2020 оны 10 дугаар сарын 29-ны өдөр 37,673,976 төгрөгийн гэрээ байгуулж гүйцэтгэхээр болсон. 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр 30,000,000 төгрөг, 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр 6,000,000 төгрөг нийт 36,000,000 санхүүжилт авсан байна. Гэрээнд зааснаар дээрх ажлыг 2020 оны 12 дугаар сарын 15-нд ашиглалтад оруулах байсан боловч одоог болтол хүлээлгэж өгөөгүй 4 жил гаруй болж байна. Захиалагч байгууллагын зүгээс 2023.02.14–ны өдрийн 1/46 албан тоотоор мэдэгдэл хүргүүлж гүйцэтгэгч байгууллагаас албан тоотын хариу мэдэгдлийг 2023.03.22-ны өдрийн 01/23 албан тоотод 2023 оны 7-р сардаа багтааж хүлээлгэж өгөхөөр заасан байдаг. Цаашид төрийн худалдан авах ажиллагааны хар жагсаалтад оруулах, хуульд заасны дагуу шүүхэд хандаж ажиллах зэрэг шат дараалсан арга хэмжээг авч ажиллаж байна. | | |
| 3 | | Төсөвт байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулж, тогтмолжуулна. | 2021 - 2024 | ЗДТГ/ байгууллагууды н ня-бо, төсөв, төрийн сангийн | Хөрөнгө шаардахгүй | 70% | 100% | - | - | Төсөвт байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжиж жилдээ доод тал нь 2 удаа хөрөнгийн тооллого хийж өмч хамгааллын асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэргэжилтэн | | | | | | | | |
| 4 | | Жил бүр санхүүчдийн баярын өдрөөр “Хуримтлалтай иргэн” аяныг зохион байгуулж суманд үйл ажиллагаа явуулж буй арилжааны хамтран сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.банкууд болон бусад байгууллагуудтай хамтран сургалт сурчилгааны ажил зохион байгуулна | 2021 - 2024 | ЗДТГ-ын санхүүгийн алба | ААН-ийн хөрөнгө | Жилд 2 удаа сургалт зохион байгуулдаг | 2 | - | - | 2021 онд Төрийн банкны салбар Хуримтлалын өдрийг тохиолдуулан ЕБС-ийн 11, 12 ангийн сурагчдад “Хуримтлалын ач холбогдол” сэдвээр сургалт хийсэн.<br>2022 онд ХААН банк 12-р анги төгсөгчдөд хуримтлал сэдвээр 1 цагийн сургалт хийсэн. Сургалтаар хэрхэн хуримтлалтай болох бэлэн мөнгийг хэрхэн ариг гамтай авч явах санхүүгийн боловсрол гэж юу болох талаар мэдээлэл хүргэсэн. Мөн аж ахуйн нэгж байгууллагууд дээр цахим банкны ашиглалтын талаар нээлттэй өдөрлөг зохион ажиллаж байна.<br>2023 онд Төрийн болон ХААН банк нь өндөр настан тэтгэвэр авагчдад зориулж тэтгэврийн карт болон цахим банкийг үнэ төлбөргүйгээр холбож өгч байгаа. Сумын бүх дэлгүүр үйлчилгээний байгууллагуудыг карт уншигч ПОС төхөөрөмжөөр хангасан .<br>2 арилжааны банк “Дэлхийн мөнгөний 7 хоног” аяны хүрээнд ажлын байрандаа үйлчлүүлж байгаа харилцагчдад мэдээлэл өгч хуримтлал татаж ажилласан.<br>2024 онд Төрийн банк нь улирал бүр ЕБС-ийн нийт 120 сурагчдын дунд санхүүгийн боловсрол олгох сургалт амжилттай зохион байгуулсан. | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Дундаж давхаргыг дэмжих зорилтын хүрээнд сумын бизнес эрхлэгчдэд “Өрхийн төсвөө хэрхэн төлөвлөх зарцуулах” сэдвээр сургалт зохион байгуулсан.<br>ХААН банк нь “Дэлхийн хуримтлалын өдөр-2024” уриа дор ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад “Зорилготой хуримтлуулъя” сэдвээр сургалт зохион байгуулсан. | | |
| 5 | | Төсөвт байгууллагуудын эзэмшиж буй түрээслэх боломжтой хөрөнгийг иргэн аж ахуйн нэгжид түрээслэх замаар эзэмшүүлж өөрийн орлогыг нэмэгдүүлэх. | 2021 - 2024 | ЗДТГ-ын санхүүгийн алба | Орон нутгийн төсөв | Төлөвлөгөө 100 % биелэдэг. | Өөрийн орлогын төлөвлөгөө 100% биелэсэн байна. | | | ЗДТГазар 8 айлын орон сууцыг бусдад түрээслүүлэх, буудлын орлого, архивын үйлчилгээний орлогоос өөрийн орлогын төлөвлөгөөг бүрдүүлэн ажиллаж байна. Өөрийн орлогын төлөвлөгөө жил бүр 100-аас дээш хувиар биелж байна. 2024 оны 11-р сарын байдлаар өөрийн орлогын төлөвлөгөөнд 2,600.0 мян/төг төвлөрүүлэхээс 2,757.0 мян/төг төвлөрүүлж 106% гүйцэтгэлтэй. Цаашид өөрийн орлогоо нэмэгдүүлэхийн тул өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмжөө түрээслэх замаар иргэн аж ахуй нэгжтэй гэрээ байгуулж ажиллана. Соёлын төв нь өөрийн эзэмшлийн байраа үзвэр үйлчилгээ болон худалдаа үйлчилгээний зориулалтаар түрээслэх замаар 2023 онд 964.0 мян, 2024 онд 590.0 мян төгрөгийн орлого олж үйл ажиллагаандаа зарцуулсан. | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Зорилт 3. Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулж, татварын үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэнэ. | Татвар төлөгчдийн эрх зүйн мэдлэг, татварын багц хуулийн шинэчлэлийг таниулж, татвар төлөх сэтгэлгээ хандлагыг өөрчлөн, заавар, зөвлөгөө, сургалтыг тогтмол зохион байгуулна. | Жил бүр | Сумын Татварын хэлтэс | Хөрөнгө шаардахгүй | | татвар төлөгчдөд зөвлөгөө мэдээллийг тогтмол өгөх, Шинээр бүртгэгдсэн татвар төлөгчдөд хууль тогтоомж болон татварын хуулийг хэрэгжүүлээгүйгээс гарах эрсдэлийн талаар сургалт зохион байгуулн. Сургалтад шинээр бүртгэгдсэн татвар төлөгчийг 100 хувь хамруулсан байна. Татварын жил, улирлын тайлан хоцроодог, татварын ногдолоо хугацаанд нь төлж хэвшээгүй татвар төлөгчдөд сургалт зохион | - | - | Цахим болон зүүм сургалт аудио хичээлүүдэд сумын татвар төлөгч 15 иргэнийг, хялбаршуулсан горимоор тайлан гаргах ЗҮҮМ сургалтанд 12 ААН, иргэний төлөөлөл, ХХОАТ-ын зүүм сургалтад сумын төсөвт байгууллагын бүх албан хаагчдаа оролцуулсан. Мөн малын тоо, толгойн албан татварын талаарх хурлын тогтоол, зурагт мэдээллийг бэлтгэн сумын пэйж хуудас, цахим сайтад тавьсан. ХҮЙС НУТГИЙН БИЗНЕС ЭРХЛЭГЧИД гэсэн фэйсбүүк групп нээж бизнес эрхэлдэг 16 иргэнийг урьж оруулан татвартай холбоотой мэдээ, мэдээллийг тус группээр дамжуулан өгч байгаагаас гадна Татвар төлөгчдийн өдрүүдийн хүрээнд баримтаа аваарай аянд нэгдэж татвар төлөгчид, бизнес эрхлэгчийг хамруулсан бичлэгийг хийж цахимд түгээсэн. Багийн ИНХ-уудаар малчдад Малын тоо, толгойн албан татварын талаар зөвлөгөө мэдээлэл өгч гарын авлага тараан төлөх мөнгөн дүн нэхэмжлэхийн дугаар, ашиглагдахгүй байгаа тээврийн хэрэгслийн талаар болон бусад татвар төлбөр хураамжуудын талаар мэдээлэл өгч ажилласан. Ирээдүйн татвар төлөгч 50 хүүхдэд татварын тухай ойлголт | 100 | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулсан байна. | | | өгч ТАЗИ апп ашиглан зөгий будуулж мэдээллийг хариуцсан байцаагчид хүргүүлэн цахимд сурталчилж ажилласан. Татварын хэлтсээс эмхлэн гаргасан Өвөрхангай мэдээ сонины шинэ дугаарыг хүртээмжийн дагуу баг, байгууллагын дарга эрхлэгч нар, хөдөөгийн иргэдэд түгээж ажилласан. Татвар төлөгчдийн өдрүүдийн хүрээнд “Цахим татварын ач тус” гар зургийн уралдааныг 3 насны ангиллаар зохион байгуулж 1 дүгээр шатанд амжилттай оролцсон хүүхдүүдэд Талархал гарын бэлэг гардуулсан. Мөн татварын тайлангаа хугацаандаа гаргаж ногдсон татвараа хуулийн хугацаандаа төлдөг шилдэг татвар төлөгч 1 иргэн, 1 Аж ахуй нэгжийг шалгаруулж Шагнаж урамжуулсан. ЕБС-ийн 7, 9 дүгээр ангийн сурагчдад татвар бидний амьдралд сургалт зохион байгуулж 46 хүүхэд хамрагдсан. "Та баримтаа авсан" аяны хүрээнд ЕБС-ийн сурагчид болон Төрийн албан хаагчдаар уриалгыг хэлүүлэн цахим орчинд тавьж сурталчилж ажилласан.<br><br>2023 онд хүнсний 8 нэрийн дэлгүүр, Шатахуун түгээх станц худалдан авч шинэ татвар төлөгчөөр бүртгүүлсэн 2 иргэнд | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | жилд төлөх албан татварууд, сар улирал хагас бүтэн жилээр гаргах тайлангийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Татвар төлөгчдийн өдрүүдийн хүрээнд “Татварын ач тус” сургалтыг бага ангийн 33, Татвар бидний амьдралд” сургалтыг дунд ангийн 27, “Татвар бидний ирээдүй” сургалтыг ахлах ангийн 18 сурагчид хийсэн. Мөн суманд үйл ажиллагаа явуулж буй дэлгүүр, ШТСтанц, мал эмнэлэг зэрэг 10 ААН-ээр орж төлбөрийн баримт олголтыг шалган төлбөрийн баримт олгоогүй, тайлан мэдээ хоцроосноор гарч болох эрсдэл, татварын хяналт шалгалт, хариуцлагын талаар мэдээлэл өгсөн. 05-р сарын 20-27ны өдрүүдэд болсон багийн хурлуудад явж малын тоо, толгойн албан татварын талаар мэдээлэл өгч 2021,2022 оноо төлөөгүй иргэдийн дансыг битүүмжлэх цаашид шат дараалсан арга хэмжээ авдаг талаар сургалт хийж нийт 86 хүн хамрагдсан байна. Өвөрхангай аймгийн татварын хэлтэс, Монголын татварын алба пэйж хуудсанд тавигдсан 26 мэдээллийг сумын хандалт ихтэй группүүдэд шэйр хийж түгээсэн байна. | | |

<table>
<tr><td>2</td><td rowspan="2"></td><td>Төсөвт бүрдүүлэх орлогыг төрөл тус бүрээр жигд хангаж биелүүлнэ.</td><td>Жил бүр</td><td>Татварын хэлтэс</td><td>Үйл ажиллагааны орлогоор</td><td>Орлогын төлөвлөгөө нэр төрлөөрөө бүрэн биелэлтэй байдаг.</td><td>-нэр төрлөөрнь 100% биелүүлсэн байх</td><td></td><td>-</td><td>Татварын орлогын төлөвлөгөөний биелэлт оноор, хувиар, /дэлгэрэнгүйг хавсаралтаас үзэх /
<table>
<tr><td>он</td><td>2021</td><td>2022</td><td>2023</td><td>20</td></tr>
<tr><td>Орон нутаг</td><td>512</td><td>111</td><td>99</td><td>90</td></tr>
<tr><td>Аймаг</td><td>112</td><td>109</td><td>102</td><td>10</td></tr>
<tr><td>Улс</td><td>123</td><td>68</td><td>138</td><td>82</td></tr>
</table></td><td>100</td><td></td></tr>
<tr><td>3</td><td>Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүд, тэдгээрийн салбар компаниудыг орон нутгийн татварын албанд бүртгэлтэй болгон, татварын бааз суурийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч,төсвийн орлогыг нэмэгдүүлэх</td><td>2021-2024</td><td>Татварын байцаагч</td><td>Орон нутгийн төсөв</td><td>2021 оны жилийн эцэст: Улс, аймаг, Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлт 102%</td><td>10 аж ахуйн нэг</td><td></td><td></td><td>Суманд үйл ажиллагаа явуулж буй Чингэлтэй дүүрэгт бүртгэлтэй байсан “Бүрд гурван болор” ХХК-ийг шилжүүлэн авч бүртгэсэн. Тус аж ахуй нэгж Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлснээр сумын НӨАТ суутган төлөгчийн тоо нэмэгдэж ААНОАТ-ын болон НӨАТ-ын татварт хамрагдаж улсын төсвийн орлогын бааз нэмэгдээд байна. Мөн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 3 жуулчны бааз /Баянговь, Степиндимсе, Шинэ дэлхий/ Газрын төлбөр, хог хаягдлын хураамж, усны тлбөр зэрэг татварууд суманд төлж байна. Суманд үйл ажиллагаа явуулдаг Баруун боригдой ХХК, Өлгий ээж ХХК шилжиж ирснээр төвлөрсөн төсвийн орлого тодорхой хувиар нэмэгдэж тус 2 ААН 3165.2мян төгрөгийн татвар төлөөд байна. Цахим төлбөрийн</td><td>90</td><td></td></tr>
</table>

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | баримтын поссын байршлыг нягтлах ажлын хүрээнд поссын байршил нь Архангай, Чингэлтэй дүүрэгт бүртгэлтэй байсан 2 дэлгүүрийн байршлыг зассанаар ААНОАТ-ын тухай хуулийн дагуу төлсөн татварын 40% орон нутагт орох нөхцөл бүрдсэн. | | |
| 4 | | Иргэдийн татвар даатгалын талаарх эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, ач холбогдлын сурталчлан таниулах. | 2021-2024 | Татварын байцаагч | Орон нутгийн төсөв | | Иргэдэд татварын эрх зүйн зөвөлгөө мэдээлэл хүргэсэн байх | - | - | Ковид-ын нөхцөл байдалтай холбогдуулан татвар төлөгч иргэдийн эрхзүйн мэдлэгийг нэмэгдүүлэх татвар төлөх сэтгэлгээ хандлагыг өөрчлөх 3 удаагийн цахим сургалтад сумын татвар төлөгч иргэд, Аж ахуй нэгжүүдийн төлөөллүүдийг хамруулсан. Мөн цахим орчинд Татварын ерөнхий газар, Өвөрхангай Татварын хэлтэс пэйж хуудсуудаар дамжуулан мэдээ, мэдээллүүдийг тухай бүрт хүргэж байна. | 90 | |
| **2.2. Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа үйлчилгээ** | | | | | | | | | | | | |
| 1 | Зорилт 1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт шилжүүлэх бодлого баримталж, бэлчээр | Үржлийн нэгж байгуулж хөнгөлөлтэй зээл төсөл хөтөлбөрт хамруулах | 2021-2024 | ЗДТГ/ Маа-н асуудал хариуцсан мэргэжилтэн/ | 15 сая | Үржлийн нэгж байхгүй | 2 үржлийн нэгж байгуулагдаж үйл ажиллагаа нь жигдэрс | - | - | Малын генетик нөөцийн хуулийн хэрэгжилтийн дагуу 2024 онд Номун тайван мал үржлийн нэгж суманд үйл ажиллагаа явуулах эрхээ авсан. 200 адууны хавар намрын ангилалтын ажлыг хамтран хийж гүйцэтгэж дуусгасан. | 30 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ашиглалтыг нэмэгдүүлэн, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй болон туслах аж ахуйг хөгжүүлж хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг хангана | | | | | | эн байна. | | | | | |
| 2 | | Цөм сүргийн малыг бий болгож, үржлийн хээлтүүлэгч ,хээлтэгч малд ангилалт явуулж, мал сүргийг даатгалд хамруулах ажлыг зохион байгуулна | 2021-2024 | ЗДТГ/ Маа-н асуудал хариуцсан мэргэжилтэн/ | ААН-ийн хөрөнгө 10 сая | 1028 хээлтүүлэгч мал байна | 1750 хээлтүүлэгчтэй болж хээлтүүлэгийн тохирго онд барьж үзлэг ангилалт явуулна | | 300,00 | Батхаан хэвшлийн хонин сүргийг бий болгох сайжруулах зорилгоор, баяд, барга, хээлтүүлэгчээр сайжруулан, нутгийн цөм сүргийн хээлтэгч, хээлтүүлэгчийг бий болгоод байна. 2021 онд 69 малчин өрхийн 6780 толгой мал , 2022 онд 126 малчин өрхийн 11280 толгой мал , 2023 онд 129 малчин өрхийн 21209 толгой мал, 2024 онд 98 малчин өрхийн 56901толгой мал даатгалд хамрагдсан байна. 2022-2023 оны өвөлжилт хаваржилтад сумын малын зүй бус хорогдол 6.03% хүрч 113 малчин өрх 6 сая төгрөгийн нөхөн олговорыг даатгалаас олгоод байна. 2023 онд 5 суурийн 1180 толгой богийн хээлтүүлэгчийг эзэмгжүүлэн намрын асстечилал, ангилтад хамруулж, үржилд тэнцэхгүй 221 хээлтүүлэгчийг үржлээс хасах, заазлах, дутуу байгаа 402 хээлтүүлэгчийг нөхөх худалдан авах ажлыг зохион байгуулж 180 өсвөр хээлтүүлэгчийг нөхөн авч үржилд ашигласан. | 100 | |
| 3 | | Өсвөр хээлтүүлэгч төсөл”-ийг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ЗДТГ/ Маа-н асуудал хариуцс | Орон нутгийн төсөв | 0 | Төслийг хэрэгжүүлсэн байна | - | 20 сая | 2021 онд 20 толгой барга өсвөр хээлтүүлэгчийг Дорнод аймгийн Хөлөнбуйр сумаас худалдан авч эхний жил өнжөөн 2022 оны намраас үржилд ашиглаж 2023 | 70 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ан мэргэжилтэн/ | 65 сая | | | | | оны хавраас гарсан төлөөс шилэн сонголт явуулж, 50 толгой өсвөр хээлтүүлэгчийг сонгон авч үржилд худалдаан малчид, иргэд борлуулаад байна. 2024 онд өмнөх жилүүдэд худалдаж авсан хуцныхаа төлөөс 50 толгой өсвөр хээлтүүлэгчийг сонгон авч үржилд худалдан борлуулсан. | | |
| 4 | | Бяруу, хурга ишгийг уламжлалт аргаар хөнгөлөхөөс татгалзаж цахилгаан долгионы болон хавчих, битүү аргаар хөнгөлөх аргыг мал аж ахуйн салбарт нэвтрүүлэх | 2021-2024 | ЗДТГ/ Маа-н асуудал хариуцсан мэргэжилтэн/ | Иргэдийн хөрөнгө | | өссөн дүнгээр 1700-аас доошгүй бяруу хурга ишгийг хөнгөлсөн байна | 30,0 | - | Цахилгаан долгионы аргаар 2022 онд 150 бяруу 300 хурга , 2023 онд 550 бяруу 1200 хурга ,2024 онд 300 бяруу 200 хурга хөнгөлж зах зээлд борлуулахад бярууны махны гарц дунджаар 24-42% нэмэгдсэн ба хурганы гулуузны гарц 17-26% иар нэмэгдэж нэг малаас авах ашиг шимийг богино хугацаанд нэмэгдүүлсэн. | 100 | |
| 5 | | Мал сүргийг бэлчээрийн даацад тулгуурлан сүргийн тоо толгойг зохистой хэмжээнд барьж, Үхэр сүргийг мах- сүүний Сэлэнгэ үүлдрээр, Хонин сүргийг мах-ноосний Бүдүүвтэр ноост Баяд, үзэмчин, мах-өөхний Эдилбай үүлдрээр ,Ямаан сүргийг ноолуурын чиглэлийн Эрчимийн | 2021-2024 | ЗДТГ/ Маа-н асуудал хариуцсан мэргэжилтэн/ | Иргэдийн хөрөнгөөр | Огт хийгдээгүй | Өссөн дүнгээр 45 бух, 65 хуц, 30 ухна , 1 гахай, 1 тахианы аа | 62,5 | - | 2022-2024 онуудад бэлчээрийн даацад тохируулан эр сувай малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хээлтүүлгийн тохиргоог зөв бүрдүүлэн явуулах зорилгоор Үхэр сүрэгт Сэлэнгэ Орхонтуул, Сант, сумдаас 21 бух, Увс аймгийн Сагил сумаас баяд үүлдрийн 20 өсвөр хээлтүүлэгч, ямаан сүрэгт баяндэлгэрийн улаан хээлтүүлэгч 21 тус тус малчдад зуучлан малынхаа чанарт анхааран ажилсан. 2022-2024 онд ӨВ ЭКО МИЙТ ХХК амьдаар 4200 толгой хонь, 6600 | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хар, Баяндэлгэрийн улаанаар сайжруулах. | | | | | | | | толгой хонь махаар борлуулалт хийгээд байна. | | |
| 6 | | Хээлтүүлэгч малыг бүрэн эзэмгжүүлэн удам гарвал ашиг шимийн чиглэлээр бүртгэлжүүлэх, сумын хяналтан дор маллуулах, үржилд тэнцэхгүйг заазлах, үржлээс хасах, сүрэг сэлбэх ажлыг зохион байгуулах. | 2021-2024 | ЗДТГ/ Маа-н асуудал хариуцсан мэргэжилтэн/ | Малчид, ОНХС | 400 хуц 130 ухна эзэмгжүүлсэн | Хуц, ухна , бухыг эзэмгжүүлэн бүртгэлжүүлэх 100% | 42,0 | 6,0 | 2022 онд 2 удаа хавар намрын технологит хугацаанд эзэмгжүүлтэд 200 хуц 150 ухныг эзэмгжүүлсэн 2023 онд Мал бүртгэлийн MLIS праграмм нэвтэрч богийн 1200 хээлтүүлэгчийг эзэмгжүүлэн бүртгэл мэдээллийн нэгдсэн бааз үүсгэн ажиллаж байна. 2023 оноос богийн хээлтүүлэгчийг сумын улсын мал үржлийн улсын байцаагчийн хяналтан дор багийн ИНХ-аар дэмжигдсэн малчнаар маллуулж байна. 2024 онд 2 удаа хавар намрын технилогот хугацаанд эзэмгжүүлтэд 50 хуц 60 ухныг эзэмгжүүлсэн 2024 онд Мал бүртгэлийн MLIS праграмм нэвтэрч богийн 1600 хээлтүүлэгчийг эзэмгжүүлэн бүртгэл мэдээллийн нэгдсэн бааз үүсгэн ажиллаж байна. 2024 оноос богийн хээлтүүлэгчийг сумын улсын мал үржлийн улсын байцаагчийн хяналтан дор багийн ИНХ-аар дэмжигдсэн малчнаар маллуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | | Богийн төлийг 08 дугаар сарын 01-ний дотор эхээс ялгаж дундаас дээш тарга хүч авахуулж өвөлжилтөнд бэлтгэх. | 2021-2024 | ЗДТГ/ Маа-н асуудал хариуцсан мэргэжилтэн/ | Иргэд, малчид | 50 хувь | 80 хувьд хүргэх | | | 2022 онд 40% намрын технологит хугацаанд богийн төлийг эхээс ялган дундаас дээш тарга хүч авахуулсан 2023 – 2024 онд зуншлага ногооны гарц сайн гарсан тул нийт малчдын 90-98% богийн төлийг эхээс ялган дундаас дээш тарга хүч авхуулж дундаас доош тарга хүчтэй зах зээлд борлуулан өвөлжилтийн бэлтгэл ажлыг 96% хангаад байна. | 100 | |
| 8 | | Гойд ашиг шимт мал болон өрхийн үйлдвэрлэгч ,хүнсний ногоо, цагаан идээний үзэсгэлэн худалдаа, дуудлага худалдааг “Намрын ногоон өдрүүд” нэртэйгээр зохион байгуулж малчид иргэд аж ахуйн нэгжүүдийг уриалан жил бүр тогтмол зохион байгуулах. | 2021-2024 | ЗДТГ/ Маа-н асуудал хариуцсан мэргэжилтэн/ | Орон нутгийн төсөв<br>Иргэд<br>ААН эрхлэгчид | Энэ арга хэмжээг зохион байгуулдаг. | аж ахуй эрхлэгчид, малчдыг өргөнөөр оролцуулах | 6,0 | 7,4 | 2022-2024 онд Намрын ногоон өдрүүд арга хэмжээг тогтмол зохион байгуулаж дараах номинациудаар шилдэгүүдээ шалгаруулсан. 2023 онд Шилдэг хөхүүртэй багаар Их боригдой 2 –р баг шалгарсан Өв түншлэл арга хэмжээнд 3–р багийн малчин Г.Буманбаярын зээрд халзан азарга 3-р байр Г.Батбямбын барга үүлдрийн улаан хүзүүт хуц 3-р байр , Их боригдой 2 –р багийн малчин Ч.Сайнбатын улаан ухна тусгай байр сумын дүнгээрээ 2 –р байр, 2024 онд Шилдэг Бүтээгдэхүүнээр 4-р багийн иргэн З.Хишигнямын үйлдвэрлэсэн цагаан идээ , Шилдэг айргаар 4-р багийн иргэн Ш.Батбаатар, Шилдэг хүнсний ногоогоор 4-р багийн иргэн Д.Уртнасан Шилдэг оёмол бүтээгдэхүүнээр 5-р багийн иргэн Ж.Ариунтөгөлдөр, Шилдэг | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | гар урлалаар Бага ангийн багш З.Гандулам, азарганы төрөлд 3-р багийн иргэн Г.Буманбаярын зээрд халзан, Шилдэг гүүгээр 5-р багийн иргэн Д.Мөнхбаярын хүрэн, Дэмбээний тэмцээний төрөлд Ш.Батбаатар, Айраг уух тэмцээнд “-р багийн иргэн Б.Алтансүх нар шалгарсан байна. өргөн дэлгэр зохион байгуулагдсан. | | |
| 9 | | Эрчимжсэн аж ахуйг дэмжиж, цэвэр эрлийз малын тоо толгойг нэмэгдүүлэх, туслах аж ахуйг бий болгох | 2021-2024 | ЗДТГ/ Маа-н асуудал хариуцсан мэргэжилтэн // | Иргэдийн хөрөнгө ААН, иргэдийн хөрөнгө | | малын тоо 268 мянган толгойгоос хэтрэхгүй болж 1 гахайаа-1, тахианы аа 1-тэй болсон байна | 45,0 | 657,0 | 2023 онд Хоршоо хөгжүүлэх сангаас 2 иргэн 1 аж ахуйн нэгжид 90 сая төгрөгийн зээл олгосон. 1 иргэн гахай аж ахуй , 6 иргэн хагас эрчимжүүлсэн саалийн үнээний аж ахуй эрхлэж өрхийнхөө хэрэгцээнд хэрэглэж байна. Цэвэр эрлийз малын 22001 тоо толгой сүүлийн жилүүдэд нэмэгдэж түүнээс авах малчдын ашиг орлого нэмэгдэж байна.<br>2024 онд Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд Мал аж ахуйгаа сайжруулах чиглэлээр арилжааны 2 банкаар дамжуулан 5 хоршоо буюу 20 гаруй өрх 567 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан байна. | 100 | |
| 10 | | Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх чиглэлээр тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийг дэмжинэ. | 2021-2024 | ЗДТГ/ Маа-н асуудал хариуцсан мэргэжилтэн/ | | | 3 иргэн 1 ААН | - | - | 2022-2024 ондууд нийт малчдын 96 % хувь нь зөөврийн хашаатай, 43% хувь нь зөөврийн воганчиктэй, 47% адууны байршил тогтоогч GPS-тэй болсон байна. 2024 онд байгуулагдсан Тогилын өгөөж, Өсөх Хос Заяа | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Зул, Элст цохио, Хүрдэт ухаа, Отоны буян хоршоо нь 567 сая төгрөгийн хөнгөлөттэй зээлээр хөдөлмөр хөнгөвчлөх тоног төхөөрөмж болох хашаа, бага оврын трактор зэргээр хөрөнгө оруулалт хийгээд байна. | | |
| 11 | | Цөөн малтай болон залуу малчдыг малжуулах төсөл хөтөлбөрт хамруулах | 2022-2024 | | Малчид Орон нутгийн төсөв хөтөлбөр | | 6 иргэн | 30,0 | 121,0 | 2023 онд малжуулах төсөлд 5 малчныг хамруулан 25 сая төгрөгийн малаар малжуулсан. Үүнд.1- р баг Н.Алтанхуягт 67 толгой , 2-р Ц.Уугангэрэлд 65 толгой, 3-р Л.Сундуйд 68 толгой ,Ц.Батбаярт 66 толгой , Ганбаатарт 67 толгой баг мал олгосон байна. 2024 онд малжуулах төсөлд 12 малчныг хамруулан 96 сая төгрөгийн малыг худалдан авч өгсөн байна. 1- р багийн Э.Болдод 72 толгой бог, 2 тугалтай үнээ, Н.Хатанбаатарт 101 толгой бог, Н.Батжаргалд 98 толгой бог, 2-р багийн С.Мөнхөөд 96 толгой бог, Б.Батгэрэлд 98 толгой бог, 3-р баг Б.Алтанбаганад 71 бог 2 тугалтай үнээ, Содномпилд 97 толгой бог, Р..Өлзийсайханд 96 толгой бог, 4-р баг Ш.Төмөрбаатарт 99 толгой бог, 5-р баг РСанжаахоролд 76 толгой бог 2 тугалтай үнээгээр тус тус малжуулсан байна. | 100 | |
| 1 | Зорилт 2. Газар | Боригдойн усалгаатай талбайд төмс хүнсний | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, | Орон нутаг | 2013 онд | Их боригдо | | | 2021 онд төмс 8га-д тариалж 96тн, хүнсний ногоо 8га-д тариалж 70тн | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тариалангийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, шинэ нэр төрлийн таримлыг тариалах замаар импортын хэрэглээг бууруулж, сумын хэрэгцээг хангах | ногоо тариалах иргэдэд газрыг ашиглалтын гэрээгээр олгож, тариалалтыг нэмэгдүүлнэ. | | газар тариалан хариуцсан мэргэжилтэн | Иргэдийн хөрөнгөөр | усалгатай газар тариалангийн тоног төхөөрөмжтэй болсон | йн 30 га-г 100 хувь ашиглах | | | нийт 2 аж ахуйн нэгж, 30гаруй иргэн тариалалт хийсэн байна.<br>2022 онд нарийн ногооны үрийн дэмжлэг үзүүлж 32 айл өрхүүдэд 70%-ийн хөнгөлөлтэй үнээр үр тараасан. Төмс 2 га, байцаа 0,2га, шар лууван 0,2га, шар манжин 0,2га, хүрэн манжин 0,3га, сонгино 0,1га, саримс 0,1га, хэмх 0,2га, лооль 01га, тарвас 0,1га, бусад 0,1га, навчит ногоо 0,2га-д тариалсан. Үүнээс нийт хураасан ургац 4,2тн төмс,байцаа-1тн, шар лууван 0,4тн, шар манжин 0,5тн, хүрэн манжин 0,5тн, сонгино 0,3тн, саримс 0,3тн, хэмх 0,5тн, лооль 0,1тн, тарвас 0,2тн,бусад 0,2 тн навчит ногоо 0,2тн байна. 3 гэр бүл төмс хүнсний ногоо тариалсан байна.<br>2023 онд Боригдойн хашаажуулалтанд тохиролцоонд хүрч чадаагүйн улмаас нэгдсэн хүнсний ногооны тариалалт хийгдээгүй. Иргэд өөрсдийн нөөц бололцоог дайчлан 0,3 га-д төмс тарисан байна.<br>2024 онд төмс 8га-д тариалж 80 тн ургац авсан байна. Хүнсний ногоо 4,15 га-д үүнд байцаа 0.2 га, шар лууван 0,3 шар манжин 1,3 га, хүрэн манжин 1,3 га, сонгино 0,5 га, саримс 0,3 га, хэмх 0,2 га, лооль 0,01 га, чинжүү 0,003 га, навчит 0,01 га-д тариалж 39,45 тн ургац хураан авсан байна. Малын тэжээлийн ургамал 180 га-аас 300 тн-ийг хураан авсан. | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | | Боригдойн тариалангийн талбайн хашааг сэлбэж, услалтын системийг засварлаж усалгаатай тариаланг хөгжүүлнэ. | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн | Улс, орон нутгийн төсөв Иргэдийн хөрөнгөөр | Усалгаатай газар тариалан хөгжөөгүй | 100% ашиглах | 27 | | Боригдойн услалтын системийн ус хаях хэсэг, хажуу хана,ус юүлэх хэсгийг засах, ус хаях хэсгийн эхлэл лайдсан,бетон доторлогоо эвдэрсэн, бороожуулагч машины цахилгаан холболт тоногдсон, удирдлагын самбар, бороожуулагчийн дугуйтай болгох, ил усалгааны Ф300 мм хаалт хөлдөж хагарсан учир солих, юүлэх болон хаях хоолой булагдаж дарагдсаныг засварлах зураг төсөв хийлгэхэд 27,0 сая хэрэгтэй болоод байна. 2024 онд Боригдойн тариалангийн талбайд 4 иргэн өөрсдийн хөрөнгөөр 2 хэсэгт хашаажуулалтыг 15-16 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шийдэж, 10 га талбайд төмс, 10 гаруй төрлийн мод тариалсан. | 50 | |
| 3 | | Боригдойн атаршсан талбайг эргэлтэнд оруулж малын тэжээл, олон наст ургамал тариалж, өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ. | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн | Иргэдийн хөрөнгөөр | 0 | 1000 га газрыг ашигласан байна. | | ,,, | 2021 онд Их боригдойн атаршсан тариалангийн талбайд малын тэжээл тарих зорилгоор 175,5 га-д 10 малчны бүлэг , өвөлжөө хаваржааны бууцны хөлд 10 малчин өрх 1га орчимд тус тус ногоон тэжээл тариалсан байна.<br>2022 онд Боригдойн эргэлтэнд оруулж буй талбайд 51 айл өрх, 100 га-д ногоон тэжээл тариалж ургац га -н дундаж 12ц- тэй байна. Орон нутгийн хөгжлийн сангаас иж бүрэн Трактор 139 сая төгрөгөөр худалдан авч ашиглаж байна.<br>2023 онд Баян боригдой хоршоо нь 78 гишүүнтэй. 145 га талбайд тариалалт хийн 306тн ургацыг | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хураан авсан нь га-ийн дундаж үзүүлэлтээр 21,1ц/га байна<br>2024 онд Баян боригдой хоршооны 74 өрх 160 га талбайд малын тэжээлийн ургамал тариалж, 300 тн ургац хураан авсан.<br>Одоо талбайд ажиллаж байгаа техник трактор 82,1, үрлэгч, анжис, хаман боогч, борной, хөнгөн хавагч, наран тармуур, 2 иртэй хадуууртай байна. | | |
| 4 | | Хүлэмжийн аж ахуй эрхлэх иргэдийг дэмжиж ажиллана. | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн | Иргэдийн хөрөнгө | 120 м.кв | 310 м.кв | | 1,61 | 2022 онд Аж ахуй нэгжийн 10м*20м хэмжээтэй нэг хүлэмж, иргэний 5*10,10*20,5*5, гэх мэт жижиг хүлэмжинд өөрийн хэрэгцээний нарийн ногоогоо тариалан хүнсэндээ хэрэглэж байна.<br>2023 онд Аж ахуй нэгжийн 2 хүлэмж, иргэдийн 5 жижиг хүлэмжинд тариалалт хийгдэж байна. Шинээр Хүнс хөдөө аж ахуйн газраас 2 ширхэг 6*10м.кв хүлэмж ирсэн Иргэдийг хүнсний ногооны хөнгөлөлтэй үнээр үрийн дэмжлэг үзүүллээ. Үүнд хүлэмжийн лооль, черри лооль, өргөст хэмх, бууцай, чинжүү, навчит салат үрийг авч ургалт 100%-тай ургуулсан байна.<br>2024 онд хүлэмжийн тариалалтыг 6 иргэн 1 аж ахуйн нэгж нийт 240 м$^2$ -т 4-5 төрлийн хүнсний нарийн ногоо тариалж 2,451 тн ургацыг хураан авсан. ХХААГазраас сумдад хувиарласан хүлэмжийг Шийрийн бүрд малчны бүлэгт өгсөн. | 90 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | | Хуучин ашиглалтгүй байгаа зоорийг засварлаж ашиглалтанд оруулах, шинээр зоорь барих санал санаачлагыг дэмжинэ. | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн | Хоршооны хөрөнгө Иргэдийн хөрөнгө | 1 | 1 зоорь | 4 | 8,0 | 2021 онд 2 өрх өөрийн эзэмшлийн зооринд засвар үйлчилгээ ариутгал хийсэн байна. ХАА-н газраас зохион байгуулсан сургалтаар 10 иргэнд зоорь барих тооцоолол, материалын судалгаа хийх аргачлалд суралцсан. Бурхант хайрханы хишиг хоршооны “Тэнгэрийн оргилго” дэлгүүр өөрсдийн хэрэгцээний 20 тн -н зоорь ашиглалтанд оруулснаар сумын хэмжээнд 3 зоорь ашиглагдах юм. | 70 | |
| 6 | | Бэлчээрийн хортон мэрэгч, үлийн цагаан оготнотой микробиологийн болон энгийн механик аргаар тэмцэх ажлыг зохион байгуулана. | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн | Орон нутгийн төсөв | 10 га-д устгал хийдэг | 10 га-д хийсэн байх | | 30,0 | 2021 онд Хөх дэл оторын бүсэд 4500га-д улсын төсвийн хөрөнгө оруулалтаар оготно устгал хийсэн байна. 2022 онд Бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан огтоныг устагх ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 30 сая төгрөгөөр бактержуулсан будааг 1 га-д 2500-3000 гр тооцон авч Ар жаргалант 1, Их боригдой 2, донгит 3, Ар хөшөөт 4, Онгон 5 -р багуудын нутгийн малчдад хүлээлгэн өгч тусгай удирдамж заавРын дагуу хийлгэлээ. | 90 | |
| 7 | | Бэлчээр ашиглалтын сумын журам боловсруулж, батлуулан хэрэгжүүлэнэ. | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн | Хөрөнгө шаардахгүй | Журам байхгүй | Журам батлуулж хэрэгжилийг хангаж ажилласан байна. | - | - | ИТХ-ийн 2023 оны 03 сарын 30 өдрийн хуралдаанаар 3 бүлэг 18 зүйл бүхий бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаН ажиллаж байна. | 90 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | | Хэт доройтсон цөлжсөн бэлчээрийг сэргээх, өнжөөх, малчин айл бүрийг 5 сарын 1-ээс өмнө өвөлжөөнөөс нүүлгэж хэвшинэ. | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн | Хөрөнгө шаардахгүй | | жил бүр 1 багт хэрэгжүүлэх | - | - | Энэ асуудлыг сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд тусгасан байгаа.<br>Багуудийн иргэдийн нийтийн хурал 4 удаа, Малчдын зөвлөгөөн 1, хортон мэргэчидтэй тэмцэх ажлын үер засаг даргын захирамж зэрэгт бэлчээрийг өнжөөх олон наст болон ногоон тэжээлийн ургамал зэргийг тариалан бэлчээрийг сэргээх зэрэг арга хэмжээг суртчилан нөлөөллийн арга хэмжээг авч ажиллаж байна | 70 | |
| 9 | | Шинээр инженерийн хийцтэй худаг гаргах болон засварлана. | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн | Орон нутгийн төсөв | Жилд 3 худаг шинээр гаргадаг | 12 худаг шинээр гаргах | 225 | 85,0 | 2021 онд 2020 оны зарласан тендерээр дуусаагүй байсан 1 худгийг хүлээж авсан. /4-р баг Баянхайрханы ар/ 2022 онд шинээр инженерийн хийцтэй худаг “Алтан шар зам” хөшөөт ногоон байгууламжид орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1 худаг, шинээр 5 цооног // гаргасан. 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Ар Худаг, Сувраагийн хоолой, Хөөвөрт тус бүр нь 25 сая төгрөгний хөрөнгө оруулалттай 3 худгийг хүлээн авсан. | 70 | |
| 10 | | Хөдөө аж ахуйн салбарын ажилтан албан хаагчид, малчид, газар тариалан эрхлэгчид, үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан | Орон нутгийн төсөв | 10 | 55 | | 1,5 | 2021 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөө аж ахуйн их сургуультай хамтран зохион байгуулсан “**Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон ухаалаг газар тариалангийн технологи,** | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүх төрлийн сургалтад хамруулах, туршлага судлуулах ажлыг зохион байгуулна. | | мэргэжилтэн | | | | | | **инноваци**" сэдэвт онол-үйлдвэрлэлийн бага хурал, Ургамлын гарал үүсэл,пестицидийн бүртгэл хяналтын систем, өрхийн тариалан бизнес хөгжил ТББ-с зохион байгуулсан сургалтанд давхардсан тоогоор 10 иргэн хамрагдсан байна.<br>2022 онд Хар хоринд тэжээлийн олон наст ургамал болон олон наст ургамалын онол практик сургалт-2 өдөр 2 иргэн 1 мэргэжилтэн<br>Өвөрхангай аймагт Хүнсний тэнцэлийн сургалт-2 өдөр мэргэжилтэн<br>Монгол улсад тогтвортой хөгжлийг зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь -2 өдөр мэргэжилтэн<br>Хоршооны үнэлгээ-2 онол практик 2 мэргэжилтэн 2 иргэн<br>Хөдөлмөр халамжийн хэлтсээс явуулж байгаа ахмад настны зөвлөх үйлчилгээгээр давхардсан тоогоох 200 гаруй иргэнд газар тариалангын сургалт зохион байгуулсан. | | |
| 11 | | Малын тэжээлийн үйлдвэрийг ашиглалтанд оруулж, үйл ажиллагааг эхлүүлнэ. | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан | Иргэдийн хөрөнгө<br>Орон нутгий | ажилладаггүй 1 үйлдвэр байгаа | Ашиглалтад оруулсан байна | - | - | Малын тэжээлийн үйлдвэрийг 380 кВт-д холбож, ногоон тэжээл тээрэмдэж үйлдвэрлэхэд бэлэн болсон. | 50 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэргэжилтэн | н төсөв | | | | | | | |
| 1 | Зорилт 3. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдэд тулгуурласан бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | Суманд “Борлуулалтын төв” байгуулан сумынхаа үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг худалдаалах боломжийг бүрдүүлэн, хэвлэл мэдээлэл, цахим орчинд сурталчлана. | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн | Орон нутгийн төсөв Иргэд | Барилгат засвар хэрэгтэй | үйлдвэр эрхлэгчдийг ажлын байраар хангаж, үйлдвэрлэл үйлчилгээ явагдаж эхэлсэн байна. | 40,0 | 10,0 | Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг Бүрд-Алтан намар, Өв-Түншлэл арга хэмжээнд 2022 онд давхардсан тоогоор 32 иргэн бүтээгдэхүүн бараа ажил үйлчилгээгээ танилцууллаа. Энэ арга хэмжээг сумын олон дагагчтай албан болон албан бус цахим хуудсуудаар нэвтрүүлэн суртчилсан. Энэ арга хэмжээнээс иргэд 1,5 сая төгрөгний мөнгөн орлого олсон байна. 2023 онд 100 гаруй иргэн оролцож 5 сая төгрөгний орлого олсон байна. 2024 онд 50 гаруй иргэн оролцож 13 номинацаар шилдгээ шалгаруулж, 3,5 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. | 100 | |
| 2 | | Сумын хэмжээнд үйлдвэрлэл эрхлэгчдийн пэйж хуудас үүсгэн мэдээ, мэдээлэл, сургалт, арга туршлага, зөвлөмж, Онлайн худалдааг хөгжүүлж, Бүрд онлайн дэлгүүр үүсгэн ажиллагааны талаар баяжуулан хөтөлж, хөгжүүлэнэ. | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн | Хөрөнгө шаардахгүй | | Үйлдвэрлэл эрхлэгчид бараа бүтээгдхүүнээ борлуулах боломж бүрдсэн байна. | - | - | Олон дагагчтай албан болон албан бус цахим хуудсуудаар нэвтрүүлэн суртчилсан арга хэмжээ, сургалт суртчилгаа давхардсан тоогоор 20-30 гаруй байна. Мөн “эрүүл хүнс” “хүнснээс хуванцарыг халах” зэрэг цуврал хичээлүүдийг цахим орчинд түгээж байна. Эдгээрийн үзсэн хандалт нь 2,3к байна. | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | | Сумын онцлог түүхэн өв уламжлал бүхий бэлэг дурсгал, гар урлал, үндэсний дээл хувцас, гоёл чимэглэл, уран хатгамал зэрэг брэндэд чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжинэ | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн | 15 | | 3 доошгүй | - | 40 | ИТХ -аар баталсан хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн тэргүүлэх чиглэлд сумын онцлог түүхэн өв уламжлал бүхий бэлэг дурсгал, гар урлал, үндэсний дээл хувцас, гоёл чимэглэл, уран хатгамал зэрэг брэндэд чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих чиглэлийг оруулж, төсөл хэлэлцэн шалгаруулж байна. Нийт оёдлын чиглэлээр 4 төсөл хэлэлцэгдсэнээс 2 иргэний төслийг дэмжсэн. | 70 | |
| 4 | | Албан байгууллагын цайны газар болон нийтийн хоолны газруудад хуванцар шанага, сав, суулга хэрэглэхийг хориглох, айл өрхүүдэд дээрх савны хор хөнөөлийг таниулах, нөлөөллийн арга хэмжээг бүхий л төрлөөр зохион байгуулж зохих үр дүнд хүрнэ. | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн | Орон нутгийн төсөв | 1 | төсвийн гал тогоо бүхий байгууллагууд хуванцар савнаас татгалзсан байна. Айл өрхүүдийн 100% нь хувцанцар сав хэрэглэхгүй болсон байна. | - | 1,8 | Цахим болон цаасан хэлбэрээр давхардсан тоогоор 240 иргэнийн хамруулсан хуванцарын хэрэглээг тандах судалгаа авч анализ хийж ажиллаа. “Хөх сав хөхүүр орлохгүй” 5 багийн дунд болзолт уралдаан зарлаж хөхүүрийн тоогоо 40% нэмэгдүүллээ. Олон дагагчтай албан болон албан бус цахим хуудсуудаар нэвтрүүлэн суртчилсан арга хэмжээ, сургалт суртчилгаа давхардсан тоогоор 20-30 гаруй байна. Мөн “эрүүл хүнс” “хүнснээс хуванцарыг халах” зэрэг цуврал хичээлүүдийг цахим орчинд түгээж байна. Эдгээрийн үзсэн хандалт нь 2,3к байна. | 90 | |
| 5 | | “Төсөл, шинэ санаа сонгон шалгаруулах” арга хэмжээг шат дараалан зохион байгуулна. | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан | Орон нутгийн төсөв | 0 | 1 арга хэмжээ зохион байгуул | | 180 | Хоршоо хөгжүүлэх сангийн журам шинэчлэгдэн батлагдсан, 2022 онд 1 хоршоо, 4 иргэний төслийг дэмжсэн. . | 90 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хариуцсан мэргэжилтэн | | | сан байх | | | 2024 онд 1 хоршоонд мод үржүүлгийн талбай байгуулах чиглэлээр 1 төслийг дэмжсэн. | | |
| 6 | | Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг Улаанбаатар хотын зах зээлд нийлүүлэхэд Нийслэлийн ЗДТГ-тай хамтран ажиллана | | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн | Орон нутгийн төсөв<br>Хувийн хөрөнгө | | Мах цагаан идээ нийлүүлсэн байх | - | - | Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг Улаанбаатар хотын зах зээлд нийлүүлэхэд Нийслэлийн ЗДТГ-тай хамтран ажиллаж байна. Улаанбаатар хот руу 2023 онд амьдаар хонь 4049, ямаа 1474, адуу 196, үхэр 111, тэмээ 6 толгойг, бүтээгдэхүүн мах адууны мах 11040 кг, тэмээний мах 140 кг, үхрийн мах 2640 кг, хонины мах 18409 кг, ямааны 22 кг , айраг 140 л-ийг тус тус нийлүүлсэн байна. "Өвлийн идэш-2023" махны өргөтгөсөн худалдаанд 10 малчин өрх 1200 кг мах борлуулсан байна. | 70 | |
| 7 | | Эрчимжсэн сүүний фермерийн аж ахуйг хөгжүүлж, загвар аж ахуйг бий болгоно. | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн | Хувийн хөрөнгө | Аж ахуйгаа томруулах зорилготой иргэд байгаа | 2 загвар ААН -ийн бий болгох | 50,0 | 587,0 | ИТХ -аар баталсан хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн тэргүүлэх чиглэлд эрчимжсэн сүүний фермерийн аж ахуйг хөгжүүлж, загвар аж ахуйг бий болгох дэмжих чиглэлийг оруулж, төсөл хэлэлцэн шалгаруулж байна. Нийт сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр 5 төсөл хэлэлцэгдсэнээс 1 иргэний төсөл дэмжигдсэн.<br>Шинэ хоршоо-чинээлэг малчин хөдөлгөөний хүрээнд Сумын иргэдийн хоорондоо эвсэн байгуулсан Тогилын өгөөж, Өсөх Хос Заяа Зул, Элст цохио, Хүрдэт | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ухаа, Онгоны буян хоршоо нь 567 сая төгрөгийн хөнгөлөттэй зээлээр хөдөлмөр хөнгөвчлөх тоног төхөөрөмж худалдан авах болон мал аж ахуйдаа хөрөнгө оруулалт хийгээд байна. | | |
| 8 | | Хүн амын хэрэгцээт сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн зэрэг гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг сумандаа үйлдвэрлэх үйл ажиллагааг дэмжинэ. | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн | Хувийн хөрөнгө | | талх талхан бүт -1, сүү сүүн бүтээгдхүүн 1 нийт хүн амын 40%-ийг хангадаг. | 20,0 | 20 | ИТХ -аар баталсан хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн тэргүүлэх чиглэлд хүн амын хэрэгцээт сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн зэрэг гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг сумандаа үйлдвэрлэх үйл ажиллагааг дэмжих чиглэлийг тусгасан.<br>Хэрчсэн гурилын үйлдвэр 1, сургууль цэцэрлэгийн гал тогоо өөрийн хэрэгцээний гурилан бүтээгдэхүүнийг өдөрт 5 кг -ийг үйлдвэрлэн хэрэглэж байна.<br>Нийт хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэгцээг 100%, гурил, гурилан бүтээгдэхүүний 0%, төмс 17%, хүнсний ногоо 11%, Мах махан бүтээгдэхүүн 1001%-иар хангаж байна. | 90 | |
| 9 | | Суманд малын гаралтай түүхий эдэд түшиглэсэн ноос, арьс, шир, хүнсний ногоо боловсруулах цех , мал нядалгааны цэг бий болгоход дэмжлэг үзүүлнэ. | 2022-2024 | ЗДТГ/Б элчээр, газар тариалан хариуцсан | | Байхгүй | 1 | - | 180.0 | ИТХ -аар баталсан хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн тэргүүлэх чиглэлийг жил бүр шинэчлэн хүн амын хэрэгцээт сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн зэрэг гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг | 50 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэргэжилтэн | | | | | сумандаа үйлдвэрлэх үйл ажиллагааг дэмжихээр тусгагасан. 2022 онд 48 төсөл , 2024 онд 2 төсөл ирснээр хороо хуралдан шийдвэрлэсэн. Баруун боригдой хоршооны төслийн 2 дугаар шатанд мал нядалгааны цех байгуулахаар тусгасан. | | |
| 10 | | Мал нядалгааны цэгийг түшиглэсэн малын гаралтай дайвар бүтээгдэхүүн /өлөн гэдэс, яс, эвэр, туурай, өөх, тос, сэвс/ боловсруулах цехүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ | 2022-2024 | ЗДТГ/Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн | | Байхгүй | 1 | 40,0 | 50 | ХХСан-аас 2022 онд 50 сая төгрөгний санхүүжилт авсан Баруун боригдой хоршооны төслийн нэг хэсэгт зөөврийн мал нядалгааны цэг байгуулах тусгагдсан байгаа боловч хэрэгжилт хангалтгүй байна. | 50 | |
| 1 | Зорилт 4. Малын халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэж тайван байдлыг хадгалан, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангаж, экспортлох | Мал сүргийг угаалга, тарилга, туулгалтад бүрэн хамруулна. | 2020-2024 | ЗДТГ Мал эмнэлгийн тасаг / цаашид МЭТ гэх/ | Улсын төсөв | 2020 онд угаалганд бог 260500 ,бод 3600 тарилга 218123 туулгалтанд 299082 мянган толгой мал | Угаалга 25039, тарилга 210588, туулга 200846 толгой мал хамрагдсан байна. | | 136,391 | Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар угаалга, туулга, боловсруулалтын төлөвлөгөөг батлуулан ажилласан. Малын эмч нар гүйцэтгэсэн ажил үйлчилгээ, малын тоог Мал эмнэлгийн нэгдсэн санд бүртгэн ажиллаж байна. Мал эмнэлгийн нэгжийн эмч нар төлөвлөгөөний дагуу шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийсэн. Малын эмч нар хийсэн ажлыг системд цаг хугацаанд оруулж байна. 2024 онд Сумын ИТХ-ын 2024 оны 02 дугаар сарын 28 өдрийн 16/06 тоот тогтоолоор шимэгчлэх өвчний төлөвлөгөөг баталуулсан бөгөөд туулгалтад | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боломжийг бүрдүүлнэ. | | | | | хамруулсан байна. | | | | 129710, боловсруулалт 126343, угаалга 89341, нийт 345394 толгой мал хамрагдаж гүйцэтгэл 89,34% тай байна. | | |
| 2 | | Мал эмнэлгийн нэгжийн тоог нэмэгдүүлэх замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | 2021-2022 | ЗДТГ Мал эмнэлгийн тасаг / цаашид МЭТ гэх/ | 25 | 3 мал эмнэлгийн нэгжтэй | Шинээр 12 нэгж байгуулагдана | 25 | - | Донгитын 3 дугаар багийг хариуцсан Үнэгд хайрхны өгөөж ХХК мал эмнэлэг шинээр байгуулагдаж үйл ажиллагаа явуулж эхлээд байна..<br>2024 онд Их боригдойн 2 дугаар багт малын эмч Б.Балжинням Шийрийн бүрд ХХК мал эмнэлэг байгуулж 60 мянган толгой мал хариуцан мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Суманд нийт 4 хувийн мал эмнэлэг үйл ажиллагаа явуулж байна. | 100 | |
| 3 | | Мал эмнэлгийн нэгдсэн системийн үйл ажиллагааг өргөжүүлж, мал эмнэлгийн гэрчилгээг бичих, баталгаажуулах, хянахад шаардлагатай төхөөрөмжөөр сумын малын эмч, мэргэжилтнүүдийг ханган мал эмнэлгийн үйлчилгээг цахимжуулна. | 2020-2024 | ЗДТГ Мал эмнэлгийн тасаг / цаашид МЭТ гэх/ | 6,0 | | Мал эмнэлгийн нэгжүүдийг тавлетээр хангасан байна. | 6,0 | - | Мал эмнэлгийн үйл ажиллагаа цахимд шилжсэнтэй холбоотойгоор малын эмч нарт шаардлагатай таблетаар хангах заалтын хэрэгжилт хийгдээгүй байна.Малын эмч нар өөрсдийн хувийн төхөрөөмжөөр ажлаа хийж байна.<br>Гарал үүсэлтэй холбоотой үйл ажиллагаа бүрэн цахимжсан. | 30 | |
| 4 | | Зах зээлд борлуулагдаж малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг мал эмнэлгийн цахим | 2020-2024 | ЗДТГ Мал эмнэлгийн тасаг / | | 268765 кг мах, амьд мал 22575 | 27тн мах, 23 толгой малд гарал | - | - | 2023 онд нийт 1539 гэрчилгээнд баталгаажуулалт хийсэн байна. Үүнд: Мах 152374 кг, ямаа 67177 кг, адуу 47730 кг, үхэр 32587 кг, тэмээ 750 кг, ноолуур 300 зг, хонины арьс 200 ширхэг, ямааны | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | системээр хянаж, гэрчилгээжүүлнэ. | | цаашид МЭТ гэх | | толгой, айраг 700 л, сүү 300 л,ноос 70 тн, ноолуур 150 кг тус тус гарал үүслийн гэрчилгээ авсан байна. | үүсэл олгоно. | | | арьс 90 ширхэг, үхрийн арьс 10 ширхэг, айраг 140 литр<br>Гадагшаа Амьд малд : Хонь 14041 толгой, ямаа 3134 толгой, адуу 596 толгой, үхэр 214 толгой, тэмээ 15 толгой нийт 18000 толгой амьдаар зах зээлд борлуусан байна.<br>Сумын дотоод байгууллага, иргэдийн хэрэгцээнд зориулсан мал махны гарал үүслийн бичиг 19 хийгдэж байна. Үүнд хонь 90, үхэр 86, ямаа 38, адуу 4<br>Гаднаас үржлийн зориулалтаар 63 гарал үүслийн бичиг хийгдэж 479 толгой мал ирсэн үүнээс: тэмээ 2, адуу 126, үхэр 118, хонь 115, ямаа 118 толгой ирж үзлэг хамруулж хүлээн авсан.<br>Гадны аймаг сумдуудаас Отор нүүдлээр ирсэн 30 гарал үүслийн бичиг хяналт хийж 1682 толгой үзлэг хамруулж хүлээн авсан үүнээс адуу 138, үхэр 104, хонь 580, ямаа 860 ирсэн байна<br>Өөр аймаг сумд руу отор нүүдлийн зориулалтаар 11 бичиг хийгдэж хонь 3027, ямаа 1078, адуу 394, үхэр 170 нийт 4669 толгой үзлэгт хамрагдаж явсан.<br>Өөр аймаг, сумд руу үржлийн зориулалтаар 24 бичиг хийгдсэн байна. Үүнээс хонь 81, адуу 65, ямаа 53, үхэр 48 нийт 247 толгой мал үржлийн дагуу бичиг хийгдсэн байна.<br>**2024 онд** 2024 оны 01 дүгээр сараас 11 дүгээр сарын 28 хооронд мал эмнэлгийн нэгдсэн | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | системд 1460 цахим гэрчилгээ бүртгэгдэж Бүрд сумаас гадагшаа 1343, сум руу ирсэн 104, дотоодод 13 бичиг үржлийн 78, амьд малын 734, бүтээгдэхүүн 573 бичиг хянагдсан байна. Үүнд хонины мах 20595 кг, адуу мах 10065 кг, үхэр мах 9040 кг, ямаа мах 7135 кг, тэмээ мах 650 кг, үхрийн аарц 550 литр, амьд мал адуу 782 толгой, үхэр 172 толгой, хонь 17669 толгой, ямаа 5262 толгой, тэмээ 13 толгойд мал эмнэгийн цахим гэрчилгээ олгож хянасан байна. Отор нүүдлийн зориулалтаар 1 бичиг хийж адуу 68, үхэр 33, хонь 390, ямаа 212 толгой малд үзлэг хийж явуулсан. үржлийн зориулалтаар 78 бичиг ирж хянагдаж адуу 86, хонь 479, ямаа 370, үхэр 11 толгой ирж мал эмнэлгийн хяналтанд үзлэгт хамрагдсан. | | |
| 5 | | Малчдыг малын эм, био бэлдмэлийг зохистой хэрэглэх арга зүйн талаарх сургалт, мэдээллээр хангаж, эмийн үнэд хяналт тавина. | 2021-2022 | ЗДТГ Мал эмнэлгийн тасаг / цаашид МЭТ гэх | Хөрөнгө шаардлагагүй | 2020 онд 1 удаа сургалт хийсэн | Малчдад арга зүйн зөвөлгөө мэдээлэл өгсөн байна. жилд 6 удаа | - | - | 2022 онд сумын багийн иргэдийн нийтийн хуралд антибиотик, ивермектиний зохистой хэрэглээний тухай сургалтыг зохион байгуулсан. Эм ханган нийлүүлэх ви.ти нетийн сургагч багш нар ирж малчид иргэдэд эмийн зохистой хэрэглээний талаар мэдээлэл хийж гарын авлага тарааж ажилласан. Мал эмнэлгийн тасгаас 5 удаа, эмийн компани 1 удаа сургалт зохион байгуулсан байна. 2023 онд НҮБ-ын Даян дэлхийн байгаль орчны санхүүжилтийн Жижиг төслийн хөтөлбөртэй хамтран “Нутгийн | 100 | . |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Иргэдийн Хамгаалалттай газар нутаг ба малчин менежер" төслийн "Нүүдэлч монгол ухаан төв" НҮ ТББ-ээр дамжуулан хэрэгжүүлж байгаа төсөлд хамрагдсан малчдад малын эмийн зохистой хэрэглээний талаар сургалтыг мэргэжлийн хүмүүс ирж зохион байгуулсан.<br>**2024 онд** Малчид иргэдэд 2024 оны 05 дугаар сарын 20-26 хооронд 1-5 дугаар багийн хурлууд болж хонь ямааны цэцэг, шүлхий, адууны ям өвчний талаарх мэдээлэл, мал амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавих мэдээллийг 225 малчин хамрагдаж гарын авлага зөвлөмж мэдээллээр хангагдсан байна. Малын эмийн зохистой хэрэглээний зөвлөмж штрокийг олон нийт сүлжээнд 5 мэдээлэлийг байршуулан малчид иргэдийг мэдээлэлээр ханган ажилласан. | | |
| 6 | | Мал эмнэлгийн тасгийг мах, сүүнд шинжилгээ хийдэг /эм, тарианы үлдэгдэл илрүүлэх/ тоног төхөөрөмжөөр хангах. | 2021-2022 | ЗДТГ Мал эмнэлгийн тасаг / цаашид МЭТ гэх | Орон нутгийн төсөв | Байхгүй | Мах, сүүнд эмийн үлдэгдэл шалгах багажтай болсон байна. | 20 сая | | ОНХС-ийн 20 сая төгргийн хөрөнгөөр малын мах, сүүнд антибиотикийн шинжилгээ хийдэг e-reader, малын цусны шинжилгээ хийх зориулалт бүхий биохимийн шинжилгээний орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан. | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | | Эрүүл мал-эрүүл хүнс дэд хөтөлбөр, Цэвэр орчин эрүүл мал тохижилт соёлжилтыг хангуулах журам зэргийг ИТХТэргүүлэгчдээр баталуулан хэрэгжилтийг ханган ажиллана. | 2021-2022 | ЗДТГ Мал эмнэлгийн тасаг | Орон нутгийн төсөв | | Хэрэгжилтийн үр дүнгээр | - | - | Эрүүл мал-эрүүл хүнс дэд хөтөлбөр, Цэвэр орчин эрүүл мал тохижилт соёлжилтыг хангуулах журам зэргийг ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, хяналтанд авч хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 70 | . |
| 8 | | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тархвар зүйн судалгаанд тулгуурлан цахим системд төлөвлөж, гүйцэтгэлийг оруулах | 2021-2022 | ЗДТГ Мал эмнэлгийн тасаг | Улс, орон нутгийн төсөв | 192576 толгой мал хамруулса | 193000 толгой мал хамруулна. | | | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ төлөвлөгөөний дагуу хийгдэж байна. 2021-2023 онуудад Боом Цусан халдварт , Дуут хавдар, ДХХ, Энтербактериоз , Галзуу , Шөвөг яр , шүлхий ,бруцеллёз, сахуу , бог малын мялзан зэрэг өвчний вакциныг сумын дүнгээр 98,4% тай байна 2024 онд гоц халдварт өвчин Шүлхий өвчний дархлаажуулалтад 9740 толгой үхэр хамрагдаж гүйцэтгэл 98,3%, Хонь, ямааны цэцэг өвчний дархлаажуулалтад 261013 толгой хонь хамрагдаж гүйцэтгэл 99,4%, бог малын мялзан өвчний дархлаажуулалтад 237326 толгой мэдрэмтгий мал амьтан харагдаж гүйцэтгэл 99,6% тай байна. Нийт гоц халдварт өвчний дархлаажуулалтад 508079 толгой мэдрэмтгий мал амьтан хамрагдсан байна. | 100 | |
| **2.3. Барилга, хот байгуулалт, газрын харилцаа** | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Зорилт 1. Сумын хөгжлийн хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу иргэдийг тав тухтай ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлнэ | Бизнес хөгжлийн төвийн барилгын урсгал засварыг хийж, гадна, дотно өнгө үзэмжийг сайжруулна. | 2022-2024 | ЗДТГ/гарын даамал/ | Орон нутгийн төсөв | | Засвар хийгдсэн байна. | 40 сая | 36 | Бизнес хөгжлийн төвийн барилгын их засварыг “Өрнөх мэргэн” ХХК хийж гүйцэтгэж байгаа, одоогоор хүлээлгэж өгөөгүй байна. | 50 | |
| 2 | | Наадмын талбай шинээр барина. | 2021-2024 | ЗДТГ/гарын даамал | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө | | Наадмын талбай баригдсан байна. | 30 | 29.6 | 2021 онд Наадмын талбай шинээр барих ажлыг ОНХС-ийн хөрөнгөөр ”Баян их наяд ” констракшин компани шалгарч 6 дугаар сарын 3-ны өдөр гэрээ хийгдэн барилгын ажлыг эхлүүлж хугацаанд нь буюу 7 дугар сарын 9-ны өдөр хүлээлгэн өгсөн. | 100 | |
| 3 | | Ахуйн үйлчилгээний байрны дулааны шугам засварлаж, халуун ус, үсчин зэрэг үйлчилгээг тогтмолжуулна | 2020-2024 | ЗДТГ/гарын даамал | Орон нутгийн төсөв | Халуун усны барилгатай хэдий ч хүйтэн учраас үйлчлүүлэгчид бага | халуун ус, үсчин зэрэг үйлчилгээг тогтмолжуулана. | 5,0 | 20.0+5 | Ахуйн үйлчилгээний байрны дулааны шугамыг Өв дулаан ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Иргэн Б. Оюунгуатай түрээсийн гэрээ хийж халуун усны үйлчилгээг үзүүлж байна. | 50 | |
| 4 | | Сумын төвийн хатуу хучилттай 800 м авто замыг засварлана. | 2020-2024 | ЗДТГ/гарын даамал | Орон нутгийн хөгжлийн сан | 500м зам маш их эвдрэлтэй байгаа | 800 м замыг бүрэн засварласан байна. | 350,0 | 585,0 | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Их монгол хороололын 750м авто замын зураг төсвийг хийлгүүлснээс 300м дугуйн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний зам, хамгаалах зурвас бүхий авто замыг шинээр барьж хүлээн авсан. | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | | Сумын төвийн хороолол гудамжийг цэгцэлнэ. | 2020-2024 | ЗДТГ/газрын даамал | Иргэдийн хөрөнгө | | газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу эмх цэгцтэй газар олголт хийж, стандартын дагуу бариулна | | 6.9 | 2022 оны 05 дугаар сарын 18-нд Сумын Засаг дарга М.Мөнхбаяр төрийн болон хувийн хэвшлийн байгууллага аж ахуй нэгжийн дарга, эрхлэгч нартай ӨГЛӨӨНИЙ ЦАЙНЫ уулзалтыг 2 удаа зохион байгуулж Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах зорилтот жилийн хүрээнд хийж хэрэгжүүлэх ажил, сумын түүхт 90 жилийн ойг угтан айл өрх албан байгууллага бүр хашаа хороо болон гадна орчны тохижилт хийх тал дээр анхаарч байгууллагын дарга нар ажилчдынхаа хашааг өнгө үзэмжийг нь сайжруулж, цэгцлүүлэх, айл өрхийн хогийг ажлын бус цагаар ачуулж байх гэр хорооллын айл өрхүүдийн хашааны гадна хураагдсан элсийг тухайн айл өрхтэй нь үнэ хөлсийг нь тохирон хог ачилтын машин, трактор 2-ыг ашиглан цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулах зэрэг асуудлыг хэлэлцэн хэрэгжилтийг зохион байгуулав.Үүний үр дүнд 23 айл хашаагаа тэгшилэн будаж оохордсон байна. | 70 | |
| 6 | | Их боригдойн 2-р багийг антенн сүүлийн үеийн төхөөрөмж суурилуулан | 2020-2024 он | ЗДТГ/газрын даамал | Хувийн хэвшлийн | | 4G Сүлжээтэй | | 290.0 | 2022 онд Мобиком корпораци ХХК-ны 2-р багийн Үнэгдийн “Сант хайрхан” -д үүрэн холбооны дамжуулах станц байгуулсан. | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шинэчилж 4G сүлжээтэй болгоно. | | | зардал | | болгоно. | | | | | |
| 7 | | Төрийн байгууллагуудад ариун цэврийн байгууламжийг шинээр барина. | 2020-2024 он | ЗДТГ/газрын даамал | Улсын төсөв | Муу | 1ш нийтийн ариун цэврийн байгууламж шинээр барина | 20,0 | 390.0 | БШУЯамны төлөвлөгөөний дагуу цэцэрлэг, сургуулийн ариун цэврийн байгууламжийн ажил хийгдэж эхэлсэн боловч гүйцэтгэгч компаны буруугаас уг ажил зогссон. 2024 онд Боловсролын яам хуучин гүйцэтгэгч болох “Номуун заяа” ХХК-тай гэрээг цуцалж шинэ гүйцэтгэгч сонгохоор ажиллаж байна. Мөн соёлын төв, Эрүүл мэндийн төв зэрэг газрууд дотор 00 -ын шугам сүлжээ байгаа боловч, гаднах шугам засварлагдаж байж ажиллах боломжтой болно. | 50 | |
| 8 | | Мааньт хороололын 04,022 кл ваттын цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчлэнэ. /өндөр хүчдлийн шугамыг цэцэрлэгээс холдуулан барих/ | 2021-2024 | ЗДТГ/газрын даамал | 41,3 сая ЭБЦТ Санцын ТӨХК өөрийн хөрөнгөөр | | Мааньт хорооллын агаарын шугам бүрэн шинэчлэгдсэн. | 100,0 | 270,3 | Сумын төвийн төв хэсгийн дэд станц, мааньт хороолол, хэрсэн хороололын 0.4 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг төмөр бетон шон, тулгуур бетон, трансформаторын шон сип кабел утсаар солих, шинээр барих зэрэг ажлууд хийгдсэн | 100 | |
| 9 | | Сумын төвийг АО301 улсын чанартай авто замтай хатуу хучилттай замаар холбоно. | 2021-2024 | ЗДТГ/газрын даамал | Орон нутгийн төсөв | Холбогдоогүй | Ажлыг эхлүүлсэн байна. | - | | Хэрэгжээгүй | 0 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | | Хүүхдийн тоглоомын талбай байгуулна. | 2021-2024 | ЗДТГ/гаэрын даамал | Орон нутгийн хөгжлийн сан | | Тоглоомын талбай баригдсан байх | 20,0 | 20.0 | ОНХС-ын хөрөнгөөр сумын төвд 2022 онд хийгдэх “Хүүхдийн тоглоомын талбай” барих газрын байршил дээр “Захиргааны ерөнхий хуульд” заасны дагуу сумын иргэдээс 2 байршилд санал авч Маанькт хорооллын баруун ШТС-уудаас чанх урд 150 метр төмөр хашаагаар хашаалж хүүхдийн тоглоомын талбай барьж хүлээлгэн өгсөн. Уг ажлыг С.Өсөхбаяр ахлагчтай “ Өсөх ирээдүй” бүлэг гүйцэтгэсэн байна. | 100 | |
| 11 | | Аймаг, хот хооронд байнгын ажиллагаатай нийтийн унаатай болно. | 2021-2024 | ЗДТГ/гаэрын даамал | Хувийн хөрөнгөөр | | аймаг сум хооронд унаатай болно. | - | | С.Ганбаатар, Ц. Дашдагва , Г.Гантулга нар хот хооронд хүн, ачаа хүргэх үйлчилгээ хийж байна. | 100 | |
| 12 | | Нийтийн орон сууц барина | 2021-2024 | ЗДТГ/гаэрын даамал | | | Орон сууц баригдаж эхэлсэн байна. | | | Хэрэгжээгүй | 0 | |
| 13 | | Орон нутгийн судлах музейд засвар хийнэ | 2021-2024 | ЗДТГ/гаэрын даамал | | | Засвар хийж дууссан байна | 20,0 | 7.5 | Орон нутгийн судлах танхимын сум суртчилах танхимыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр дээвэр болон дотор заслыг хийсэн. Мөн музейн хашаан доторх амьтдыг сэргээн засварласан | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Зорилт 2. Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг эдийн засаг, нийгмийн хөгжил, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөж, газрын төлөв байдал, чанарын улсын баталгааг хийлгэх. | Хот суурингийн болон бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг үе шаттай хийлгэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | 2020-2024 он | ЗДТГ/газрын даамал/ | Улсын төсөв<br>Орон нутгийн төсөв | | 35 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулсан байна. | 12,0 | 0.7 | Бүрд суманд иргэн, аж ахуй нэгж байгууллагын газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажил хийлгэх хүсэлт ирээгүй. | 100 | |
| 2 | | Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газрын кадастр, үнэлгээ, газрын мониторинг, биржийн байнгын ажиллагаатай системийг хөтөлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, газар олголт, газар зохион байгуулалтын үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй хэрэгжүүлнэ. | 2020-2021 он | ЗДТГ/газрын даамал/ | | | газар олголт, азар зохион байгуулалтын үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй хэрэгжүүлнэ. | - | | Сумын газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөө, газрын кадастр, үнэлгээ, газрын мониторингийн мэдээллүүдийг холбогдох системүүдэд оруулж egazar.gov.mn цахим хуудаст нэгтгэн байршуулсан. Цахим хуудсыг ашиглан иргэд газрын харилцаа болон сумын Газрын даамал дээр очих шаардлагагүйгээр газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг, газрын төлбөр, татварын мэдээлэл, мөн хэрхэн төлөх талаар гэх мэт бүх мэдээллийг авах, газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдолтой бүх төрлийн хүсэлт, эзэмшиж, ашиглаж буй газрын бусад үйлчилгээ (барьцааны бүртгэл, хугацаа сунгах, талбайн хэмжээ өөрчлөх гэх мэт)-тэй холбоотой 6 төрлийн хүсэлт, эзэмшил ашиглалттай холбоотой 12 төрлийн хүсэлт илгээх боломжтой болсон.<br>Сумын хэмжээнд он бүр бэлчээрийн талбайг 14 цэгээр | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | төлөөлүүлэн фото мониторингийн аргаар үнэлж, гарсан үр дүнг “Газрын мониторингийн цахим систем”-д бүрэн оруулсан. | | |
| 3 | | Сумын төвд хийгдсэн хаягийн зургийг засварлан, хаягжилтын мэдээллийн сан үүсгэж, төрийн байгууллагын мэдээллийн бусад сантай холбож, хаягжилтын ажлыг зохион байгуулна | 2020-2024 он | ЗДТГ/газрын даамал/ | Улсын төсөв | Хаягжилт хийгдсэн. | хаягжилтын мэдээллийн сангийн дагуу хаягын тогтоол шинэчлэн батлуулах | - | | 2013 оны 02 дугаар сарын 07 ны өдөр Хаягжуулалтын тухай хууль , Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолын хавсралтаар Гудамж зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам, 2014 онд Гудамж зам талбай үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага, стандарт батлагдсаны дагуу 2016 онд Сумын хаягийн зураг хийгдэж, гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн жагсаалтыг батлуулж, мэдээллийн санд оруулан хаягжилтын мэдээллийн сан үүсгэж төрийн байгууллагуудад ашиглагдаж байна. Хаягийн мэдээллийн санг засварлаж шинээр орц гарц, гудамжны эхлэл төгсгөлийн цэг, сумын төв болон багуудын төв цэгийг тодорхойлон ажиллаж байна. гэр хороололын хаягжилтыг тоотын дагуу дугаарлан хаягжуулсан. Сумын ИТХ-аар хаягжилтын мэдээлэлийн санг шинэчлэн батлуулсан. | 90 | |
| 4 | | Хот, суурины газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх | 2022-2024 он | ЗДТГ/газрын даамал/ | | Байхгүй | Хот, суурины | 60,0 | | Хэрэгжээгүй | 0 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | | зардлыг сумын ИТХ-аар батлуулан, орон нутгийн төсөвт тусгуулан гүйцэтгэнэ. | | | | | газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх зардлыг сумын ИТХ-аар батлуулна | | | | | |
| 5 | | Өвөлжөө хаваржаа эзэмшүүлэх журам боловсруулж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар оруулж батлуулан ажиллах, | 2022-2024 он | ЗДТГ/газрын даамал | | | журам боловсруулж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар оруулж батлуулах | - | | Сумын тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу Газрын кадастрын мэдээллийн санд Өвөлжөө хаваржааны зориулалтаар 2022 онд 17 нэгж талбар, 2024 онд 1 нэгж талбар нийт 18 нэгж талбарыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж газар эзэмших эрхийн шийдвэр гаргасан. Мөн газар эзэмших эрхийн шийдвэр гаргасан ч газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй 7 нэгж талбар нөхөн бүрдүүлэлтээр оруулж гэрээ, гэрчилгээ олгож ажилсан. | 50 | |
| 1 | Зорилт 3. Сумын хэмжээнд газар зүйн нэрийн | Газарзүйн нэрийн хээрийн тодруулалт, мэдээллийн сан үүсгэх, зураглал үйлдэх ажлыг мэргэжлийн эрх бүхий | 2022-2024 он | ЗДТГ/газрын даамал | Орон нутгийн төсөв | | Мэргэжлийн байгууллагаар хийлгэс | - | 6,0 | Газарзүйн нэрийн хээрийн тодруулалт, мэдээллийн сан үүсгэх, зураглал үйлдэх ажлыг мэргэжлийн эрх бүхий байгуулла “Дижитал Меппинг” ХХК-тай гэрээ | 70 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлж газар зүйн нэрийн хээрийн тодруулалтын ажлыг зохион байгуулж, газарзүйн нэрийн мэдээллийн сан бүрдүүлэн олон нийтэд танилцуулна | байгууллагаар гүйцэтгүүлнэ. | | | | | эн байна.газар усны нэр тодорхой болсон байна. | | | байгуулан гүйцэтгүүлж, 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. | | |
| 2 | | Газарзүйн нэрийн мэдээллийн санг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулна. | 2020-2022 он | ЗДТГ/газрын даамал | Орон нутгийн төсөв | | Газар зүйн мэдээллийн санг таниулах ажлыг хийж баталгаажуулсан байна. | - | | Сумын хилийн цэсийн газрын нэрийг тодруулж, АИХ-ын 1986 оны тогтоолыг сумын сонин болон цахим сайтаар иргэдэд сурталчилж байна. | 70 | |
| 3 | | Сумын хилийн цэсийн газрын нэрийг тодруулж, АИХ-ын 1986 оны тогтоолын дагуу баталгаажуулах | 2020-2024 он | ЗДТГ/газрын даамал | | | Сумын хилийн цэс дээрх тогтоолын дагуу баталгаажсан байна. | - | | Сумын хилийн цэсийн газрын нэрийг тодруулж, АИХ-ын 1986 оны тогтоолын дагуу маргаантай цэг болох Монгол толгой асуудлаар Булган аймгийн Рашаант сумын удирдлагуудтай санал солилцсон. Мөн хилийн цэсийн талаар ГХГЗЗГ-т албан бичиг хүргүүлж , хилийн цэсийн тодруулга хийсэн. | 90 | |
| **БҮЛГИЙН ДУНДАЖ 78 арга хэмжээ** | | | | | | | | | | | **83,2** | |

Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолын 3б дугаар хавсралт

**ӨВӨРХАНГАЙ БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ /2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/**

**2024.12.02** **Бүрд**

| № | №ХБТББ-т тусгагдсан зорилт, үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Нийт зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/ 2024 | | | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | ТГ | ИТХ |
| **ДӨРӨВ. НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ** | | | | | | | | | | | | |
| **4.1. Ногоон хөгжил** | | | | | | | | | | | | |
| 1 | Зорилт 1. Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална. | Усны нөөцийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх зорилгоор булаг шандны эхийг хамгаалж, хөв цөөрөм байгуулна. | 2021-2022 | Байгаль орчны мэргэжилтэн | Орон нутгийн төсөв | 2 | жилд 2 булгийн эхийг хамгаалах, хамгаалалтыг сэргээх /нийт 8 булаг/ | 1.2 | 31,2 | 2021 онд 4-р багийн нутаг Мандалын булаг , Донгитын 3-р багийн нутагт орших Хавчигийн булагийн эхийг хамгаалсан. 2023 онд Аман булагийн эхийг Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 15,404,774 төгрөгөөр төмөр хашаагаар хашиж хамгаалсан. НҮБ-ийн Байгаль хамгаалах сангийн жижиг төслийн хүрээнд Шийрийн бүрдний эхийг Ё.Дашдоржоор ахлуулсан бүлэг хийж гүйцэтгэсэн. 2024 онд 3-р багийн нутаг Шилүүстэйн дунд булаг , 1-р багийн Хадатын булаг, ЕБС-ийн Эко бүлгэмээс Ар жаргалант 1 дүгээр багийн “Хөндлөн” булаг, НҮБ-ийн Байгаль хамгаалах сангийн жижиг төслийн хүрээнд Их боригдой 2 дугаар багийн “Шийрийн Бүрдний баруун эхийн хамгаалалтыг Ё.Дашдоржоор ахлуулсан 12 өрх | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | эхийн хамгаалалсан. . Мөн Мөнгөн булгийн эхийг хамгаалах ажлыг Өсөх Хос Заяа зул хоршоотой гэрээ байгуулан ажиллаж байна. Шинээр хамгаалагдсан булгийн эхийг ойрхон нутагладаг малчин өрхтэй гэрээ байгуулан хүлээлгэж өгсөн. | | |
| 2 | | Шийрийн бүрд, Аман булаг, Мөнгөн булагийн рашаан,сумын төвийн худгийн усны нөөц, физик-химийн найрлага хатуулгийг мэргэжлийн байгууллагаар тогтоолгоно. | 2021-2022 | ЗДТГ-ын байгаль орчны мэргэжилтэн | Улсын төсөв | Жил бүр хийгддэг | шийрийн Бүрдний физик химийн найрлагыг мэргэжлийн байгууллагаар | 3,6 | | 2021 онд Өвөрхангай аймгийн мэргэжлийн хяналтын итгэмжлэгдсэн сорилтын лабораторид **Шийрийн бүрд**: Кальци ион14,02мг/л, Магни ион10,9мг/л, Нийт төмөр 0,003мг/л, pH 8,2, хатуулаг 1,6мг-экв/л , **Аман булаг**с: Кальци ион12,8мг/л, Магни ион6,8мг/л, Нийт төмөр0,005мг/л, pH 8,1, хатуулаг1,2мг-экв/л **Мөнгөн булаг**: Кальци ион 13.6мг/л, Магни ион 2,6мг/л, Нийт төмөр0,033мг/л, pH 8,5, хатуулаг 0,9мг-экв/л Дээрх 3 булгийн усыг ундныусны зориулалтаар ашиглаж болно гэсэн дүгнэлт гарсан. | 100 | |
| 1 | Зорилт 2. Байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, доройтсон газрыг нөхөн сэргээх чиглэлээр, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, байгалийн нөөцийг | Хог хаягдлын менежментийг сайжруулах, иргэн аж ахуй нэгж, байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх замаар хог хаягдлыг бууруулж, эх үүсвэр дээр нь ангилж, хөдөө нутаг, гол усны хогийг цэвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | 2021-2023 | ЗДТГ-ын байгаль орчин хариуцсан мэргэжилтэн | Хувийн хөрөнгө | Айл өрхүүдийн 20% нь хог ангилан ялгадаг савтай болсон | бүх үйлчилгээнй газруудыг бүрэн, айл өрхүүдийн 80 хүртэлх хувийг эх үүсвэр дээр нь ангилан ялгадаг болгоно. | 4,5 | 120,0 | Жилд улирал бүр бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулж хэвшсэн. 2022 онд 7 сумын төвөөс Шар толгойн уулзвар хүртэлх 36 км зам дагуух хог 2 тонн хогийг төвлөрсөн хогийн цэгт авчиран устгал хийсэн. Хогоо ангилан ялгадаг айл өрх .43 , байгууллага аж ахуйн нэгж 16 байна. Сумын төвд 2 ширхэг ангилан ялгах хогийн савыг байрлуулсан. Хог ангилан ялгах 2 савнаас ангилан ялгасан хаягдалыг хадгалах байр руу зөөверлөдөг. айл өрхүүдийн эх үүсвэр дээр ангилсан хаягдлыг хадгалах байр руу Хог тээврийн жолооч Ү.Чинбат зөөверлөж байна. Хог тээврийн ажлыг ОНХС-аас санхүүжүүлэн иргэнтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна.<br>Иргэн Л.Чинбаатар эзэнтэй “Тэнгэрийн оргилого” дэлгүүр нь өөрийн хуванцар сав, гялгар уут, архины шил, лааз хогоо ангилан | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | | | | ялгаж прэсслэн тухайн хэрэгцээтэй газар өгдөг болсон. Сумын Засаг даргын 2022 оны 04.15-ны өдрийн А/29 захирамж гарч малын сэг зэм устгал, ариутгал халдваргүйжилтийн 2 сарын аян, Жил бүр хавар намар 2 удаа нохой устгалын ажлыг зохион байгуулж байна, Сумын төвийн хуучин хогийн цэгийг ландфилийн аргаар булж, хогийн цэгийг шинэчилэн зогоон татаж хамгаалалтын далан барин дээр нь төмөр хайсан хашааг 87.6 сая төгрөгөөр барьж ашиглалтад оруулсан. | | |
| 2 | | Суманд хог хаягдлыг дахин боловсруулах цех байгуулна, | 2020-2024 | ЗДТГ-ын байгаль орчин хариуцсан мэргэжилтэн | Хувийн хөрөнгө | | Цех байгуулах | | | Хог хаягдлыг ангилан ялгах 2 сав сумын төвд байрлуулсан. Сумын 710 иргэдэд хог хаягдлаа ангилан ялгах аюултай хог хаягдлын хор хөнөөлийн талаар сургалт сурталчилгаа хийсэн. Хог хаягдал дахин боловсруулах хоёрдогч түүхий эд, хуванцар, лааз, шил зэргийг Ч.Чинбаатар , Хог тээврийн ажлыг гэрээгээр гүйцэтгэж байгаа жолооч Ү.Чинбат хуванцар, нар иргэдээс авч төвлөрүүлэн дараагийн цэгт хүргэн ажиллаж байна. | 70 | |
| 3 | | Гэр хороолол, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс болон аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуй нэгжүүдэд дэвшилтэт технологи бүхий “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний | 2020-2024 | ЗДТГ-ын байгаль орчин хариуцсан мэргэжилтэн | орон нутгийн төсөв, иргэд аж ахуйн нэгжийн хөрөнгө | 0 | 40 эко жорлон барих | | | Эко жорлон хийх аргыг судлаж иргэдэд цахимаар мэдээлэл өгөн ажиллаж байна 2023 онд албан байгууллагуудын ариун цэврийн байгууламжид 2 удаа Эрүүл мэндийн төв, Мал эмнэлгийн тасгаас ариутгал халдваргүйжилт хийсэн. Сумын төвд ариун цэврийн байгууламж сайжруулсан 17 өрх, хөдөөгийн айл өрхүүдээс өвөлжөө хаваржаа, зуслан намаржаандаа ариун цэврийн байгууламжтай болсон өрх 47 байна Тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа Баянговь жуулчны бааз зориулалтын SWEET GOBI нь эко ариун цэврийн байгууламжтай, жуулчид их ирдэг Ширээт цагаан | 90 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бохирдлыг бууруулна. | | | | | | | нуурын орчим зориулалтын ариун цэврийн байгууламжтай болсон. | | |
| 4 | | Нэн ховор, ховор амьтан, ургамлын тархац нөөцийн судалгааг өргөжүүлж, хамгаалалтын менежментийг сайжруулна. | 2020-2024 | ЗДТГ-ын байгаль орчин хариуцсан мэргэжилтэн | Орон нутгийн төсөв | Судалгаа хийгээгүй | Нөөцийг тогтоож хамгаалалтын асуудлыг шийдвэрлэнэ. | | | Тус сумын нутагт халиун буга, согоо , чоно, тарвага зэрэг ховор амьтад , Ширээт цагаан нуур, Их бага Монгол уул орчим хонин арц /нэн ховор/, ямаан арц / ховор/ байдаг бөгөөд ховор , нэн ховор амьтан, ургамалын судалгааг гарган ажиллаж байна. Хөгнө Тарны байгалийн цогцолборт газрын байгаль хамгаалагч Р. Намжилдоржтой хамтран хяналт шалгалтын ажлыг тогтмол хийж байна. | 70 | |
| 5 | | Төрийн үйлчилгээний чанар бүтээмжийг нэмэгдүүлэх, байгаль орчны хууль тогтоомж, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролыг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ | 2020 2024 | ЗДТГ-ын байгаль орчин хариуцсан мэргэжилтэн | Орон нутгийн төсөв | | ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролыг олон нийтэд суртчилна. Хүний тоо-600 | 3,8 | | 2021 онд Байгаль орчныг хамгаалах боловсролыг цахимаар Бүрд сумын нэгдсэн групп, Өвөрхангай аймгийн бүрд сумын төрийн байгууллагын мэдээ мэдээлэл зэрэг фейсбүк группээр олон нийтэд хүргэж байна. Нийт 10 мэдээлэл хүргэсэн.<br>2022 онд Сумын сонинд 2 удаа “ Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-орчны бохирдлыг бууруулах” зорилтот жилийн ажлын төлөвлөгөө ажлын мэдээлэлийг сонинд хэвлүүл таланг нийтэлж сумын айл өрхүүдэд хүргүүлж ажиллав. Багийн иргэдийн нийтийн хурлын хуралдаанд багийн Засаг дарга болон сумын удирдлагууд 650 хүнд зорилтот жилд хийх ажлын төлөвлөгөө болон хийж буй ажлын талаар танилцуулсан.<br>Зорилтот жилийн хүрээнд хийгдэж буй ажлыг иргэдэд сурталчилан таниулах зорилгоор 8 удаа мэдээлэл бэлтгэн Өвөрхангай Бүрд сумын Д.Пүрэвдоржийн нэрэмжит, аймгийн тэргүүний ЕБС цахим групп-д байршуулан ажилласан.<br>2023 онд багийн иргэдийн хурлаар Төрийн үйлчилгээний чанар бүтээмжийг нэмэгдүүлэх, байгаль орчны хууль тогтоомж, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролыг олон нийтэд сурталчлан. хэлэлцэж нээлттэй | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ярилцлага явуулсан. Нийт 360 оролцсон.<br>2024 онд Хог хаягдлын хаяхгүй байх анхааруулга самбар 16 ш хог хаягдал ихээр хаягддаг 9 газруудад байршуулж ажиллаа.<br>Мөн багийн хурлаар мод тарих зөвлөмж, хог хаягдлыг сумын төвлөрсөн цэгт хүргэж хэвших зэрэг мэдээлэл өгч ажиллаа. | | |
| 6 | | Сайн дурын байгаль хамгаалагчдын тоог нэмэгдүүлж тэдний чадавхжуулж, байгаль орчныг хамгаалах талаар иргэдтэй хамтран ажиллана. | 2020-2024 | ЗДТГ-ын байгаль орчин хариуцсан мэргэжилтэн | Орон нутгийн төсөв | Сайн дурын байгаль хамгаалагчгүй | хөдөөгийн баг тус бүрт сайн дурын байгаль хамгаалагчийг ажиллуулна. | 3,8 | | Сайн дурын байгаль хамгаалагчдын тоог 1-р багт 2 идэвхтэн байгаль хамгаалагч 2-р багт идэвхитэн байгаль хамгаалагч 1, 4-р багт идэвхтэн байгаль хамгаалагч 2, 3-р багт идэвхитэн байгаль хамгаалагч 2 хүнд нийт 7 үнэмлэх тэмдэг олгосон. | 90 | |
| 1 | Зорилт 3. Ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, хомсдол, доройтлыг зогсоох, нөхөн сэргээх ойжуулах замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх, зүй зохистой тогтвортой ашиглахад чиглэсэн | Ойжуулалт, төв суурингийн ногоон байгууламжид шаардлагатай тарьц, суулгацаар сумын хэрэгцээг бүрэн хангаан, ойжуулах ажлыг төсөл хөтөлбөрт хамруулах санаачлага гарган ажиллана. | 2021-2024 | ЗДТГ-ын байгаль орчин хариуцсан мэргэжилтэн | Орон нутгийн төсөв | тарьц суулгац бэлтгэдэггүй | ногоон байгууламжинд шаардлагатай тарьц суулгацыг өөрийн сумандаа бэлдэх эхлэлийг тавьж суулгацны 80 хүртэлх хувийг хангадаг болно. | 3,0 | | "Бат цэцэрлэгжилт" ХХК-тай хамтран 2 газар 1 га-д ойжуулалт хийсэн. Сумын төвд ургаж байсан модноос / улиас, бургас/ мөчир тайран авч мөчрөөр суулгац бэлтгэсэн нь сумандаа модны суулгацын нөөцтэй болох ажлын эхлэл байсан. Сумын хэмжээнд 2022 онп 100 гаран модны суулгац бэлдсэн. | 70 | |
| | | Ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, унанги мод цэвэрлэх, ой хамгааллын арга хэмжээ | 2021-2024 | ЗДТГ-ын байгаль орчин хариуцсан | Улс, орон нутгийн төсөв Төсөл, хөтөлбөр | | 2 га-д нөхөн сэргээлт хийнэ. | | | Бүрд сумын ойн сан 43,7045 га, тэлэн ургах талбай 25,8138 га, байна. Монгол улсын ерөнхийлөгчийн тэрбум мод тарих аяны хүрээнд сумын хэмжээнд 2022-2030 он хүртэл 1 сая мод тарихтай холбогдуулан "Бат цэцэрлэгжилт" ХХК болон бусад | 70 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | менежментийг бүрдүүлнэ. | авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн одоогийн байгаа түвшинг тогтвортой хадгалах нөхцөл бүрдүүлнэ. | | мэргэжилтэн | | Судалгаа хийгдэ эгүй | | 2,2 | | мод үржүүлгийн газар, өөрийн сумын нөөц бололцоог түшиглэн мод тарих ургуулах ажлыг үргэлжлүүлнэ.<br>2023 онд сумын төвд, 2024 онд Ар жаргалант 1 дүгээр багт Бургасны үзүүр гэх газарт ойн зурвас байгуулсан 1 га газарт 4036 ш мод тарьсан. /улиас, хайлаас, бургас/ Энэ онуудын Сумын 42 өрх 1192 мод тарьсан. | | |
| 3 | | Төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэн иргэн бүр нэг мод тарих аян өрнүүлж хамгаалалтыг сайжруулах . | 2021-2024 | Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн | Орон нутгийн төсөв Хувийн хөрөнгө Төсөл хөтөлбөр | Мод ТарьсаН Байгуу Ллага ААН – 6 Айл өрх- | Цэцэрлэгт хүрээлэнд 100-аас доошгүй , айл өрх албан байгууллага өрхийн гишүүд, албан хаагчдынхаа тоогоор шинээр мод бут тарьж тордож ургуулсан байна. | 3,0 | | 2021 онд Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “тэр бум мод” хөдөлгөөний хүрээнд 15 айл өрх, 3 байгууллага нийт 500 мод бут тарьсан. 2022 онд Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны бохирдлыг бууруулах зорилтот жилийн хүрээнд сумын иргэд, аж ахуйн нэгжүүд 5252 мод, бут тарьснаас ургалт 80 %-тай байна. Тус сумын 2 цэцэрлэгт хүрээлэн 2895 ш шинээр /гацуур, шинэс, нарс, чацаргана, хайлаас, улиас зэрэг/ мод бут шинээр тарьж ургуулж байна. Далай гүний хошууны Алтанхуяг ноёны удамыхан 173 ш, 2-р багийн нутаг “Ар булагийн дэнж”-д Балдангийн үр хүүхдүүд “Шинэс ойн төгөл” байгуулан шар хуайс 500ш, шинэс 100ш гацуур 2 буйлс 60 ш, нийт 662 мод тарин ургуулж байна.<br>2023 онд Аж ахуй нэгж, албан байгууллагууд нийт 1712 мод тарьсан. Үүнд:Эрүүл мэндийн төв 40 ш бургас, 10ш улиас, сургуулийн өмнөх боловсролын байгууллага 10 ш бургас, 10ш улиас, Соёлын төв 10ш улиас Бат цэцэрлэгжилт ХХК хандиваар тарьсан.<br>2024 онд Таван эрдэнэ цэцэрлэгт хүрээлэнд 30 ширхэг гацуур мод тарьсан. Эрхийн хугацаанд суурин газарт 8329 мод тарьсан байна. | 100 | |
| | | Иргэдийн байгаль | 2021-2024 | Байгаль | Орон Нутгийн | | байгаль хамгаалах | | 25 | Иргэдийн байгаль хамгаалах боловсрол мэдлэгийг дээшлүүлэх | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | | хамгаалах боловсрол мэдлэгийг дээшлүүлж, элсний нүүдэл ихсэж байгаа зарим газруудад мод бут, олон наст тарих аргыг турших эхлэх | | орчин хариуц лагын мэргэж илтэн | төсөв | | чиглэлээр 700 хүнд боловсрол олгоно, 3 га-д олон наст тарина. | 1,4 | | зорилгоор элсний нүүдлээс хамгаалах мод бут тарих мэдээлэлийг цахимаар болон танхимын сургалтуудыг хийсэн.<br>**2023 онд** сумын төвд 0,5 га газар цөлжилтийг сааруулах зорилгоор 860 бургас, 86 улиас, 1290 хайлаас тарьж ойн зурвас байгуулан нийт 2236 мод тарьсан. Сумын хэмжээнд 3818 мод тарьж, мод усалгаа арчилгааг тогтмол явуулж байна. Амьдралтын хувь 97 байна.<br>2024 онд Ар жаргалант 1 дүгээр багийн нутаг Бургасны үзүүр гэх газарт ойн зурвас байгуулж 0.5 га газарт 1800 ш мод тарьсан. Мөн БИН-ийн хурлаар мод тарих зөвлөмж өгч ажилласан. Сумын 30 өрх 320 мод тарьсан. | | |
| **4.2.Аялал жуулчлал** | | | | | | | | | | | | |
| 1 | Зорилт 1. Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | Зарим иргэдийг хөтөч, угтан үйлчлэгчийн зэрэг сургалтад хамруулж, нутгийн онцлогтой аялал жуулчлалыг хөгжүүлэн, бүтээгдэхүүн, үйлчилгээний, чанар, стандартыг сайжруулан жуулчдын тоог суурь түвшингээс 50 хувиар нэмэгдүүлнэ. | 2021-2024 | Байгаль орчин хариуц сан мэргэж илтэн | Орон нутгийн төсөв | Судалгаа төдийлөн байхгүй | жуулчин хүлээж авдаг айл өрхүүдийг хөтөч, угтагчийн сургалтанд хамруулна. 10 хүн | 2,1 | | Тус суманд гэрээрээ жуулчид хүлээн авдаг 9 айл өрхүүд байдаг. Тэдгээр айл өрхүүд нь жуулчид хүлээн авч гэр буудал ажилуулах, тэмээ, морь унуулах зэргээр жуулчдад үйлчилж байна.<br><br>Тус сумын түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг 28 гэрээт хамгаалагч хариуцдаг бөгөөд тэдэнд хамгаалалт болон аялал жуулчлалд үл хөдлөх дурсгалт газруудаа хэрхэн эргэлтэнд оруулах талаар мэдээ мэдээлэл өгч ажиллаж байна. | 70 | |
| | | Монголын нүүдлийн соёлын онцлогт | 2022-2024 | ЗДТГ-ын байгал | Иргэд ААН-ийн хөрөнгө | | | | | Монголын нүүдлийн мал аж ахуйн соёлын онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүнүүдийг 5-р багийн | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | | тохирсон брэнд бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж, аялал жуулчлалын эргэлтэд оруулан, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | | ь орчин хариуцсан мэргэжилтэн | | Байхгүй | Аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүнтэй болсон байна. | | | Д. Цэрэндолгор " Таван тансаг" нэртэйгээр үйлдвэрлэж, сумын иргэдэд төдийгүй жуулчидад зарж борлуулан өөрийн орлогыг нэмэгдүүлж байна. Цаашид санал санаачилга гаргаж байгаа иргэдийг дэмжин ажиллаж байна. Аялал жуулчлалын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр Тус сумын нутагт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг жуулчины бааз 2, гэр кейп 9 байна. Sweet gobi жуулчины баазад 1 эвент арга хэмжээ зохион байгуулсан. /Од харангаа жаз хөгжим сонсох / | | |
| 3 | | Тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, даацад тулгуурласан эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | 2021 | ЗДТГ-ын байгаль орчин хариуцсан мэргэжилтэн | ААН -ийн хөрөнгө | 2 | ширээт цагаан нуур, мөнгөн булаг орчим эко аялал жуулчлал хөгжүүлнэ. | 6,2 | | 3-р багийн нутагт орших тусгай хамгаалттай газарт нутагладаг 9 айл өрх зуны улиралд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж өөрийн орлогоо нэмэгдүүлэн ажиллаж байна. | 70 | |
| 4 | | Аялал жуулчлалыг дараах маршрутаар хөгжүүлнэ. Өндөр гэгээн Занабазарын түүхэн замналаар аялах машрут: Элсэн тасархай – Их, бага Монгол уул - Ширээт цагаан нуур –Дуут манхан- Мөнгөн булаг- Монгол орны төв цэг, | 2021-2024 | ЗДТГ-ын байгаль орчин хариуцсан мэргэжилтэн | ААН жуулчины бааз, иргэдийн хөрөнгө | 2 Жуулчны бааз | Маршрут эргэлтэнд орсон байна. | | | Элсэн тасархай, Их бага Монгол уул, Ширээт цагаан нуур, Дуут манхан, Мөнгөн булаг, Монгол орны төв цэг зэрэг тус сумын аялал жуулчлал маршрутаар жуулчид зорин аялах нь нэмэгдсэн. Сумын нутаг дэвсгэрт 2 жуулчины бааз үйл ажиллагаа явуулж байна. Баянговь жуулчины баазад жилд дунджаар дотоод гадаадын 1000 орчим жуулчин ирж амарсан. SWEET GOBI жуулчины баазад 600 гаран гадаад ,дотоодын жуулчин хүлээж авсан.<br><br>Монгол Улсын төв цэгт "Гал голомт цогцолбор" төсөл хэрэгжүүлэхээр Улсын Их Хурлын гишүүдэд хандсан. | 90 | |
| 5 | | Аялал жуулчлалын гол чиглэл дагуу дэд бүтцийг хөгжүүлж, | 2023-2024 | ЗДТГ-ын байгаль орчин хариуцсан | | | Шинээр байгуулагдсан отоглох цэг, үйлчилгээний цогцолборын тоогоор | | | Тус сумын нутагт байрлах Их боригдойн 2-р багийн төвөөс баруун тийш 1 км орчимд байрлах Алтан шар зам дууны хөшөөний дэргэд аймгийн ӨВАЗЗАТӨХХК-тай хамтран цэцэрлэгт хүрээлэн, авто машины | 70 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | отоглох цэг, авто зам дагуу үйлчилгээний цогцолбор байгуулах иргэдийн санал санаачлагыг дэмжиж ажиллана. | | мэргэж илтэн | | | | | | зогсоол зэргийг байгуулж байна. Зам дагуу ногоон байгууламж байгуулж байгаа тул усалгааны асуудлыг сум хариуцаж худаг гаргахад нь 10 сая төгрөг зарцуулсан. | | |
| 6 | | Байгаль, түүх, соёл, мал аж ахуй, танин мэдэхүйн чиглэлээр орон нутгийн аялал жуулчлалын сүлжээ бий болгож, түүнд түшиглэсэн соёлын үйлдвэрлэл, брэнд бүтээгдэхүүн бий болгоно. | 2021-2024 | ЗДТГ-ын байгаль орчин хариуцсан мэргэжилтэн | Орон нутгийн төсөв | | Соёлын чиглэлээр шинэ брэнд бүтээгдхүүн бий болгож хамтарч ажиллана | | | Тус сумын 3-р багийн зарим иргэд жуулчдад тэмээ болон морь унуулах, гэр түрээслэх, хийсэн гар урлал, айраг, сүү цагаан идээ, бүтээгдэхүүнээ борлуулах, үндэсний спорт болох нум сум харвуулах зэрэг үйл ажиллагаа явуулж байна. Сумын айраг аймгийн брэнд бүтээгдэхүүн болов. Аймагт Б. Цэрэндолгор нь цагаан идээний үзэсгэлэн худалдаанд оролцож бүтээгдэхүүнээ борлуулсан. 2-р багийн малчин Ц. Дашдэмбэрэл айрагны хөхүүр захиалгаар хийж борлуулсан байна. Сур суран эдлэл М. Наранцацралт, Н. Цэрэндолгор сүү цагаан идээ үйлдвэрлэн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж байна. З.Наранцацралт, Г.Буманбаяр нар сур суран эдлэл, хөхүүр хийж борлуулдаг. | 90 | |
| **Бүлгийн дүн :/ 18 арга хэмжээ/** | | | | | | | | | | | **84,4** | |
| **Нийгмийн бодлого** | | | | | | | | | | | **84,5** | |
| **Эдийн засаг** | | | | | | | | | | | **83,2** | |
| **Засаглал** | | | | | | | | | | | **88,4** | |
| **Бүгд** | | | | | | | | | | | **85,1** | |

НЭГТГЭСЭН: ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.ГАЧМАА

Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ /2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/

| ХБТББ-т тусгагдсан Зорилт, үйл ажиллагаа | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Нийт хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/ 2024 он | | | Хүрсэн үр дүн | Хэрэгжилтийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | ТГ | ИТХ |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| **НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ** | | | | | | | | | | | | |
| **1.1.ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ** | | | | | | | | | | | | |
| Зорилт 1. Эх хэл, соёл, ёс заншлаа дээдэлсэн эх оронч үзэлтэй эв нэгдлийг эрхэмлэсэн иргэнийг төлөвшүүлэн хөгжүүлж, түүх, соёлын өвөө хамгаалан, үндэсний бахархлаа түгээн | 1 | Уламжлалт монгол ахуй, өв соёлоо сэргээн хөгжүүлэх, угийн бичгийн бүх нийтээр хөтөлж хэвших, сургалт мэдээллийн ажлуудыг зохион байгуулна. | 2021 2024 | Соёлын төв | Орон нутгийн төсөв | 20 хувь /Угийн бичиг хөтөлсөн айл өрхийн хувь/ | 60 хувь нэмэгдүүлэх/ ургийн бичиг хөтлөх өрхийн хувь/ | 0,4 | 0.4 | 2021-2024 онд Биет бус өв болох уртын болон богины дуу,ерөөл, магтаал, монгол ардын бүжиг, уул усны тахилга зэргийг 5 удаа цахим видео хийж 2145 хүнд хүрсэн байна. Угийн бичиг хөтлөх үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд байгууллага бүрд цахим сургалт зохион байгуулж, сургалтад нийт 106 албан хаагч хамрагдав. Мөн БИНХурлуудад угийн бичиг яаж хөтлөх талаар заавар зөвлөмж тарааж, суртчилан таниулсан. Нийт 5 багийн 205 иргэн хамрагдсан. Угийн бичгийн сургалтын төрийн 4 байгууллага, 2 аж ахуй нэгжийн 75 албан хаагч, албан байгууллага аж ахуй нэгжүүдийн дунд "Дээлтэй | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| дэлгэрүүлж, соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | монгол” уралдаан зохион байгуулж нийт 125 хүн хамруулсан. Төрийн албан хаагчдын 53 хувь угийн бичиг хөтөлсөн. Сумын нийт иргэдийн 412 хүн буюу 17 хувь нь угийн бичиг хөтөлсөн байна.”Монгол бичиг бидний бахархал” сэдэвт 8- р ангийн сурагчдын монгол бичгээр хичээнгүй бичсэн нутгийн зохиолчдын шүлгийн үзэсгэлэн гаргасан.Байгууллага дотроо монгол бичгийн хичээлийн анхан шат болон дунд шатны сургалтыг зохион явуулсан. | | |
| | 2 | Соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулна. | 2020 2024 | Соёлын төв | Орон нутгийн төсөв | 50 үл хөдлөх дурсгалт зүйл хамгаалагдсан | Соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах, малчин иргэдтэй гэрээ байгуулан урамшуулал олгосоноор дурсгалт зүйл устаж үгүй болох гадны халдлагаас урьдчилан | 12,0 | | 2021-2024 онд “Цахим соёл”, “Соёлын өв-Хөгжлийн дархлаа”, цахим хуудас дээр нийт 6 бичлэг хийж нийт 2500 гаруй хүнд хүргэсэн. Бүрд соёлын төв фейсбүүк хаяг дээрээ орон нутаг судлах танхимын үзмэрүүдийг видео бичлэг хийж ард иргэдэд хүргэсэн.<br>“Уртын дуугаа дээдлэн дэлгэрүүлцгээе” аяны хүрээнд “Оломгүй далай” уртын дууг 50 гаруй иргэд сурсан.<br>Сумын нутагт байгаа 28 үл хөдлөх биет өв хамгаалагчдын гэрээг шинэчлэн хийж, хамгаалагчдыг үнэмлэхжүүлсэн. Биет өвүүдийн хамгаалалтын хайс хашааг сэлбэн засварлав. Үл хөдлөх дурсгалын улсын тооллого амжилттай явууллаа. 14 үл хөдлөх дурсгалыг бүртгэлжүүлсэн.<br>2023 оны 9 сард соёлын биет бус өвийн улсын тооллого цахимаар бүртгэсэн. 2024 онд соёлын биет бус өв өвлөн тээгч 11 хүний 2 нь шилжиж, нэмж 2 хүнийг соёлын биет бус өвийг өвлөн тээгчээр бүртгэсэн. “Соёлын өв-хөгжлийн дархлаа” ,Бүрд сумын | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сэргийлсэн байх | | | Соёлын төв цахим хаягуудаар байгууллагын үйл ажиллагаа, соёлын өвийн хадгалалт хамгаалалт, өв хамгаалал, үйл ажиллагааны тайлан контент, шторк, мэдээлэл байршуулан 4715 иргэдэд хандаж мэдээлэл авсан байна. | | |
| | 3 | Орон нутгийн судлах танхимыг засварлан тохижуулж, үзүүлэн дэглэлтийг хийж, үзмэрийн тоог нэмэгдүүлж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг тогтмолжуулна. | 2020 2024 | Соёлын төв | Орон нутгийн төсөв | Музейгээр үйлчлүүлсэн хүний тоо | Музейн хашаан дотор тохижилт хийх, орон нутаг судлах танхимыг зориуллтын дагуу тохижуулж,үзүүлэн дэглэлт хийж үйлчлэх орчинг бүрдүүлэх | 2,0 | 8,1 | 2021-2024 онд Орон нутгийн судлах танхимын сум суртчилах танхимыг орон нутгийн хөгжлийн сангийн 7,600 мян/төгрөгөөр дээвэр болон дотор заслыг хийсэн. Мөн музейн хашаан доторх амьтдыг сэргээн засварлахад 2-р багийн малчин А. Батбаатар 500,0 мян/төгрөг хандивласан. Орон нутаг судлах танхимын үүсгэн байгуулагчийн 100 насны ойг тохиолдуулан ерөнхий боловсролын сургуулийн түүхийг багштай хамтран нийт 150 хүүхдийг орон нутаг судлах танхимтай танилцуулах аялал хийлээ. | 90 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 4 | Дашравжайлан хийдийн барилгат их засвар хийж, тогтвортой үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлнэ. | 2021 2024 | Соёлын төв | хандив | Хуучин барилгатай | Үйл ажиллагаа тогтмолжсон байна. | 80,0 | 80,0 | Сумын 90 жилийн ойг угтсан бүтээлч ажлын хүрээнд Дашравжайлан хийдийн барилгад Аргай овогт Чүлтэм, Харваач овогт Ойдов, Дамирангийн Цэвэгжав нарын үр хүүхдүүд ач зээ нарын хандив тусламж болон сумын иргэдийн хандив нийтаар 80 сая / сумын иргэдийн хандиваас 30 сая/ Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлөөс 50 сая / төгрөгөөр засварласан. Нээлтийн үйл ажиллагааг 2022 оны 09 дүгээр сарын 24 -нд ёслол төгөлдөр зохион байгуулсан. Нээлтийн үйл ажиллагаанд Наро банчэн гэгээнтэн ирж иргэдэд хандаж ном айлдсан. Уг арга хэмжээнд 500 гаруй иргэд оролцсон байна. Барилгын засвар хийх, нээлтийн бүх ажиллагааг нутгийн зөвлөлөөс Ч. Баярсайхан хурандаа хариуцаж нутгийн удирдлагуудтай иргэдтэй хамтран гүйцэтгэсэн байна. | 100 | |
| Зорилт 2. Соёл, урлагийн байгууллагын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, соёлын үйлдвэрлэлийг дэмжих замаар | 1 | Соёл, урлагийн нэгдсэн арга хэмжээ, уралдаан, наадам зохион байгуулан, хүүхэд залуучууд, ардын авьяастнуудын авьяас билгийг нээн хөгжүүлж, түгээн дэлгэрүүлнэ. | 2020 2024 | Соёлын төв | Орон нутгийн төсөв | Арга хэмжээний тоо 2 | Хөгжим бүжиг дууны дугуйланг уудыг хичээллүүлж хүүхэд залуучуудын авъяасыг хөгжүүлэн иргэдэд урлаг соёлоор | 8,0 | | Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан 2022 онд “Бүсгүй цэцэг” хөтөлбөрт цэнгүүн, 2023 онд “Бүсгүй минь чи инээмсэглэж яваарай” хөтөлбөрт цэнгүүн тус тус зохион байгуулсан. Жил бүр энэ арга хэмжээнд 80-100 иргэн оролцсон байна.<br><br>2023 онд “Сумын бүжиг-2023” аяны хүрээнд Өвөрхангай аймгийн “Зөв цаг” бүжгийн клубтэй хамтран 7 хоногийн сургалт зохион байгуулж, нийт төрийн 102 албан хаагч, иргэд хамрагдаж Өвөрхангай аймагтаа “ Шилдэг сум”-аар шалгарсан. | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| үйлчилгээн ий чанар, хүртээмжий г өргөжүүлэн, мэргэжлийн хүний нөөцөөр хангана. | | | | | | | үйлчилнэ 2 удаа | | | “Яруу эгшиглэн” хүүхдийн урлагийн наадмыг анх удаа зохион байгуулж төрөл тус бүр дээр аваргуудыг шалгаруулав. Аймгаас зохион байгуулсан “Эх орон танаа” цэргийн дууны уралдаанд жил дараалан амжилттай оролцож Ц. Даваадорж 1, 3-р байр, “Хаврын баяр -2023 бүжгийн их наадамд ардын бүжгийн дунд насны ангилалд О. Оюунсайхан тусгай байр эзэлсэн.<br>Аймгийн аварга шалгаруулах спорт бүжгийн тэмцээнд Ц. Энхцэцэг багштай бүжгийн хамтлаг мөнгө, хүрэл медаль хүртсэн байна.<br>Жил бүр төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд “Авьяаслаг Бүрдчүүд” урлагийн наадмыг зохион байгуулж хэвшсэн.<br>2024 онд тэмдэглэлт баяруудаар үйл ажиллагаа зохион байгуулж, 5 тоглолт , 7 уралдаан тэмцээн зохион байгуулсан байна. Дууны болон бүжгийн дугуйланд нийт 65 хүүхэд хамрагдаж байна. | | |
| | 2 | Соёлын төвийн гадаах талбайг хайсжуулж, ногоон байгууламж бий болгох, шаардлагатай дуу,гэрэлтүүлэг, техник тоног төхөөрөмж, хувцас хэрэгслээр хангаж, мэргэжлийн танхимуудыг тохижуулж, үйл ажиллагааг тогтмолжуулж, хөрөнгө | 2021 2022 | Соёлын төв | Улс, аймаг орон нутгийн төсөв хандив | Шинэ Барилга тай болсонт ай аа тай | Соёлын төвийн гадаах талбайн тохижилт, ногоон байгуула мж, урлагын хувцас хэрэглэл ээл хангагдса н байх, | | 64,8 | Сумын соёлын төвийн гадаах талбайны хайсыг орон нутгийн хөгжлийн сангийн 10 сая төгрөгөөр студийн тоног төхөөрөмж нийт 17,500.000 төгрөгний /канон камер 24-105 дуран, камерийн дагалдах, суурин компьютер, компьютер дэлгэц, зөөврийн хард, видео гэрэл, микрофон, гэрэл ойлгогч/ хэрэгсэл худалдан авсан байна.<br>Улсын төсөв хөрөнгө оруулалтаар 20 сая төгрөгний техник хэрэгсэл, аймгийн засаг даргын шийдвэрээр 14 ширхэг лед гэрэл, сумын 90, 91 жил, сургуулийн 80 жилийн ойг | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | оруулалтыг нэмэгдүүлнэ. | | | | | Урлагын хувцас хэрэглэл ээр хангагдсан байх | 30,0 | | тохиолдуулан төгсөгчдийн хандиваар дуу бичлэгийн студи тоног төхөөрөмж, 2 ширхэг мак гэрэл зэрэг 10,900,0 мянган төгрөгний тоног төхөөрөмжтэй болсон. Бүжгийн хувцас 16ш дээлийн үнэ 3,840,0 мянган төгрөг нутгийн зөвлөлийн хандиваар, 16ш гутал сумын соёлын төвийн төсвийн хөрөнгө 1,568,0 мянган төгрөгөөр худалдан авсан байна 2023 онд соёлын төвийг гадна талбайд 12 ширхэг мод тарьсан. Арын хувцас солих өрөөний 2 цонхонд 2 ширхэг хөшиг авч хийсэн. Ажилчдын амрах өрөөг тохижуулсан. | | |
| | 3 | Иргэдэд зайны болон нүүдлийн соёл урлагийн үйлчилгээг жил бүр хүргэж, сумын соёлын төвийг соёлын өв хариуцсан ажилтантай болгоно. | 2021 2024 | Соёлын төв | Орон нутгийн төсөв | | Багийн өдөрлөг БИНХ-ын дараа нүүдлийн номын сан, соёлын үйлчилгээ үзүүлэх | 0,8 | | 2022, 2023, 2024 онуудад сумын ЗДТГ-тай хамтран 5-н багийн иргэдийн дунд урлаг, спортын наадам зохион байгуулсан. Улсын аварга малчдын цолны наадмын үйл ажиллагаанд зориулан урлагийн тоглолт үзүүлсэн. Наадамд тус бүрд 200 гаруй иргэд оролцсон байна. БИНХ- аар нийт 5 багийн хуралд оролцож нүүдлийн номын сан болон угийн бичгийн сургалт хийлээ. | 90 | |
| | 4 | Сумын соёлын төвийн хүний нөөцийг бэлтгэн мэргэжлийн боловсон хүчнээр хангах. | 2021 2024 | Соёлын төв | Хувийн зардал | 5 Бүтэц, орон тоо | Хөгжим, бүжгийн багш, номын санчнарыг мэргэжлийн сургуульд суралцуулан мэргэжлийн боловсонхүчнээр хангагдсан байна. | | | Хөгжмийн багш Си Ти дээд сургуулийг хөгжмийн багшаар, бүжгийн багш Глобал удирдагч их сургуульд цахимаар болон танхимаар хосолсон сургалтаар суралцаж байна.<br>2024 онд бүжгийн багш болон номын санчийг мэргэжил дээшлүүлэх сургалтанд бүжгийн багш 2 удаа номын санч 1 удаа хамрагдсан. Соёлын төв хөгжмийн багшийн сул орон тоонд СИТИ дээд сургуулийн төгсөх ангийн оюутанг авч ажиллуулж байна. | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 5 | Ном, соёлын үйлчилгээний оновчтой хэлбэрийг бий болгож, номын санг цахим болгон, фондод баяжилт хийнэ. | 2021 2024 | Соёлын төв | Орон нутгийн төсөв | 7545 номыг цахим бүртгэлд оруулсан | номын сангийн үйлчилгээ сайжирч, цахимжин, жил бүр номын баяжилт хийгдсэн байна. | 1,2 | 3,6 | Номын сангийн фондод байгаа нийт 7545 номыг цахим бүртгэлд оруулж уншигч олонд хүргэн үйлчлэж байна. 700 иргэнд 1172 ном уншуулсан. Шинээр номын фондод сүүлийн үеийн уран зохиолын болон хүүхдийн үлгэрийн нийт 153 ширхэг номоор баяжууллаа. Сум байгуулагдсаны 90-н жилийн ойн баяраар төгсөгчдийн 1,533,0 мянган төгрөгний хандиваар хүүхдийн болон танин мэдэхүйн 74 ширхэг номтой болсон. “Алаг адуу” ТББ -аас 1,500,0 мян/ төгрөгийн үнэлгээтэй ном хандивласан. Сумын номын санд шинээр 500,0 мян/төгрөг зарцуулсан. 2023 онд 70 мян төгрөгөөр номын баяжилт хийсэн. Ардын уран зохиолч Д. Пүрэвдоржийн мэндэлсний 90 жилийн ойг тохиолдуулан Пүрэвдорж сангаас ном бэлэглэсэн.<br>2024 онд Номын фондыг 500.000 төгрөгийн нийт 23 ширхэг шинэ хүүхдийн номоор баяжилт хийсэн. | 100 | |
| | 6 | Соёлын ажилтнуудыг хөрш зэргэлдээ болон бусад аймаг, суманд туршлага судлуулах, сургалтанд хамруулж, чадавхижуулна | 2021 2024 | Соёлын төв | Орон нутгийн төсөв | 1 арга хэмжээ | соёлын ажилтануудыг жил бүр уламжлан зохион байгуулагддаг бүсийн сумдын соёлын ажилтанудын нөхөрсөг уулзалт урлаг | 0,9 | | 2021 онд Соёлын ажилтнуудын туршлага солилцох арга хэмжээг Хайрхандулаан суманд болж уг арга хэмжээнд байгууллагын ажилтан албан хаагчид бүрэн хамрагдсан. 2022-2023 онд Зүүн бүсийн Соёлын төвүүдийн нөхөрсөг уулзалт арга хэмжээ Өлзийт суманд 2 удаа зохион байгуулагдаж спорт, урлагийн арга хэмжээнд амжилттай оролцож спортын төрөлд багийн дүнгээр 2 удаа 1-р байр эзэлж шилжин явах цом гардан авав.<br>2024 онд Зүүн бүсийн соёлын төвүүдийн нэгдсэн арга хэмжээг сумандаа зохион байгуулж 6 сумын 34 | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | спортын арга хэмжээнд хамрагдаж оролцож байх | | | албан хаагчид “Бид соёлынхон” урлагийн нэгдсэн тоглолт мөн спортын 3 төрөлтөөр амжилттай өрсөлдлөө. Баян-өндөр суманд зохион байгуулсан Зүүн бүсийн соёлын төвүүдийн нэгдсэн арга хэмжээнд байгууллага хамт олноороо амжилттай оролцов. | | |
| | 7 | “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II” арга хэмжээг хэрэгжүүлж, соёл, урлагийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | 2020 2024 | Соёлын төв | Орон нутгийн төсөв | 1 Арга хэмжээний тоо | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарагн хэрэжилт бүрэн хэрэгсэн байна. | | | 2022 онд Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II -ийн хүрээнд “Эрийн хийморь” морь бөх цоллоочдын анхдугаар уралдааныг сумандаа зохион байгуулсан. Шинэ номын үзэсгэлэн танилцуулга гаргаж иргэдэд үйлчилсэн. Биет бус өвлөн тээгч 2 хүнийг шинээр бүртгэсэн. Сур суран эдлэл 1, мал маллах арга ухаан 1 биет бус өвлөн тээгчээр бүртгэсэн. 2023 онд дуу хөгжмийн багш Д.Азжаргал сумын залуу уран бүтээлчидтэй хамтран “Их голомт нутаг” тоглолтоо зэргэлдээ 3 суманд амжилттай тоглосон, бүжгийн багш Ц.Энхцэцэг “Амьдрал яасан сайхан юм” тайлан тоглолтоо сум орон нутагтаа тоглолт зохион байгуулсан. Малын арьсыг элдэж татлагын сур, хурган дээл хийж өрхийн орлогоо нэмэгдүүлсэн. | 90 | |
| | 8 | “Сонгодог урлаг-III” хөтөлбөрийг өөрийн сумандаа хэрэгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. | 2021 2024 | Соёлын төв | Орон нутгийн төсөв | 1 | Хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн урлагы байгууллага, уран бүтээлчтэй хамтран жилалсан байна. | | 0.3 | Дуу хөгжим, бүжгийн дугуйлангийн сурагчдад сонгодог урлагийн талаар сургалт явуулж сонгодог урлагийн сор бүтээлүүдийн талаар анхан шатны ойлголт өгөв. Соёлын сэргэлт -2023 аяны хүрээнд “Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Монгол хүний ондоошил” сэдвээр хүүхэд, насанд хүрэгчдийн дунд 2 удаа илтгэл тавьсан. Нийт 250 хүн оролцсон байна. | 70 | |

| 1.2. Эрүүл мэнд | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | 1 | Зорилтот насны иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг, хорт хавдрын 7 төрлийн илрүүлгийн үзлэгт хамруулна. | 2021 2024 | ЭМТ | Улсын төсөв | Нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь-100 | 100%-д хүргэн бүрэн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах | 3,75 | | Эрхийн хугацаанд хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт 1342 хамрагдахаас 744 хамрагдаж 55,4 % , Чихрийн шижингийн үзлэгт 806 иргэн хамрагдахаас 744 хамрагдаж 92,3%, Хөхний өмөнгийн эрт илрүүлэгт 721 хамрагдахаас 668 хамрагдаж 92,6%, Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн шинжилгээнд 118 эмэгтэй хамрагдахаас 74 эмэгтэй хамрагдаж 62,7 %-ын тус хамрагдалттай явагдаж байна. | 90 |
| | 2 | Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүл арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. | 2021 2024 | ЭМТ | Улсын төсөв 300 | 40 удаа | Жил бүр 40-55 удаагийн сургалт сурталчилгаа өгөх | 0,9 | | 1.Засгийн газрын баталсан 224-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдээр зохион байгуулах ажлын төлөвлөгөө жил, сараар гаргаж Зорилтод бүлгийн иргэдрүү чиглэсэн 4 удаагийн сургалт өдөрлөг зохион байгуулсан. “Хөдөлгөөн эрүүл мэнд” Зохистой хоололт, “Дэлхийн усны өдөр”,Сүрьеэ өвчнөөс сэргийлье “Архи тамхины-хор хөнөөл”, зэрэг сэдвээр эрүүл мэндийн цахим сурталчилгаа хийж хандалтын тоо-650 өдөрлөг 4 удаа зохион байгуулсан Нийт давхардсан тоогоор 324 иргэн хамрагдсан байна. Томуу, томуу төст өвчнөөс сэргийлье”- “ БЗХӨ сэргийлье” ”Зохистой хооллолт эрүүл мэнд” “Цусны даралт ихсэх өвчнөөс сэргийлье” “Осол гэмтэл-Хөлдөлт,Түлэгдэлтээс сэргийлье” сэдвүүдээр сумын 8 грүпп чатаар цахим сургалт болон танхимын 2-н удаагийн сургалт хийж давхардсан тоогоор 160 иргэдийг | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хамруулан цахим хандалт 4986 байна.<br>2. Нийтийг хамарсан “Идэвхитэй хөдөлгөөнийг эрхэмлье” спортын арга хэмжээ зохион байгуулж 156 иргэдийг хамруулсан. Мөн гарын авлага зөвлөмжийг 5-6 төрлөөр боловсруулж 350ш түгээсэн байна.<br>3.Сумын хүн амын дунд Эрт илрүүлэг үзлэгт хамрагдаагүй иргэдийн 5-р сард УБ хотоос ирсэн “Нүүдлийн эмнэлэг”-тэй хамтран эрт илрүүлэг үзлэгт 156 иргэд 10-р сард БОЭТ-ийн эмч нартай хатран 80 ахмадуудыг хамруулж эрүүл мэндийн зөвөлгөө тусламж өгч ажилласан байна.<br>4. Олон нийтийн Эрүүл мэндийн ажилтанг бэлтгэж иргэдэд чиглэсэн сургалт сурталчилгааг” “Сүрьеэ өвчнөөс сэргийлье” “ Идэвхитэй хөдөлгөөн –Эрүүл мэнд” сургалтуудыг хийж 98 иргэдийг хамруулж зөвлөмж тараах, мэдээлэл хүргэх ажлыг тогтмол хамтран хийж байна. | | |
| | 3 | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, өвчлөлийг бууруулна. | 2021<br>2024 | ЭМТ | Улсын төсөв | Урьдчил сан сэргийлэ х үзлэгт хамрагд сан хувь | Халдварт өвчингүй гараагүй байх | 0,8 | | Сүрьегийн эрт илрүүлэг үзлэг оношлогоог Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төслийн хүрээнд Монголын Сумын Эмч, Мэргэжилтнүүдийн Холбоотой хамтран ЭМТ-өөс сүрьеэгийн сорцыг БОЭТ-ийн лабораторт умайн хүзүүний эсийн шинжилгээтэй хамт 9 сорьцыг зөөвөрлөн ажиллаа.Сорьцын хариу сөрөг гарсан байна. | 90 | |
| | 4 | Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжиж ажиллана. | 2021<br>2024 | ЭМТ | | Жирэмс ний хяналт 93,7 хувьтай | Жирэмсэ н эхийн хяналтыг 96 хувьд хүргэх | | | Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжилтэд дүгнэлт хийн ажиллаж байна. Нөхөн үржихүйн 15-49 насны 765 эмэгтэйчүүдийн судалгааг шинэчлэн | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 15000 Улсын төсөв | | | 0,5 | | гаргаж шилжилт хөдөлгөөний хяналтыг тогтмол хийж байна. эндэгдэл гаргаагүй ажилласан. 2021 онд жирэмсэний хяналтанд 39 эхийг авч эхийг эхний 3 сарын хяналтанд авч эхний сартай жирэмсэн хяналт 92,3%- тай байгаа бөгөөд БОЭТ -д 12 эх, сумын ЭМТ-8 эх, ЭХЭМҮТ,болон өөр аймаг суманд -10 эх эсэн мэнд амаржсан.<br>2022 онд эх нярайн эндэгдэл гаргаагүй ажилласан. Жирэмсэний хяналтанд 44 эхийг авч эхийг эхний 3 сарын хяналтанд авч эхний сартай жирэмсэн хяналт 90,2%- тай байгаа бөгөөд БОЭТ -д 25 эх, сумын ЭМТ-11 эх, ЭХЭМҮТ,болон өөр аймаг суманд -9 эх эсэн мэнд амаржсан. 2023 онд жирэмсний хяналтанд жирэмсний эхний 3 сарын дотор 27 эх хяналтанд орсон байна. Жирэмсний эрт үеийн хяналт 92% байна. 2023 онд 34 эхийг хяналтад авсан 3 сарын хяналт 94.1%, БОЭТ-17 суманд -5 өөр газар 17 эх төрсөн байна.<br>2024 онд 1 нярай эндсэн, 27 эх хяналтанд орсноос БОЭТ-17 суманд -2 өөр газар -8 төрсөн байна.<br>Хугацаа хэтэрсэн 2 жирэмсэн эх хяналтанд орсон байна. Өвчтэй илэрсэн 86 эмэгтэйг эмчилсэн. | | |
| | 5 | Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн үзлэгийг жилд нэг удаа зохион байгуулна. | 2021 2024 | ЭМТ | | Цэргийн насны 112- 74 хамрагдсан | Бүр эн хамруулах, эрүүл мэндийн шалтгаанаар оролцогчдын 20% нь | | | 2022 оны цэрэг татлагаар нийт 128 цэргийн насны залуучууд хамрагдахаас 92 залуу оношлогоо шинжилгээнд хамрагдсан байна.<br>2023 онд цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг дэмжих, эрүүлжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлж, эрчимжүүлэлтийн хувь урьд оноос 20- | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | | | | Улсын төсөв | | чөлөөлөгдсөн байх | | | иос доошгүй хувиар нэмэгдүүлсэн. Цэргийн насны 120 залуучууд хамрагдахаас 92 хамрагдсан. Анхан шатны ЭМТ-д эмчлэн эрүүлжүүлэх боломжтой 78 залууг эмчлэн эрүүлжүүлсэн байна.<br><br>2024 онд цэрэг татлагаар 110 цэрэг орохоос 80 залуу цэргийн үзлэгээр орж эрүүл мэндээр тэнцсэн 41, цэрэгт татагдсан -5, бусад эрхтэн тогтолцооны эмгэгээр 38 залуу өвчилсөн байна. Тайван цагт цэргийн албанд тэнцээгүй -1 Багийн эмч нарт нэрсийг өгч эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна | | |
| Зорилт 2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний орчин үеийн оношилгоо, | 1 | Сумын эрүүл мэндийн төвийн лабораторийн шинжилгээний аппаратуудыг шинэчлэнэ. (Цус болон шээсний анализатор) | 2021 2024 | ЭМТ | 2000<br><br>Улс, орон нутгийн төсөв | Шээсний Анализат -ортой болсон | Шээсний аналикатор, цусны ерөнхий шинжилгээ, хүзүүний татлага, нурууны татлагын аппарттай болох | 10,0 | 12,250 | Эмнэлэгт лаборторийн тоног төхөөрөмж хангалттай байна Лабораториор Цусны ерөнхий шинжилгээ Шээсний ерөнхий шинжилгээ Биохими- элэгний үйл ажиллагаа бөөрний үйл ажиллаагаа нойр булчирхайн үрэвсэл цусан дахь сахар Иммунологийн анализатортой болсон. Сахарын дундаж, витамин Д, үений үрэвсэл, бамбай булчирхайн Т3-Т4 зэргийг 2025 оны 01 сараас үзэхээр төлөвлөн ажиллаж байна. | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| эмчилгээний технологийг нэвтрүүлнэ. | 2 | Эрүүл мэндийн салбарт эмнэлзүйн олон улсын стандарт UpToDate платформ, бүртгэл, хяналтын цахим тогтолцоог нэвтрүүлэн, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2021 2024 | ЭМТ | Улсын төсөв 15000 | - | Up To Date-ын платформ, бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүртгүүлнэ. | 15,0 | | Хэрэгжээгүй | 0 | |
| Зорилт 3. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бүрдүүлж, мэргэшүүлэн, чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ. | 1 | Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хангах, боловсон хүчинг тогтвор суурьшилтай ажиллуулахад дэмжлэг үзүүлнэ. | 2021 2024 | ЭМТ | Улс, орон Нутгийн төсөв | Дэмжсэн хүний тоо- | Уламжлалтын их эмч, эх баригч, хүний их эмчийг тогтвор суурьшилтай ажиллуулсан байна. | 3,0 | 6,0 | ЭМТ нь 18 ажилтантай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Багийн эмч 2, эх баригч 1 дутуу байна.<br>2023 оны 7 сараас нэг их эмчийг авч ажиллаж байна. Эмчийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор 1 багийн эмчийг их эмчийн сургуульд цалинг нь олгож, сургалтын төлбөрийн дэмжлэг сумаас олгон сургаж байна. Мөн үйлчлэгчээр ажиллаж байсан хүнийг ээлжийн сувилагчаар бэлдэн мэргэжлийн сувилгчаар нэмсэн.<br>Эмчийн байранд 2019 онд их засвар, 2020 онд дулааны шугамтай холбож амьдрах орчинг сайжруулсан байна. | 100 | |
| | 2 | Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын улирлын урамшуулал, ур чадварын нэмэгдлийг | 2021 2024 | ЭМТ | Улсын төсөв | Улирлын урамшуулал, ур чадварын нэмэгдүү | Ажилчдын үр дүнгийн урамшууллалыг | 24,0 | | ЭМТ-ийн эмч эмнэлгийн мэргэжилтэн ажилчдын ажлыг сар бүр дүгнэн ажлын ачаалалтай уялдуулан улирлаар нь үр дүнгийн урамшуулал болон ур чадварын нэмэгдлийг олгож | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тэдгээрийн харилцаа, хандлага, ёс зүйн үнэлгээтэй уялдуулан олгодог тогтолцоонд шилжүүлнэ. | | | | лэх, үйлчилгээний менежментийг сайжруулсан байгууллагын тоо-0 | нэмэгдүүлж | | | байна. Ажлыг дүгнэхдээ ажилтан бүрээр хийсэн ажлын тайланг бичүүлж ажлын байранд хяналтыг дотоод хяналтын баг хийж удирдалгын баг, чанарын багт тайлагнаж байна.<br>Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолыг үндэслэн эрүүл мэндийн төвийн ажиллагсадад улирал бүр үр дүнгийн урамшуулал, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг үндэслэн олон жил ажилласан 5 ажилтандаа ур чадварын нэмэгдлийг олгосон байна. | | |
| Зорилт 4. Эрүүл мэндийн төвийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ | 1 | Сумын эмчийн байрны гадна талд тохижилт хийнэ. | 2021 2024 | ЭМТ | Орон нутгийн төсөв | байртай | Хайс, жорлон, муу усны нүхтэй болох | 2,0 | | Хэрэгжээгүй. | 0 | |
| | 2 | Эрүүл мэндийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, түргэн тусламжийн автомашиныг шинэчилж, хөдөөгийн багийн эмч нарыг унаажуулна. | 2021 2022 | ЭМТ | | | Шинээр машинтай болсон байна. | | 190,6 | 2021 онд цусны хагас автомат анализатор-1, автомакс 20л-1, автомакс жижиг/0.5л/-1, ариутгалын мананцар үүсгэгч-1, яаралтай тусламжийн ор-1, цахилгаан үүсгүүр мотор -1, угаалгын машин-1, индүү-1, даралтын аппарат чагнуур-3, пульсоксиметр-5, ком, компьютер-3, нөүтбүүк-2, мотоцикл-1 зэргээр хангагдлаа. Засаг даргын нөөц сангаас 10л-ийн 2 ширхэг хүчил төрөгчийн болланыг худалдан авсан. | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Улсын төсөв | | | 13,0 | | 2022 онд шээсний анализаторийн аппарат, дуслын сандал, шарлагын аппарат, сувилагчийн тэргэнцэр, каварц, зэргийг худалдан авсан байна. 2024 онд ЭМГ-аас термостат1, бүлээцүүлэх хөнжлийн багц, сувилагч тэргэнцэрийн багц, эмийн хэрэгсэл бүхий яаралтай тусламжийн иж бүрдэл /вакцин/, эмнэлгийн хэрэгслийг ариутгах зориулалттай төмөр хайрцаг /вакцин/, дижитал термометр /кушатка/, зэргээр хангагдсан байна. 2022 онд Тоёото Пробокс" маркийн суудлын автомашин, 2023 онд ЭМГ-аас БОЭТ-д ашиглаж байсан фургон авто машин, 2024 онд "LC78 diesel medium, MT" маркийн суудлын автомашинтай болсон. | | |
| | 3 | Уламжлалт анагаах ухааны төвтэй болж, шаардлагатай тоног төхөөрөмжээр хангах, уламжлалтын эмч, сувилагчийг орон тоогоор ажиллуулана | 2021 2024 | ЭМТ | Орон нутгийн төсөв | | Уламжлалт анагаах усны кабинеттай болж үйл ажиллагаа эхлүүлсэн байх | 1,0 | | Хэрэгжээгүй | 0 | |
| | 4 | Эмгэг анатомын (моорог)байрыг шинээр барих. | 2021 2022 | ЭМТ СЗДТГ | Орон нутгийн төсөв | | Байртай болсон байх | 25,0 | | 2021 онд Мооргийн барилгыг 25 сая төгрөгөөр засварлан ашиглагтанд хүлээн авсан. | 100 | |
| | 5 | Эмнэлгийн түргэний машины гражыг дулаан шугамд холбоно. | 2021 2024 | ЭМТ | Орон нутгийн төсөв | | Дулааны шугамтай холбосон байх | 4,0 | | Хэрэгжээгүй | 0 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 6 | Эрүүл мэндийн төвөө түшиглэн шүдний кабинеттэй болно. | 2021 2024 | ЭМТ | Орон нутгийн төсөв | | Шүдний кабнеттай болсон байна. | 30,0 | | Хэрэгжээгүй | 0 | |
| **1.3 Нийтийн биеийн тамир** | | | | | | | | | | | | |
| Зорилт 1 Нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгож хөгжүүлэн мэргэжлийн спортыг дэмжиж, биеийн тамир спортод ээлтэй орчныг бүрдүүлнэ. | 1 | Сумыг нийтийн биеийн тамирын арга зүйчтэй болгож, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ. | 2020 - 2024 | ЗД | Улсын төсөв | 1 | Нийтийн биеийн тамирын арга зүйчтэй болж , үйл ажиллагаа тогтмолжсон байна. | 9,3 | 20,0 | 2021-2023 Онд нийтийн биеийн тамирын арга зүйчийг ажиллуулсан. 2024 оны байдлаар Нийтийн биеийн тамирын арга зүйчийн орон тоо батлагдаагүйгээс арга зүйчийг ажлаас чөлөөлсөн. Нийгмийн бодлогын мэргэжилтэн тус ажлыг хариуцан ажиллаж байгаа боловч нийтийн биеийн тамирын ажил төдийлөн хэрэгжилт хангалттай бус байна, цаашид мэргэжилтэнтэй болох шаардлагатай байна. | 90 | |
| | 2 | Залуучуудын хөгжлийн төвийг түшиглэн , спорт заал ,фитнес клубын үйл ажиллагааг тогтмолжуулна. | 2022 , 2024 | НБМ Биеийн тамрын арга зүйч | Орон нутгийн төсөв | Байр Тоног Төхөөр өмжтэй | Үйл ажиллагаа тогтмолжсон байх | 40,0 | | 2021 онд Залуучуудийн хөгжлийн төвд Орон нутгийн хөгжлийн сангаас фитнесс, спортын 59 ширхэг 23.880.000 төгрөгний тоног төхөөрөмжийг байрлуулсан боловч Залуучуудын хөгжлийн төв, спорт заалны паар хөлдсөн учраас үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон. 2022 оны 8 сард Спорт заалны дээвэр, хана тааз, шал, сантехник, Залуучуудын хөгжлийн төвийн сантехникийг засварлаж халаалт өгснөөр үйл ажиллагаа нь тогтмолжсон. 2024 оны байдлаар залуучууд хөгжлийн төвийн халаалт дулааны асуудал хэвийн боловч техник хэрэгсэлд эвдэрч гэмтэн эдэлгээ буудсан. Ширээний теннис, биллиард хүндийн өргөлтийн төхөөрөмжүүд ажиллаж байгаа. Залуучууд ширээний теннис, биллиард тоглох, хүндийн | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | өргөлтийн төхөөрөмж дээр бие бялдраа хөгжүүлэх дасгал хийдэг. Залуучууд хөгжлийн төвийн барилга үйл ажиллагаа явуулахад шаардлага хангахгүй ашиглалт дуусч байна. | | |
| | 3 | Үндэсний болон багийн спортын төрлүүдийг хөгжүүлэн, дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллана | 2021 - 2024 | НБМ Биеийн тамрын арга зүйч | Орон | | Шагайн харваа, үндэсний бөх, шатар, гар бөмбөг, сагсан бөмбөг, чөлөөт болон жудо бөх төрлүүдэд хөгжүүлнэ. | 15,0 | 5,0 | 2021-2022 онуудад ЕБС-ийн дэргэд үндэсний болон чөлөөт бөх, жудо бөх, гар бөмбөгийн секц дугуйлан хичээллэж байв. СӨББ-ийн дэргэд шатрын дугуйлан хичээллэж байна.<br>2024 оны байдлаар үндэсний спортын төрлөөр шагайн харвааны бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг 2024 оны 5 дугаар сард зохион байгуулсан бөгөөд 4 сумын 6 багийн 48 харваач оролцсон. Их Монгол Шаравжамцын нэрэмжит сумын цолтой болон залуу бөхчүүдийн тойргийн барилдааныг жил бүр зохион байгуулж байна. Мөн тус сумын харьяат аймгийн начин Норлохын Батцэрэнгийн нэрэмжит үндсэний бөхийн өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2024 оны 09 дүгээр сард амжилттай зохион байгуулсан. Сумын Голомт-Нутаг үндсэний бөхийн холбооноос тэгш сар бүр үндэсний бөхийн өсвөрийн барилдааныг тогтмол зохион байгуулж хэвшсэн. Монгол улсад биеийн тамир, спортын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд зохиогдсон. Чөлөөт бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд сумын баг тамирчид багийн дүнгээр 2 байрт шалгарлаа. Сар шинийн баярт зориулсан Улс аймгийн цолтой хүчит 64 бөхийн барилдсан.<br>Багийн спортыг хөгжүүлэх чиглэлээр сумын аварга шалгаруулах эрэгтэй, эмэгтэй гар бөмбөгийн тэмцээнийн 03 | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нутгийн төсөв хандив | | | | | дугаар сард зохион байгуулсан. 2024 оны 05 дугаар сард Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас эцэг эхчүүдийн дунд гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулсан. 2024 оны 11 дүгээр сард Анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан төрийн албан хаагчдын дунд спортын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж ажиллаа. Тус тэмцээнд 4 байгууллагын 56 албан хаагч оролцож багийн дүнгээр Засаг даргын Тамгын газар 1 дүгээр байр, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага 2 дугаар байр, Ерөнхий боловсролын сургууль 3 дугаарт шалгарлаа. | | |
| | 4 | Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох, заавал биелүүлэх норм, нормативын сорилыг насны ангиллаар жилд 1 удаа авч хэрэгжүүлнэ | 2020 - 2023 | НБМ Биеийн тамрын арга зүйч | Орон нутгийн төсөв | 1 | 1 удаа авах | | | 2021 оны 10 сард 16-54 насны төрийн болон аж ахуй нэгжийн албан хаагчид болон хүүхдүүдээс бие бялдарын сорил авлаа. Үүнд 16 настай хүүхдүүдээс 15 хүүхэд сорилд хамрагдаж төрийн болон хувийн аж ахуй нэгжээс 37 албан хаагчид хамрагдсан байна .<br>2024 оны 11 сард Ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн 14 бүлгийн 290 хүүхдээд сорилыг авч дуусган 140 хүүхдийн мэдээллийг программд шивэлт хийсэн. | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 5 | Багуудын дунд “Миний нутаг сайхан” спорт, урлагийн наадмыг жил бүр зохион байгуулна | 2021 - 2024 | НБМ Биеийн тамрын арга зүйч | Орон нутгийн төсөв хандив | 1 | Жилд 1 удаа зохион байгуулах | 15,0 | 15,0 | "Иргэдийн наадам 2021"-ыг 12 дугаар сарын 24-нд тусгай удирдамжийн дагуу зохион байгуулав. үүнд 1,2,3,4,5 -р багийн нийт 140 гаруй иргэд оролцсон.<br>2022 оны 8-р сарын 4-ны өдөр сумын багуудын дунд эрэгтэй, эмэгтэй гар бөмбөг, дардас, олс таталт,дэмбээ, нийтийн монгол бөх гүүтэй айлын гүзээ хүү, охин, гар барилдаан хөгжөөнт буухиа, дуэт дуу, багийн мэндчилгээ зэрэг төрлүүдээр зохион байгуулагдаж 192 иргэн оролцсон<br>2023 онд 8 сард багуудын дунд урлаг спортын 6 төрлөөр тэмцээн явуулж нийт 250 иргэн оролцсон.<br>2024 оны 8 дугаар сарын 25,26-ны өдрүүдэд багуудын нэгдсэн өдөрлөг арга хэмжээг зохион байгуулсан. Энэхүү тэмцээнд 5 багийн 230 гаруй иргэд спортын 9 төрөл, урлагийн 3 төрлөөр амжилттай зохион байгуулагдсан. | 100 | |
| | 6 | “Шатар” хөтөлбөрийг сумын онцлогт тохируулан үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | НБМ БТ-ын Арга Зүйч | Орон нутгийн төсөв | 20% | Нийт иргэдийн 35% нь хамрагдсан байна. | | | Шатар хөтөлбөрийг СӨББ амжилттай хэрэгжүүлж байна. СӨББ дээр 4-5 насны 23 хүүхэд, Ерөнхий боловсролын сургуульд шатрын өрлөн хүү клубт нийт 32 сурагч хичээллэж байна | 90 | |
| | 7 | Залуучуудын хөгжлийн төв, спорт зааланд их засвар хийнэ. | 2021 - 2024 | НБМ БТ-ын арга зүйч | Орон нутгийн төсөв | | Засвар хийгдэж, иргэдийн хөгжих орчин бүрдсэн байна. | 40,0 | 60,26 ,278 | Сумын залуучуудын хөгжлийн төв, спорт заалны сантехникийн засварыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр ӨВ ДУЛААН ХХК 22.000.000 төгрөгөөр засварласанаар үйл ажилгаагаа хэвийн явагдах нөхцөл бүрдсэн байна. Залуучуудын хөгжлийн төвийг тоног төхөөрөмжөөр хангасан. Спорт заалыг аймгийн | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | 38,265.278 төгрөгөөр төсвийн хөрөнгөөр ПҮЛҮҮ БУМБА ХХК их засварыг хийсэн. | | |
| **1.4 Боловсрол** | | | | | | | | | | | | |
| Зорилт 1. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 1 | Сургуулийн спорт тоглоом, биеийн тамирын талбайг шинэчилнэ. | 2022 - 2024 | ЕБС | Орон нутгийн төсөв иргэдийн хандив | Хуучин талбайтай | биеийн тамирын гадаа талбай шинээр байгуулдаж, спорт тоглоомын хэрэглэгдэхүүний хангамжийгинэмэг дүүлсэн байна. | 10,0 | 21,8 | 2022 онд беийн тамирын гадна талбайг орон нутгийн хөгжлийн сангийн 12.000.000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар сургуулийн өмнө талбайд шилжүүлэн, сагсан бөмбөг, волейболын талбайг шинээр хийж байгуулсан. ЕБС-ийн 2007 оны төгсөгчид 4.000.000 төгрөгийн бөхийн дэвжээ хандивласан. Сагсан бөмбөг, волейболын 5 бөмбөг шинээр нөхөн хангасан.<br>2022 онд аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас 5.834.0 спорт тоглоомын хэрэглэгдэхүүн олгосон. | 100 | |
| | 2 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл барьж, гадна талбайг тохижуулна. | 2022 - 2024 | СӨББ | Улсын төсөв | Өргөтгөлийн зураг төсөв хийгдсэн | Гадах талбайн тоглоомын хангалт бүрэн хийгдэж тохижуулсан байна_ | 25,0 | 24,5 | Бүрд сумын цэцэрлэгийн барилгыг 50 хүүхдийн 1 урлаг залтайгаар өргөтгөхөөр 600.000.000 төгрөгөөр төсөвлөж тендэр зарлан ӨВ аймгийн Арвайн шагшаа ХХК шалгарч ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулсан. Барилга хот байгуулалтын заавраар хүйтэн орсон тул эрсдлээс сэргийлж барилгын өргөтгөлийг 2025 онд үргэлжлүүлэн хийх чиглэл өгсөн байна.<br>2022 оны 6-р сард ОНХС-ийн хөрөнгөөр цэцэрлэгийн гадаах тоглоомын талбайг С.Өсөхбаяр ахлагчтай “ Өсөх ирээдүй” бүлэг шалгарч хийж гүйцэтгэсэн. | 90 | |
| | 3 | Багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Багшийн хөгжлийн төв” –ийн | 2022 - 2024 | ЕБС | | 80% | дугуйлан клубын үйл ажиллага | 5,0 | 3,8 | Багшийн хөгжлийн төвийн тохижилтыг сургуулийн гүйцэтгэлийн урамшууллын менежмент сайжруулах | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тохижилтыг сайжруулж, түүнд тулгуурлан ахмад багш нарын идэвхи, оролцоотойгоор залуу багш, сурагчдад зориулсан дугуйлан, клуб ажиллуулна | | | Орон нутгийн төсөв | | а жигдэрсэн байна. | | | зардлаас ширээ, сандал, бусад тохижуулалт хийсэн.<br>Тэргүүлэх зэрэгтэй багш нар залуу багш нарыг дагалдуулан сургаж, арга зүйн зөвлөгөө өгч ажилладаг. Сургуулийн "Залуу багш" клуб, мэргэжлийн хөгжлийн 3 бүлэгт 26 багш, ажилтан хамрагдаж байна.<br>2024 онд Багш нарын суралцах, хөгжих, амрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл бусад тавилга, хэрэгслийн судалгаанд багш нарын саналыг авч нэгтгэсэн. Ахмад багшийн зөвлөх үйлчилгээг бага боловсролын 3-5-р ангийн 113 суралцагч, 5 багшид "Ойлгож унших" сэдвээр 128 цагийн сургалтыг зохион байгуулсан. Уншсан зохиолын хүрээнд "Үлгэрийн баатар амилсан нь" дүрийн тоглолтыг зохион байгуулж 4 бүлгийн 46 сурагч хамрагдсан. | | |
| Зорилт 2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны сургалтын болон үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулж, ажиллана. | 1 | Ерөнхий боловсролын сургуулийн барилга, спорт зааланд их засвар хийнэ. | 2021 - 2024 | ЕБС | Улсын төсөв | 2021 онд засвар хийгдсэн. | Засвар хийгдсэн байна. | 280,0 | 359,966.964 | Сургуулийн хичээлийн байрны 280,0 сая төгрөгний гадна пасад, дотор талын засал, хаалга, арын хэсгийн цонх шинэчлэл, шал, сантехник, цахилгааны хэсэгчилсэн, спорт заалны их засварыг TLG XXK 2021 онд хийж гүйцэтгэсэн.<br>2023 онд Сургуулийн хичээлийн байрны дээвэрт хэсэгчилсэн их засвар хийгдсэн. | 100 | |
| | 2 | Дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулна. | 2022 - 2024 | ЕБС | | Их засвар хийгдсэн. | Урсгал засвар хийгдсэн байна. хатуу эдлэл шинээр | | 205,8 | 2021 онд сургуулийн дотуур байранд 67,0 сая төгрөгний хаалга, шалны хэсэгчилсэн засвар, 2022 онд Дотуур байрын гал тогоонд 1.281.000 төгрөгийн хөлдөөгч, түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах хүнсний зориулалтын сав, халуун сав, данх, | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Улс, орон нутгийн төсөв | | хангагдсан. | 45,0 | | хувинг шинэчилсэн. Сумын ГХУСЗөвлөлөөс 440.000 төгрөгийн санхүүжилтээр 2 гадна камер шинээр суурилуулсан. Дотуур байрын гадна талын хамгаалалтын 120 м хашааг 6.500.000 төгрөгийн, гадна тоглоомын талбайг 8.000.000 төгрөгийн хандиваар шинээр хийж тохижуулан орчин нөхцөлийг сайжруулсан. Дотуур байрын хүүхэд хөгжлийн танхим, нийтийн эзэмшлийн талбай, багшийн өрөөний тохижилтыг 5.600.000 төгрөгийн хандив болон улсын төсвийн санхүүжилтээр тус тус хийсэн. 2023 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар дотуур байрны гал тогоонд дээжний хөргүүр, улсын төсвөөс үдийн цай зөөх сав, ундны усны сав, дээжний хөргөгч, халуун сав зэрэг гал тогооны жижиг хэрэглэгдэхүүнүүдийг шинэчилсэн. Нийтийн эзэмшлийн талбай, гал тогооны хэсэгт улсын төсвөөр, хүүхдийн амьдардаг 19 тасагт эцэг эхийн зүгээс урсгал засвар хийж орчин нөхцөлийг сайжруулсан. Гадна ариун цэврийн 00 шинэчлэн хийсэн.<br>2024 онд дотуур байрны дээврийн их засвар хийгдсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр дотуур байрны хатуу эдлэлийн шинэчлэлийн хүрээнд 12,4 сая төгрөгийн хүүхдийн ор шинээр авсан. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчны таазны засвар, шадна орчны тохижилтын ажлын улсын төсөв болон тусламжийн 2,1 сая төгрөгийн тохижилт хийсэн. | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3 | Сургууль, цэцэрлэгийн орчны эрсдэлийн үнэлгээг улирал бүр хийж, стандартад нийцүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | 2021 - 2024 | СӨББ ЕБС | Улсын төсөв | СӨББ-80 хувь ЕБС -50 хувь | Орчны тохижилтын эрсдэл буурч стандартын орчин бүрдэнэ | 1,0 | 0,6 | **СӨББ** Жил бүр цэцэрлэгийн орчны эрсдлийн үнэлгээг үнэлгээний баг нь 2, 5, 8, 11 дүгээр саруудад хийж байна. Үнэлгээ хийсний дараа эрсдлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан ажлыг эрчимжүүлэн эрсдэл бууруулан ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд ОНХСХөрөнгөөр 2022 онд гадаах тоглоомын талбайг 20 сая төгрөгөөр байгуулж, 2023 онд гал тогоонд 20 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан. Улсын төсвийн хөрөнгөөр 2023, 2024 онуудад ангиудын тоглоомын хэрэгсэл, нүүдлийн сургалтын гэр тохижилт, бэлтгэл бүлгийн тохижилт, гадна, доторх дулаалга, засварт 8,9 сая төгрөг зарцууллаа.<br>Дээрх ажлуудыг хийж хэрэгжүүлэн ажилласнаар байгууллагын орчны эрсдлийг бууруулав.<br>Сургуулийн орчны эрсдлийн үнэлгээ 2 удаа хийгдсэн. Үнэлгээний дагуу эрсдлийг бууруулах чиглэлээр хичээлийн байр, дотуур байрын хамгаалалтын хашааг шинээр хийсэн. Авто машины зогсоолыг нүүлгэн шилжүүлж тэмдэгжүүлсэн. Хичээлийн байр болон дотуур байрны план зургийг зааврын дагуу байрлуулж аюулгүйн тэмдэг тэмдэглэгээ хийсэн. | 90 | |
| | 4 | Сургууль, цэцэрлэгийн цахилгаан хангамж, цэвэр, бохир усны шугам сүлжээний ажлыг шинэчлэнэ. | 2021 - 2024 | ЕБС СӨББ | Улсын төсөв | Зураг төсөв хийлгэж ажлыг эхлүүлсэн | Ашиглалтад оруулсан байна. | 330 | | БШУ-ны яамны захиалгаар сургуулийн хичээлийн байр, дотуур байр, цэцэрлэгийн барилгуудад ариун цэврийн байгууламж барьж байгуулах ажил 2021 оны 10-р сараас хийгдэж эхэлсэн боловч газар шорооны ажил хийгдэж байгаад дутуу орхигдсон. Тус ажлыг Номуун заяа | 30 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ХХК гүйцэтгэсэн. Одоог хүртэл нэмж тодорхой ажил хийгдээгүй. Иймд сургууль, цэцэрлэгийн эрхлэгч нар аймгийн Боловсролын газар, БШУЯ, БХБЯ-уудад холбогдож ,уулзаж уг ажлыг эрчимжүүлэх талаар хамтран ажиллаж байна. 2024 онд дээрх компанитай гэрээ цуцлагдаж дараагийн байгууллагыг шалгаруулахаар тендер зарлах үйл ажиллагааг БШУЯ зохион байгуулж байна. | | |
| Зорилт 3. Боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 1 | Ерөнхий боловсролын сургуулиудыг шаардлагатай кабинет, лаборатори, цахим тоног төхөөрөмжөөр хангана. | 2021 - 2024 | ЕБС | Орон нутгийн төсөв<br>Иргэдийн Хандив тусламж | | Мэдээлэл технологи, монгол бичиг, Бага ангийн математик, монгол хэл байгалийн ухааны кабинетад шинэчлэл хийгдсэн байна. | 150,0 | 234,4 | Сургуулийн хэмжээнд гэрчилгээтэй 14 кабинетаас үндэсний бичиг, дизайн технологи, англи хэл, олимп судлал, мэдээллийн технологи, хөгжмийн кабинетууд хуваарийн дагуу кабинетийн системээр хичээллэж байна. Физик, биологи, бага ангийн байгалийн ухаан, нийгмийн ухаан, монгол хэлний кабинетуудыг кабинетийн системээр сургалт зохион байгуулах бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байна. Кабинет хариуцсан багш нарын кабинетийн баяжилт, үйл ажиллагааны тогтовортой байдлыг сар бүр хяналт тавин ажиллаж байна. | 100 | |
| | 2 | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангах, хатуу зөөлөн эдлэлийг шинэчлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | ЕБС | Орон нутгийн төсөв | 50% | Дотуур байр, хичээлийн байранд цэвэр ус уух боломжийг бүрдүүлс | 0.5 | 13,020 | Хичээлийн байр болон дотуур байрын орчинд ундны цэвэр усаар хангах 6 ширхэг ус цэвэршүүлэгч байршуулсан. Анги танхимд 14 ширхэг ус шүүгч байршуулсан.Дотуур байрны хатуу эдлэлийг шинэчилсэн. | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эн байна, шаардлагатай эд ахуйн хангамж нэмэгдсэн байна. | | | | |
| | 3 | Хичээлийн болон дотуур байруудад орчин үеийн стандартад нийцсэн дуу, дүрс бичдэг хяналтын камерын тоог нэмэгдүүлнэ. | 2021 - 2024 | СӨББ ЕБС | Орон нутгийн төсөв | | Хяналтын камерын тоо нэмэгдсэн байх, засвар үйлчилгээ хийгдсэн байна. | 9,0 | 7,889 | **Цэцэрлэг нь** БСУГ-ын төлөвлөгөөний дагуу 2021 оны 9 дүгээр сараас орчин үеийн стандартад нийцсэн дуу, дүрс бичдэг хяналтын камераар хангагдаж хичээл сургалтын танхим, гал тогоо, үүд, коридорт-6 ширхэг, гадаах талбайд-1 ширхэгийг байрлуулж аюулгүй байдлыг хангаан ажиллаж байна. 2023 оны хичээлийн жилээс гадаах талбайд 1 камер нэмэгдүүлсэн.<br>ЕБС Нөхөн хангалтын зардлаар утасгүй интернетийн 8 төхөөрөмжийг суурилуулан хичээлийн байранд ашиглах интернетийг бүх анги, танхим, өрөө тасалгаанд интернет орох боломжийг бүрдүүлсэн.<br>Сургуулийн хичээлийн байр болон дотуур байранд 45 теле хяналтын камер хэвийн үйл ажиллагаатай ажиллаж байна. Камер хадгалалтын хугацаа 1,5 сар, ямар нэгэн эвдрэл гэмтэлгүй хэвийн ажиллаж байна. Сургуулийн анги танхим, гадна орчны 22, нийтийн эзэмшлийн талбайн 7, дотуур байрны 16 хяналтын камерын бичлэгт түүвэрчилсэн хяналт дотоод хяналтын нэгж, нийгмийн ажилтан, сургалтын менежер, байрын багш, эмч 7 хоногт 1-2 удаа хийж хэвшсэн. Өдөр тутмын хяналтыг сургалтын менежер, байрын багш хийж байна. Хяналтаар илэрсэн 11 зөрчил | 100 | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | илэрсэн. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгахад анги удирдсан багш, холбогдох албан хаагчдад тухай бүрд танилцуулан зөрчлийг арилгах арга хэмжээг авсан. | | |
| | 4 | Цэцэрлэгийн дотоод тоглоом сургалтын хэрэглэгдэхүүний хангалтыг сайжруулна. | 2021 - 2024 | СӨББ | Орон Нутгийн Төсөв | | Хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоомын хангалтыг нэмэгдүүлсэн байна. | 10,0 | 18,7 | 2021-2022 оны хичээлийн жилд байгууллагын үнэлгээний урамшууллалд хамрагдан дотоод тохижилтонд 6.100.000 төгрөг, 2022-2023 оны хичээлийн жилд БШУЯ-аас хувиарлагдан ирсэн нөхөн хангалтын 3.865.600 төгрөгөөр тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн, цагаан хэрэглэл, 2023-2024 онд нөхөн хангалтын зардлаар 2.330,000 төгрөгийн хэрэглэгдэхүүн авч хангалт хийсэн. 2023 онд багшид олгох хичээл практикийн зардал 1,823.800, 2024 онд 4,581.600 төгрөг зардлаар хичээл практикийн үйл ажиллагаанд зарцуулсан. | 100 | |
| | 5 | 1-2 настай хүүхдийг яслид, 2-3 настай хүүхдийг хүүхэд харах үйлчилгээнд, 3-5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд /5 настныг заавал/ хамруулж, хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана. | 2021 - 2024 | СӨББ | Улсын төсөв | 85 % | 1-2 настай хүүхдийг ясли, 2-3 настай хүүхдийг хүүхэд харах үйлчилгээ, 3-5 настай хүүхдийг СӨБ-д бүрэн хамруулж сургуульд бэлтгэсэн байна | | | 2020-2021 оны хичээлийн жилд 5 настай 66 хүүхдийг ердийн болон хувилбарт сургалтанд хамруулан сургуулийн өмнөх боловсрол олгож ЕБС-д элсүүлэн суралцууллаа. Сумын 3-5 настай нийт 188 хүүхдийн 4 настай ахлах бүлэгт 18 хүүхэд, 5 настай 33 хүүхэд өдрийн бүлэгт , зайны сургалтанд 18 хүүхэд, өөр сум, суурин газруудад 20 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж хамрагдалт 66%-тай байв. 2021-2022 оны хичээлийн жилд сумын хэмжээнд 254 хүүхдээс ердийн сургалтанд 97 хүүхэд, хувилбарт болон нүүдлийн бүлэгт 13 хүүхэд, явуулын багшийн сургалтанд 36 хүүхэд, ээлжийн багшийн сургалтанд | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | 16, бусад газар 92 хүүхэд хамрагдаж хамран сургалтаа нэмэгдүүлэн ажилласан. Хамран сургах тойргийн 5 настай 66 хүүхдийн бүртгэлтэй. Үүнээс 30 хүүхдийг танхимаар, бусад газар 27 хүүхэд, хувилбарт сургалтанд 9 хүүхэд, бусад газраас 7 хүүхэд хамруулан Бэлтгэл бүлгийг нийт 37 хүүхэд танхимаар төгсгөж хамран сургалтыг 100% хувьд хүргэж ажиллаа.<br><br>2022-2023 оны хичээлийн жилд 242 хүүхдээс СӨБ-ын бага бүлэгт-28 хүүхэд, ахлах бүлэгт-39 хүүхэд, бэлтгэл бүлэгт-25 хүүхэд, нийт 92 хүүхэд ердийн бүлэгт хамрагдаж байна. Хувилбарт болон нүүдлийн бүлэгт 36 хүүхэд, явуулын багшийн сургалтанд 61 хүүхэд, бусад газар 54 хүүхэд, өөр газрын харъяат 14 хүүхэд хамрагдаж хамран сургалтыг нэмэгдүүлэн ажиллаж байна. Хамран сургах тойргийн 5 настай нийт тойргийн 52 хүүхэдээс ердийн сургалтанд 25 хүүхэд, Явуулын багшийн сургалтанд 11 хүүхэд, өөр баг харъяанд 16 хүүхэд хамрагдаж байв.<br><br>2023-2024 оны хичээлийн жилд бага бүлэгт 27 хүүхэд, ахлах бүлэгт 41 хүүхэд, бэлтгэл бүлэгт 30 хүүхэд нийт өдрийн бүлгээр 98 хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгож байна. Сумын 5 настай 65 хүүхэд байгаагаас тайлант онд 3 хүүхэд бүүр шилжсэн 30 хүүхэд өдрийн сургалтанд хамрагдаж байгаа, 10 хүүхэд хувилбарт сургалт, 22 хүүхэд өөр баг харъянад сургуулийн өмнөх боловсрол | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | эзэмшиж байна. Хөдөөгийн алслагдмал айлын хүүхдүүдийг хувилбартын сургалтанд хамруулж байна. Нийт хамран сургалт 100%-д хүрсэн. | | |
| | 6 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт тэгш хамрагдах боломжийг бүрдүүлэн, хамран сургалтыг нэмэгдүүлэх, шаардлагатай тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангаж, багшлах боловсон хүчнийг давтан сургах, мэргэшүүлэх, жирийн ангид шилжин суралцах чадварыг дээшлүүлэн, сэргээн засах үйлчилгээг нийгэм, хамт олонд нь түшиглэн тогтмол үзүүлнэ. | 2021 - 2022 | ЕБС | Улсын төсөв | | Сургууль йн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд жирийн ангид суралцах нөхцөлийг хангаж ажилласан байна | | . | **СӨББ-д** 2020-2024 оны хүчээлийн жилд 2-5 насны хөгжлийн бэрхшээлтэй нийт 1 хүүхэд хувилбарт болон өдрийн бүлэгт ээлжлэн сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж төгссөн.<br>ЕБС 2023-2024 оны хичээлийн жилд бага ангид хөгжлийн бэрхшээлтэй 4, дунд ангид 2 нийт 6 сурагч суралцснаас ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр 3 хүүхэд хичээллэсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих дэмжлэгийн багаас хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн санал хүсэлтийг сонсон цаашид хэрэгжүүлэх шаардлагатай. 2024-2025 оны хичээлийн жилд бага ангид 4, дунд 3 нийт 7 хөгжлийн бэрхшээлтэй сурагч суралцаж байгаагаас ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр 2 сурагч хичээллэж байна. Ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байгаа багшид улирал бүр урамшуулал олгон ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журамд заасны дагуу дэмжлэгийн багийн үйл ажиллагааг сайжруулах, хүүхдийг сургуулийн орчинд дасан зохицох, хөгжлийн онцлог давуу талыг судлах зорилгоор “Дэлхийн цагаан таягтны өдөр” буюу хараагүй иргэдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд хараны бэрхшээлтэй | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | сурагчдын сурч боловсрох орчин нөхцөлд тулгамдаж буй асуудал, сурагчдын ялгаварлан гадуурхалт болон бусад асуудлын талаар нээлттэй ярилцлага зохион байгуулан ажилласан. | | |
| Зорилт 4. Сургууль цэцэрлэгт үйлчилгээний стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцийг бүрдүүлж, бүх сурагчдыг үдийн хоолны хөтөлбөрт хамруулна. | 1 | Ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай" арга хэмжээг "Үдийн хоол" болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | ЕБС | Улсын төсөв | 1-5 -р ангийг Үдийн хоол арга хэмжээнд бүрэн шилжүүлсэн байна | 1-12 -р ангийг Үдийн хоол арга хэмжээ чанар үр дүнтэй хэрэгжиж байна. | | 36,979.5 | Үдийн хоол хөтөлбөрт 1-5 дугаар ангийн хүүхдүүд хамрагдаж амт чанартай халуун хоол цайгаар үйлчлүүлж байна. Хоолны цэсийг хүүхдийн биед шим тэжээлээр хангахуйц 7 хоногт давтагдахааргүй цэс гарган батлуулж ажиллаж байна. Суралцагчид хоолны амт чанар, хүрэлцээнд сэтгэл хангалуун байдаг.Үдийн хөндлөнгийн хяналтын зөвлөл 10 удаа, сургуулийн дотоод хяналтын нэгж 3 удаа хийсэн. Үдийн хоолонд оны турш 24653 хүхэд хамрагдсан байна. Сургуулийн дотуур байрны гал тогоогоор дамжуулан хэрэгжүүлж байна. | 90 | |
| | 2 | Цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх, Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын гал тогоог стандартын шаардлагад нийцүүлэн засварлах, зориулалтын хөргүүрийн тоног төхөөрөмжөөр хангана. Эмч болон хариуцсан албан хаагчдыг хоолны технологич, хоол | 2021 - 2024 | СӨББ ЕБС | улс, орон нутгийн төсөв | Дотуур байрны гал тогоонд урсгал засвар хийгдсэн байна | Тоног төхөөрөмжийн хангалт хийж, хоол зүйчийн мэргэшүүлэх сургалтанд хариуцах ажилтанг сургаж мэргэжүүлсэн байна. | 10,0 | 20,0 | **Цэцэрлэг** 2023 оны 9-р сард орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 20 сая төгрөгийн 150 хүүхдэд хоол хийх хүчин чадалтай тоног төхөөрөмжөөр хангагдсан.<br>**Сургууль** хөргүүр, дээжний хөргөгч, үдийн цай зөөх сав, гар угаалтуур, гал тогооны жижиг хэрэглэгдэхүүний шинэчлэл хийгдсэн. Сургууль, эмнэлгийн гал тогооны тоног төхөөрөмжийн шинэчлэл 2025 онд хийгдэхээр Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэхээр эрэмблэгдсэн. | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зүйчээр мэргэшүүлэх сургалтанд хамруулна | | | | | | | | | | |
| | 3 | Сургууль, цэцэрлэгүүдэд туслах болон хүлэмжийн аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 2021 - 2024 | ЕБС | Орон нутгийн төсөв | Эзэмшлийн хүлэмжинд ногоо тарьж аж ахуйдаа хэрэглэдэг. | Туслах болон хүлэмжийн аж ахуйг өргөжүүлж байгууллагын эзэмшлийн хүлэмжтэй болж, нарийн ногоо тариалан хүүхдийн хоолонд хэрэглэх | | 1,020 | Сурагчид, албан хаагчдыг оролцоонд тулгуурлан сургуулийн хичээлийн болон дотуур байрны гадна ногоон талбайд хаврын тариалалтаар 421, намрын тариалалтаар 86 мод шинээр тариаллан ногоон байгууламжийн хамгаалалтыг сайжруулж, тохижилт хийж услалт, арчилгаа хийж байна.<br><br>Сургуулийн туршилтын талбайд жил бүр төмс, сонгино, сармис, хүлэмжийн нарийн ногоо тариалан багш, сурагчдын хэрэгцээнд ашиглаж байна.<br>1-12-р ангиуд хичээлийн байр дотуур байрны цэцгийн 22 мандлыг хариуцан 1 наст цэцэг тарин арчлалт хамгаалалт хийж хэвшсэн. Орон нутгийн 1 булгийн эхийг 100м төмөр хашаагаар хамгаалан “Эко клуб”-ийн сурагчдын ажиглалт, судалгаа хийх талбайг “Нутгийн үйлс, ухаан, сургалт судалгааны төв” төрийн бус байгууллагын санхүүжилтээр шинээр байгуулсан. Нийт давхардсан тоогоор 293 сурагчид тасалгааны цэцэг арчилгаа, хүлэмжийн нарийн ногоо тариалах, үрслүүлэх арга зүй, мод усалгааны горим, арчилгааны арга зүйн сургалт зохион байгуулсан. | 100 | |
| Зорилт 5. Боловсролын үйлчилгээг чанартай зохион байгуулж, | 1 | Улсын төрөлжсөн олимпиадыг орон нутагтаа зохион байгуулж, багш, сурагчдын чадавхыг дээшлүүлнэ. | 2022 | ЕБС | Улс, орон | | Зохион байгуулалттай оролцсон байна | 20,0 | 0,650 | 12а ангийн сурагч Ц.Билгүүн Монгол хэл бичгийн шалгалтад 800 оноо авч Аймгийн засаг даргын тэтгэлэг, 12 дугаар ангийн төгсөгч Э.Мөнхжаргал, Т.Отгонбилэг Б.Төрмөнх нар Ерөнхийлөгчийн илгээлт-2100 хөтөлбөрт , 12а ангийн сурагч | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| сургалт, хүмүүжлийн ажлын чанарыг дээшлүүлж, дотоод, гадаадын их дээд сургуульд хүлээн зөвшөөрөгдсөн суралцагчийг бэлтгэнэ. | | | | | нутгийн төсөв | | | | | Ц.Лхагвадорж ЭЕШ-аар хамгийн өндөр оноо авч “Доржгочоо сан”-гийн тэтгэлэгт хамрагдсан.<br>Улсын төрөлжсөн олимпиадын 2-ын давааанд 12 судлагдахууны олимпиадад багш болон 9, 12-р ангийн суралцагчдын төрөлд нийт 42 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, биологийн багш “Хүрэл” медаль хүртэж, чанарын үзүүлэлтээр 3-р байр 1 шалгарч аймгийн хэмжээнд 24-р байр эзэлсэн.<br>2024 онд Боловсролын газраас зохион байгуулагддаг анги нийтийн олимпиадад 9 бүлэг 6 судлагдахуунаар 15 шалгалт өгч 33.2%-ийн гүйцэтгэлтэй өмнөх жилээс 6.8%-ийн ахицтай шалгагдсан.<br>Багш нар заах аргын нэгдлээрээ хамтран олимпиадын дүн мэдээ, судлагдахууны даалгавруудын гүйцэтгэлд анги бүрээр дүгнэлт хийж үр дүнг дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байна. | | |
| | 2 | Таваас доошгүй хичээл судлагдахуунаар анги нийтийн аймгийн олимпиад уралдаан зохион байгуулж, анги хамт олны амжилтыг үнэлж, дүгнэнэ. | 2021 - 2024 | ЕБС | Улс Орон нутгийн төсөв | | Анги хамт олны амжилт ахисан байна | | | 2021-2022 оны хичээлийн жилд Мэргэжлийн хичээлүүдийн аймгийн олимпиадад багш, сурагчид амжилттай оролцсон. Бага ангийн багшийн төрөл Э.Нямсүрэн 4-р байр, З.Хишигжаргал 4-р байр эзэлсэн.<br>аймгийн хэмжээний “Тоо бодож оюунаа хөгжүүлье”, ”Эх хэл эрдмийн түлхүүр”, ”Эх түүхээ эрхэмлэе”, ”Гадаад хэл хөгжлийн түлхүүр” олимпиадуудыг 1 шатыг сургуулийн хэмжээнд амжилттай зохион байгуулж 2 шатанд шалгарсан ангиуд оролцож дүн мэдээ хүлээж байна.<br>2022-2023 оны хичээлийн жилд Анги нийтийн олимпиадад эх хэл эрдмийн | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | түлхүүр, тоо бодож оюунаа хөгжүүлье, гадаад хэл хөгжлийн түлхүүр, эх түүхээ эрхэмлэе, эрүүл мэнд хичээлүүдээр анги нийтийн олимпиадын 1-р шатыг сургуулийн хэмжээнд амжилттай зохион байгуулж, амжилттай шалгагдсан 12 бүлэг дараагийн 2-р шатанд оролцсон.<br>2023-2024 оны хичээлийн жилд Боловсролын газраас зохион байгуулагддаг анги нийтийн олимпиадад 9 бүлэг 6 судлагдахуунаар 15 шалгалт өгч 33.2%-ийн гүйцэтгэлтэй өмнөх жилээс 6.8%-ийн ахицтай шалгагдсан.<br>Багш нар заах аргын нэгдлээрээ хамтран олимпиадын дүн мэдээ, судлагдахууны даалгавруудын гүйцэтгэлд анги бүрээр дүгнэлт хийж үр дүнг дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байна. | | |
| | 3 | Цэцэрлэг, сургууль бүр үйл ажиллагаандаа өөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тогтолцоог хөгжүүлж, цэцэрлэг, сургууль хөндлөнгийн үнэлгээнд хамрагдана. | 2021 - 2024 | СӨББ ЕБС | Улс Орон нутгийн төсөв | | Үйл ажиллагаандаа өөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дотоод аудитын хөндлөнгийн үнэлгээ болон дотоод аудит хийж | 0,2 | 0,1 | **Цэцэрлэг** нь жил бүр өөрийн үйл ажиллагаандаа 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилон үнэлгээ хийж үйл ажиллагааны үр дүнг хамт олны хурлаар хэлэлцүүлэн цаашдын ажил, төлөвлөлтөнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар томилуулсан үнэлгээний багийнхан “Цэцэрлэг Ерөнхий боловсролын сургууль”-ийн ажлыг үнэлэх журмын дагуу цэцэрлэгийн үйл ажиллагааг үнэлэхэд 2022 оны 06-р сард 94,8%, 2023 оны 6 дугаар сард 97.7 хувьтай хэвийн үйл ажиллагаатай гэж үнэлэн үнэлгээний тайланг цэцэрлэгийн эрхлэгчид хүлээлгэн өгч эрхлэгч | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэвшсэн байна. | | | БШУГ-т 6-р сарын 15нд цахимаар илгээлээ.<br>2023-2024 оны хичээлийн жилийн эхэнд цэцэрлэгийн үйл ажиллагааны эхний үнэлгээг 8-р сард үнэлж дүгнэхэд 95.9%-тай байлаа.<br>ЕБС-ын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагаа тогтмолжсон. Сургалтын байгууллагуудын гүйцэтгэлийн үнэлгээнд 2 жил дараалан хамрагдаж 74,4%-ийн үнэлгээтэй III түвшинд үнэлэгдэн гүйцэтгэлийн урамшуулал авч байна. Энэ үзүүлэлт өмнөх оныхоос 3% ахисан ба улсын дундажаас дээгүүр үнэлэгдсэн. | | |
| | 4 | Хүүхэд нэг бүрийг ёс зүйтэй бие хүн болгон төлөвшүүлэн, хүмүүжүүлэхэд багш, эцэг, эх, нийгмийн ажилтны хамтын оролцоог хангана. | 2021 - 2024 | 90 | Улс, орон нутгийн төсөв | | зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулан, хамтын үйл ажиллагаа дээшилсэн байна. хүүхдүүдийн ёс зүй сайжирч, эерэг хандлага төлөвшсөн байна. | 0,4 | 0,2 | 2021 онд 6-12-р ангийн сурагчдын дунд хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, харилцаа ба хандлага, хорт зуршил түүний хор нөлөө, ялгаатай байдлыг хүндэлье, хүүхэд хамгаалал, гэсэн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулан ажилласан. Мөн эцэг эх асран хамгаалагчдын дунд хүүхэд хамгаалал, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, сургалтыг зохион байгуулан зөвлөгөө мэдээлэл хүргэн ажилласан. Аймгийн сургуулийн сэтгэл зүйн хамтарсан багийн бүрэлдэхүүнийг сургуулийн хэмжээнд ажиллуулсан.<br>Сэтгэл зүйн хамтарсан баг нь 1-12 дугаар ангийн нийт 315 хүүхэд хамрагдаж 90% амжилттай оролцлоо.<br>2022 онд бүлгийн уулзалт зохион байгуулагдсанаар сурагчдын сэтгэл зүйн төлөв байдал, анги хамт олны уур амьсгал, ангийн багш болон сурагчдын харилцан ойлголцох чадварын талаар зөв мэдлэг мэдээлэл хүргэн ажилласан. | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Ганцаарчилсан уулзалт нь сурагчдын тулгамдаж буй асуудлыг нээлттэй сонсож, харилцан ярилцаж, тулгамдаж буй асуудлаа даван туулахад нь дэмжлэг болох давуу талтай. 1-12 дугаар ангийн нийт 30 хүүхэд ганцаарчилсан зөвлөгөө авсан. Сургуулийн 22 албан хаагчдад “Аз жаргал ба хайр” гэсэн сэдвээр сургалт зохион байгуулан арга зүйн зөвлөгөө, мэдээлэл хүргэн ажилласан. 2024 онд Сургуулийн хөгжлийн хүрсэн түвшинг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах, хамт олны хүсэл зорилтыг дэмжих, сургуулийн хөгжлийн боломжуудыг хамтран эрэлхийлэх, менежментийн төлөвлөгөөг сайжруулах зорилгоор ажлын хэсгээр судалгаа, санал асуулгыг 2 удаа зохион байгуулсан. Энэ судалгаанд 42 багш, ажилтан, 48 эцэг эх асран хамгаалагч, 11 хүүхдийн өөрөө удирдах байгууллагын ахлагч нар хамрагдсан. “Хүүхдийнхээ найз нь байя” нээлттэй хаалганы өдөрлөгт нийт 123 эцэг эх, асран хамгаалагч оролцсон. Эцэг эхчүүдтэй хамтран гараас гарт, багш айлчлал, school police шйо ажиллагааг хичжжлийн жилийн турш зорион байгуулсан. | | |
| | 5 | Багш, удирдах ажилтны ажлын арга барил, үйл ажиллагааны үр дүн, ур чадварын түвшин тогтоох, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор багш, удирдах | 2021 - 2024 | ЕБС | Улсын төсөв | | Аттестат чилд 100% хамрагдсан байна. | 0,1 | | Багш удирдах ажилтнууд цахим болон танхимаар сургалтад хамрагдаж мэргэжил боловсролоо тасралтгүй хөгжүүлж байна. Үүнд модуль сургалтад 25 багш, ажилтан хамрагдаж 84% нь 3 кердитийн батламж авсан. Мөн ажлын байран дээрх сургалтад тогтмол хамрагдаж мэргэжил арга зүйгээ дээшлүүлж | 90 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажилтныг аттестатчилд оруулна. | | | | | | | ажилладаг. Удирдах ажилтан, багш нар монгол бичгийн сорилго, судалгаанд хамрагдсан. | | |
| | 6 | Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанарыг сайжруулж элсэлтийн ерөнхий шалгалтын үзүүлэлт үнэлгээг аймгийн дунджаас дээгүүр байлгана. | 2021 - 2024 | ЕБС | Улсын төсөв | 516,6 | 531 | | 2022 онд 12а ангийн сурагч Ц.Билгүүн Монгол хэл бичгийн шалгалтад 800 оноо авч Аймгийн засаг даргын тэтгэлэг,. Э.Мөнхжаргал Т.Отгонбилэг, Б.Төрмөнх нар Ерөнхийлөгчийн илгээлт-2100 хөтөлбөр, 12а ангийн сурагч Ц.Лхагвадорж ЭЕШ-аар хамгийн өндөр оноо авч “Доржгочоо сан”-гийн тэтгэлэгт хамрагдсан. Элсэлтийн ерөнхий шалгалтанд монгол хэлний шалгалт аймаг улсын дунджаас дээгүүр 549,5 оноотой шалгагдсан.<br>2023 онд Монгол хэл бичгийн шалгалтад 12-р ангийн 16 суралцагч оролцож сургуулийн дундаж хэмжээст оноо 563.6, 100% босго оноогоо давсан амжилттай шалгагдсан нь өмнөх жилийн хэмжээст онооноос 105.3 оноогоор ахисан үзүүлэлттэй байна.<br>2024 онд Элсэлтийн ерөнхий шалгалтад 16 суралцагч орж 7 хичээлийн 51 шалгалт өгсөн. Аймагт биологийн хичээлээр 605.3, монгол хэлний хичээлээр 604.7 оноотойгоор тус бүр 5-р байр, англи хэлний хичээл 515.4 оноогоор 8-р байр эзэлсэн. Элсэлтийн шалгалтын дундаж хэмжээст оноо 524.8 ба аймагт 11-р байр эзэлсэн. Хэмжээст онооны дундаж өмнөх оны үзүүлэлтээс 102.3 оноогоор ахисан.<br>“Багш, ажилтны тасралтгүй хөгжлийг дэмжих” сургалтыг ЭЕШ-т болон анги нийтийн олимпиадад амжилттай бэлтгэх, үнэлгээний шалгуурт нийцсэн | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | даалгаврын сан бүрдүүлэх, цахим контент боловсруулах арга зүй, цахим хэрэглүүр ашиглах сэдвүүдээр Шинэ Монгол сургуулийн монгол хэл, бичгийн багш Э.Батдэлгэр, Орчлон сургуулийн монгол хэл бичгийн багш Б.Алтанзул нараас 16 цагийн сургалтад 28 багш ажилтан 100% хамрагдсан. Сургалтын үр дүнд хичээлийн хэрэглэгдэхүүн, гарын авлага, танилцуулга, брошур, интерактив даалгавар, зэргийг хийж сурсан ба 5-н багш medle.mn-д хичээл илгээж зөвлөгөө авч ажилласан. | | |
| | 7 | Сургууль сурталчилах ажлыг жил бүр үе шаттайгаар зохион байгуулна. | 2021 - 2024 | ЕБС | Орон нутгийн төсөв | 50% | Сумын хэмжээнд нээлттэй хаалганы өдөр, багийн ИНХ-аар сургуулийн үйл ажиллагаг сурталчлан таниулсан байна. Зэргэлдээ сумдууд сургууль суртчлах ажлыг зохион байгуулах | 0,3 | 0,2 | Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг сургуулийн үйл ажиллагааг эцэг эх, олон нийтэд танилцуулах, сурталчлах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сургуулийн нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулан ажилласан. Тус өдөрлөгт 1.Сургалтын үйл ажиллагаа, зохион байгуулалтын танилцуулга 2. Хүүхдийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, клубын танилцуулга 3. Эрүүл мэндийн зөвлөмж, зөвлөгөө өгөх. 4. Мэргэжлээ хэрхэн сонгох бэ? зөвлөмж 5. “Хүүхэд, эцэг эхээ сонсох өдөр” үйл ажиллагаа 6. Сурагчдын унших бичих чадварыг хөгжүүлэх “ЭРДМИЙН ХӨТӨЧ” төслийн явц, үйл ажиллагааны танилцуулга 7. Дүйцсэн хөтөлбөрийн зорилго чиглэл 8. Дотуур байрны үйл ажиллагааны танилцуулга гэсэн 8 чиглэлээр зохион байгуулан ажилласан.<br>ИНХ-аар сургуулийн үйл ажиллагаа, сургалтын орчин нөхцөлийн талаар | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | танилцуулга мэдээлэл хүргэх, гарын авлага, боршур тараах үйл ажиллагааг 1 удаа зохион байгуулсан. Боловсролын багц хуулийн танилцуулга, сургуульд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, сургалтын агуулгыг, сургуулийн үйл ажиллагааны тайланг 2 удаа зохин байгуулж бага ангийн суралцагчдын эцэг эхийн 77%, дунд ангийн суралцагчдын эцэг эхийн 80%, ахлах ангийн суралцагчдын эцэг эхийн 67% буюу нийт эцэг эхчүүдийн 77% нь хамрагдсан. Сумын Нээлттэй хаалганы өдрөөр үйл ажиллагааны танилцуулга хийсэн | | |
| | 8 | Тойргийн хэмжээний хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилгоор бодлогын баримт бичиг боловсруулж хэрэгжүүлнэ. | 2021 - 2022 | ЕБС | Орон нутгийн төсөв | 52.8% | Тойргийн хүүхдийн хамрагдалтыг 60 % хүргэх, | | | 1-р ангид элсэн суралцах хамран сургах тойргийн хүүхдүүдийн 54% нь шинээр элсэн орсон. 6-14 насны хүүхдийн хамран сургалтын цэвэр жин 51% хамрагдаж байна. Хамран сургах тойргийн хүүхдүүдийг харъяаллын сургуульд суралцуулах чиглэлээр сумын хэмжээнд багийн дарга нартай хамтран 6-14 насны нийт хүүхдүүдийн судалгааг гаргасан. Судалгааны дагуу хамтран сурах тойрогтоо суралцах боломжтой эсэх талаар мэдээллийг цуглуулан сумын хэмжээнд нэгдсэн бодлого төлөвлөлт боловсруулах ажлыг эхлүүлсэн. | 70 | |
| Зорилт 6. Сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, | 1 | “Миний Өвөрхангай” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, жил бүр аймаг байгуулагдсан тэмдэглэлт өдрийг угтан аян зохион байгуулах | 2021 - 2024 | ЕБС | Улс, орон нутгийн төсөв | | Хөтөлбөрийг сургуулийн хэмжээнд амжилттай хэрэгжүүлсэн байна. | 0,1 | 0,1 | “Миний Өвөрхангай” аяны хүрээнд БУЗАН, НУЗАН, БАЗАНэгдлээрээ суралцагчид, эцэг эх олон нийтийг хамарсан ажлын төлөвлөгөө гарган үр дүнтэй хэрэгжүүлж аймгийн ТОП 5 сургуульд жагссан амжилттай оролцлоо. Үүнд бага ангийн сурагчдын дунд “Миний мэдэх төв цэг” бүтээлийн уралдаанд 2а ангийн сурагч М.Алтангэрэл тэргүүн байр, | 100 | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос бичигтэн болох зэрэг хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлнэ. | | | | | | | | | | | А.Төрмөнх дэд дунд ангийн сурагчдын дунд “Миниймэдэх өвөрхангай” бяцхан ном бүтээх уралдаанд 9а ангийн сурагч Э.Сарангуа тэргүүн байр, Б.Цэцэгмаа дэд байр, О.Баасансүрэн гутгаар байр, ахлах ангийн сурагчдын дунд цахим контент бэлтгэх уралдаанд 12а ангийн” эв эе” багийн “Үндэсний өв соёл” контент шалгарлаа Миний Өвөрхангай аяны хүрээнд суралцагчид, багш албан хаагчид, эцэг эх, иргэдийг хамруулан 5 чиглэлийн дагуу 29 үйл ажиллагааг зохион байгуулж цахим орчинд байршуулан үр дүнг тооцож ажиллан аймгийн шилдэг сургуулиар шалгарсан. Үүнд: Аймгийн засаг даргын видео хичээлийг 1-12 -р ангийн 125 суралцагч, 26 багш, ажилчид үзэж хэлэлцүүлэг өрнүүлсэн<br>Миний Өвөрхангай аяны хүрээнд анги удирдсан багшийн хичээлийг Бага боловсролын багш Т.Уранбилэг "Түүхэн дурсгалт газар Төвхөн хийд", түүх газар зүйн багш Н.Наранхүү "Бидний бахархалт нутаг мину" зочин багштай хичээл, хөгжмийн багш Б.Даариймаа "Соёлын биет бус өв" сэдвүүдээр хичээл заав.<br>Зочинтой ярилцлага үйл ажиллагаанд - Сумын ахмад настан Б.Наранхүү 6-9-р ангийн 115 сурагчдад "Сумынхаа түүх, түүхэн дурсгалт газруудын талаар,<br>Сургуулийн түүх, газарзүйн багш Н. Наранхүү 11-р ангийн 17 сурагчдад "Миний бахархалт нутаг" сэдвийн хүрээнд сумынхаа түүх, соёлын талаар домог, хууч яриа, | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Сумын номын санч Ц.Доржсүрэн 10-12-р ангийн 54 сурагчдад "Соёлын биет болон биет бус өвийн талаар танин мэдэхүйн мэдээлэл өгч, хэлэлцүүлэг өрнүүлэв. Сургуулийн хамт олон Дэндэвийн Пүрэвдоржийн зохиол "Мөнгөн хүрхрээн магтуу" дууг дуулан сум, сургуулийн цахим групт байршуулж бусдад түгээн дэлгэрүүлэх зорилгоор сумынхаа албан байгууллага, аж ахуй нэгж, иргэдийг челленжид нэгдэхийг уриалан ажиллав. Дэндэвийн Пүрэвдорж эх найрагчаараа бахархах, түүний уран бүтээлийг сурч, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор 1-11-р ангийн 336 суралцагч болон ЕБС-ийн албан хаагчид дараах 12 дууг сурч дуулан сургуулийн цахим группт байршуулсан. 2024 онд Аймгийн Засаг даргын 2020 оны А/15 дугаар захирамжаар батлагдсан "Миний Өвөрхангай" аяны хүрээнд 5 чиглэлийн хүрээнд 21 ажил төлөвлөн 1-12- ангийн 322 суралцагчид, 42 албан хаагчдыг хамруулан амжилттай зохион байгуулж тайлан мэдээг хугацаанд нь илгээсэн. | | |
| | 2 | Сургуулийн хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын санал санаачлагыг дэмжиж хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх, бие даан бүтээлчээр суралцахуйд суралцах боломжийг нээн, | 2021 - 2024 | ЕБС | Орон нутгийн төсөв | 80 | 89 хувьд хүргэх | 2,0 | 0,5 | 2023-2024 оны хичээлийн жилд сургуулийн хэмжээнд 23 хүүхдийн өөрөө удирдах дуйгуулан секц үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 18 нь дунд болон ахлах ангийн сурагчдад зориулсан, 5 нь бага ангийн сурагчдад зориулсан. Удирдан чиглүүлэгч 20 багш, ажилтан ажиллаж байна. | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сургуулийн харьяа уламжлалт өв соёл, хэл, сэтгэн бодох, техник технологи, оюуны спортын төрлийн клуб, төв, дугуйлан, секцэд хичээллэх сурагчдын тоог нэмэгдүүлнэ. | | | | | | | | давхардсан тоогоор 572 хүүхэд хамрагдаж байна.<br><br>“Сонирхлоороо нэгдсэн бидний амжилт” хүүхдийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны Хүүхдийн хөгжил оролцооны хүүхдийн өөрөө удирдах байгууллага, клубуудын үйл ажиллагааг сурталчилах, үе тэнгийнхэний нийгэмд чиглэсэн үйл ажиллагааны чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд зорилгоор:<br>• Хүүхдийн өөрийн удирдах байгууллагуудын туршлага солилцох боломжийг бүрдүүлэн ажилласан.<br>• Клубуудийн үйл ажиллагаатай эцэг эх, асран хамгаалагч нар нээлттэй танилцсан.<br>• Хүүхдийн өөрөө удирдах байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааг сурталчилан таниулах үзэсгэлэн гарган ажилласан.<br><br>2024-2025 оны хичээлийн жилд ахлах ангийн сурагчид 19 чиглэлээр, бага ангийн сурагчид 6 чиглэлээр удирдан чиглүүлэгч 23 багш, ажилтан ажиллаж давхардсан тоогоор 683 хүүхэд хамрагдаж байна. Давхардсан тоогоор 1-5 дугаар ангийн 184, 6-9 дугаар ангийн нийт 392, 10-12-р ангийн 107 суралцагч хамрагдаж байна. Сургуулийн хэмжээнд нийт сурагчдын 90,7% нь хамрагдаж байна | | |
| | 3 | Хүүхдийн зуны амралтыг үр бүтээлтэй өнгөрүүлэх, тэднийг | 2021 - 2024 | ЕБС | Орон | Хийгддэггүй | Үйл ажиллагаа г | | | Хэрэгжээгүй | 0 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөдөлмөрт сургах, хамтарч ажиллах, чадвар эзэмшүүлэх зорилгоор “Хөдөлмөр зуслан”-г сургуулийг түшиглэн хөгжүүлнэ. | | | нутгийн төсөв | | тогтмолж сон байна. | | | | | |
| Зорилт 7. Нээлттэй боловсролы н тогтолцоог бий болгон цахим болон зайн сургалтын нэгдсэн платформы г хөгжүүлэн, бүх шатны боловсролы н сургалтын байгууллаг ыг цахим хэрэглээнд бүрэн шилжүүлж, бүх насны суралцагч, иргэдэд зориулсан цахим сургалтын хөтөлбөр, агуулга боловсруул ан түгээнэ. | 1 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг интернэт сүлжээнд 100 хувь холбож, хурдыг нэмэгдүүлнэ. | 2021 - 2022 | ЕБС | Улсын төсөв | 80 хувь | СӨББ, ЕБС бүрэн холбогдо ж, чанартай интернет ээр хангагдса н байна. | 9,0 | | Сургуулийн хичээлийн байр интернетэд холбогдсон. Нөхөн хангалтын зардлаар утасгүй интернетийн 8 төхөөрөмжийг суурилуулан хичээлийн байранд ашиглах интернетийг бүх анги, танхим, өрөө тасалгаанд интернет орох боломжийг бүрдүүлсэн. | 90 | |
| | 2 | Суралцагчдын тест, сорил, шалгалтын материалыг богино хугацаанд үнэлж, үр дүн, тайлан мэдээллийг олон төрлөөр боловсруулах хүчин чадалтай программ, техник хэрэгсэл нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. | 2021 - 2024 | ЕБС | Улс, орон нутгийн төсөв | 0 | Суралцаг чдын тест, сорил, шалгалты н материал ыг засах ажлыг бүсийн төвтэй хамтран зохион байгуула х, үр дүнг тооцох | | | Хэрэгжээгүй | | |
| | 1 | Багш, албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний эрүүл мэнд хөдөлмөрийн | 2021 - 2024 | ЕБС СӨББ | Улсын | | Нийгмийн хамгаалл ыг сайжруул | | 2,390, 3 | СӨББ Багш, ажилтаныг эрүүл мэндийн үзлэгт 2022 оноос эхлэн жилд 2 удаа байгууллагаас зардлыг хариуцан хамруулж байна | 90 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 8. Багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжиж, тэднийг урамшуулах , харилцан туршлага солилцох боломжийг олгож, нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ. | | үнэлэмж, орон байрны нөхцлийг сайжруулах асуудлуудыг үе шаттайгаар шийдвэрлэнэ | | | төсөв | | сан байна. | 3,0 | | ЕБС- Багш боловсролын байгууллагын удирдах ажилтны ажлын чанар хөдөлмөрийн үр бүтээлийг үнэлэх төрөөс баримтлах шалгуурыг үндэслэн нийгмийн хамгааллын асуудлыг журмын дагуу шийдвэрлэж үйлчилгээний 13 албан хаагч, 9 багш урамшуулалд хамрагдсан. Ур чадварын нэмэгдлийг 11 багш, үйлчилгээний 4 албан хаагчид олгож байна. Багш нарын орон байрны хангалтыг сум орон нутгийн нөхцөл боломжийн дагуу 8 айлын орон сууцанд 5 багш амьдарч байна. Өрх толгойлсон 1 эмэгтэй албан хаагчид гэрийн шал хандивласан. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 11 багш, ажилчдыг БОЭТ-тэй хамтран 550,000 төгрөгийн улсын төсвөөс төлбөрийг даан хамруулав.<br>Багш нарын эрүүл мэндийн үзлэгт 24 албан хаагч хамрагдсан. | | |
| | 2 | Багш, удирдах ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх "Багшийн цахим кампус" зайн сургалтын системийг хөгжүүлж, багш нарын 70-аас доошгүй хувийг зайн сургалтаар мэргэжил, боловсролыг нь дээшлүүлнэ. | 2021 - 2024 | СӨББ ЕБС | Улсын төсөв | 85 хувь | Үндсэн сургалт, багшийн цахим кампуст хуваарийн дагуу бүрэн хамруулсан байна. 100% | | 1,2 | СӨББ-ийн бүлгийн багш нар болон туслах багш нар “Багшийн цахим кампус” зайн сургалтанд тухайн тавигдсан сургалт бүрд хамрагдаж мэдлэгээ дээшлүүлж, ажилдаа хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>2021-2023 онуудад Багш М.Мөнхжаргал, Н.Долгоржав нар нь Глобал удирдагч ДС-ийн Магистрийн эчнээ ангид 2.5 жил суралцан мэдлэг чадвараа дээшлүүлэн сургуулиа амжилттай төгслөө. Туслах багш Ц.Уртнаст 2.5 жилийн эчнээ сургалтанд “Улаанбаатар эрдэм” дээд сургуульд суралцан СӨББ-ын багш мэргэжлээр бакалавр зэрэгтэй | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3 | | | | | | | | | төгслөө. 2023-2024 оны хичээлийн жилд 1 туслах багш мэргэжлээ дээшлүүлэх эчнээ ангид суралцаж байна.<br>ЕБС-ийн Багш удирдах ажилтнууд цахим болон танхимаар сургалтад хамрагдаж мэргэжил боловсролоо тасралтгүй хөгжүүлж байна. Үүнд модуль сургалтад 25 багш, ажилтан хамрагдаж 84% нь 3 кердитийн батламж авсан. Мөн ажлын байран дээрх сургалтад тогтмол хамрагдаж мэргэжил арга зүйгээ дээшлүүлж ажилладаг.<br>2024 онд ЕБС-Үндсэн сургалтуудад нийт 6 албан хаагч хамрагдаж 100% батламж авсан. Үүнд: Эхний жилийн үндсэн сургалтад 3 багш,5 дахь жилийн үндсэн сургалтад 2 багш 2, удирдах ажилтан хамрагдаж батламж авсан.<br>Багш нар өөрийн мэргэжлийн дагуу цахим сургалтуудад хамрагдаж онолын мэдлэгээ нэмэгдүүлэхэд анхаарч байна. Хосолсон сургалтын арга зүйд тулгуурлан цахим хичээлийн санг мэргэжлийн 19 багш, 20 судлагдахуунаар нэгж, ээлжит хичээлийн иж бүрэн хөтөлбөрийг “Plickers Cards” ашиглан цахим код үүсгэн “Миний арга зүй таны мэдлэгт” туршлагаа түгээн дэлгэрүүлэх самбарт нээлттэй байршуулсан. | | |
| | 3 | Боловсролын салбарын гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлж, жил бүр багш, удирдах ажилтан, | 2021 - 2024 | НБХ БСУГ | Улсын төсөв | - | Боловсролын салбарын хуваарь төлөвлөгөөний | 3,0 | | Хэрэгжээгүй | 0 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэргэжилтнийг гадаад улс оронд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна. | | | | | дагуу мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан байна. | | | | | |
| | 4 | Багш нарын заах арга зүйн хөгжлийг дэмжих тэргүүн туршлага, ур чадвараа түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Багш, сурагч солилцоо”-ны арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | НБХ БСУГ | Улсын төсөв | | Багш-4 Сурагч-8 | | | Хэрэгжээгүй | 0 | |
| | 5 | Багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох, багш нарын ажлын үнэлэмжийг дээшлүүлэх зорилгоор “Чадварлаг багш” арга хэмжээг зохион байгуулж, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнгээр шинэ бүтээл, оновчтой санал /инноваци/ нэвтрүүлсэн багш, удирдах албан хаагч нарт урамшуулал олгоно. | 2021 - 2024 | ЕБС СӨББ | | | Чадварлаг багш арга хэмжээг зохион байгуулж ур чадвартай багшийн арга барилыг түгээн дэлгэрүүлсэн байна. Мэргэжлийн багшийн хангалт 100% | 0,8 | 0,8 | Чадварлаг багш үндэсний дэд хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан эрхлэгчээр баталгаажуулан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.<br>-“Чадварлаг багш” үндэсний дэд хөтөлбөрийн хүрээнд бүлгийн багш нарын дунд сар бүр чиглэл бүрээр нээлттэй үйл ажиллагааг тогтмол зохион байгууллаа. Багш нар бие биедээ ур чадвар, туршлага солилцсон үр дүнтэй, бүтээлч ажилуудыг зохион байгууллаа.<br>2022 оны хичээлийн жилд багш нар нь үнэлгээнд хамрагдаж 1-р түвшинд 2 баг 4-р түвшинд 1 багш, байгууллага нь 2-р түвшинд үнэлэгдэн ур чадварын урамшуулалд хамрагдсан. | 90 | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болсон байна. | | | -“Чадварлаг багш” үндэсний дэд хөтөлбөрийн хүрээнд бүлгийн туслах багш нарын дунд сар бүр “Үлгэрээр” нээлттэй хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгууллаа. ЗАН-ын гишүүдээрээ ололттой, дутагдалтай талуудыг хэлэлцэн туслах багш нарын ур чадвар, үр бүтээлийг нэмэгдүүлэх үүднээс заавар зөвлөгөө өгөн ажиллаа.<br>2023 оны 1 дүгээр сард бүсийн дунд зохион байгуулсан илтгэлийн уралдаанд “Багшийн ёс зүй харилцаа хандлага” сэдвээр Бэлтгэл бүлгийн багш Н.Долгоржав амжилттай оролцсон<br><br>ЕБС сургууль 2023 оны 4 дүгээр сарын гүйцэтгэлийн үнэлгээнд байгууллага, багш нар амжилттай хамрагдаж нийт 3 багшийн 2 багш ур чадварын урамшуулалд хамрагдаж байна. 9-р сард аймгийн боловсролын салбарын спортын наадамд 28 хүний бүрэлдэхүүнтэй баг амжилттай оролцсон. 10-р сард аймгийн Зүүн бүсийн ерөнхий боловсролын сургуулиудын туршлага солилцох, уулзалт тэмцээнд Баян-Өндөр суманд зохион байгуулагдаж 27 хүний бүрэлдэхүүнтэй баг амжилттай оролцож гутгаар байр эзэлсэн.<br>2024 онд Тэргүүлэх багш нарын нэрэмжит ур чадвар, нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулах уралдаан зохион байгуулж 15 багш оролцсон. Сурган хүмүүжүүлэх илтгэлийн уралдаанд 11 багш оролцож 3 багш аймгийн шатанд оролцохоор болсон. | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 9. Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ. | 1 | Насан туршийн боловсролын танхимтай болоход дэмжлэг үзүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулна. | 2021 - 2022 | ЕБС НТБ-ын арга зүйч | | | Насан туршийн танхим байгуулж үйл ажиллагаа нь тогтмолжсон байна. | 8,0 | | Ерөнхий боловсролын сургуулийг түшиглэн үйл ажиллагаа явуулж байна. Цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтот жилийн хүрээнд иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургагч багшийн сургалтад Насан туршийн суралцахуйн нэгжийн багшийг хамруулж байгууллагын хэмжээнд e-Mongolia танилцуулга, ахлах ангийн сурагчдад цахим орчин дахь аюулгүй байдлын талаарх сургалтуудыг зохион байгууллаа. сургалтад нийт 77 албан хаагч, сурагч хамрагдсан. тархины саажилт, зүүн талын саа G80/ боловсролын мэдээллийн системд бүртгэж, алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь төслөөр ерөнхий боловсролын сургуульд хөрөнгө оруулалтаар орж ирсэн миний номын өргөөний гарын дасгал хөдөлгөөнийг сайжруулах ном тоглоомын багцад хамруулан анхан шатны мэдлэг бүтээх чадварт суралцуулан ажиллаж байна. | 70 | |
| | 2 | Насан туршийн боловсрол олгох сургалтыг бизнес, амьдрах ухаан, хүний хөгжил, ёс суртахуун, гоо зүй, гэр бүл, байгаль орчны, иргэний боловсрол (эрх зүй, эрүүл мэнд, гамшгаас хамгаалах) олгох чиглэлээр сургалтын олон талт хэлбэрээр зохион байгуулна. | | НТБ-ын арга зүйч | | - | Насан туршийн боловсрол олгох 5 чиглэлийн сургалтыг зохион байгуулж, хамрагдсдын тоог нэмэгдүүлж нийт иргэдийн | | | Санхүүгийн боловсролын чиглэлээр: хувь хүний санхүүгийн төлөвлөлт, сэдэвт сургалтыг 1 удаа зохион байгуулж 28 иргэн хамрагдсан. Гэр бүлийн боловсрол чиглэлээр: “Гэр бүл-хүүхэд хүмүүжил”, “Хүүхэд хүмүүжүүлэх сөрөг арга” сэдвүүдээр сургалтыг зохион байгуулж сургалтанд 34 иргэн хамрагдсан байна. Иргэний боловсрол чиглэлээр: “Архины хор хөнөөл” сэдэвт сургалтыг ЕБС-ийн багш албан хаагчдад зохион байгуулан нийт 42 хүн хамрагдсан. Ёс суртахуун төлөвшлийн боловсрол | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 12 хувь хүрсэн байна. | | | чиглэлээр: Дотуур байрын багш, нийгмийн ажилтан нартай хамтран дотуурын байрын суралцагч нарт харилцаа ба хандлага сэдвээр сургалт зохион байгуулж сургалтанд 56 сурагч хамрагдсан. Амьдрах ухааны боловсролын чиглэлээр: Мэргэжил сонголт ба амьдрал үнэ цэнэ сэдэвт сургалтыг 8-12 ангийн сурагчдад зохион байгуулж 113 хүүхэд хамрагдсан. | | |
| | 3 | Насанд хүрэгчдийн тасралтгүй сургалт болон ерөнхий боловсрол нөхөн олгох сургалтыг зохион байгуулна. | 2021 | НТБ-ын арга зүйч | Улсын төсөв | | Бага-2 Суурь-7 Бүрэн дунд- | | | Дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг ЕБС-ийг түшиглэн заах аргач болон түүнээс дээш зэрэгтэй багш нартай гэрээ байгуулан хичээл сургалтаа явуулдаг. 2022-2023 оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд 8 хүүхэд суралцаж 1 суралцагч суурь боловсрол эзэмшсэн. 2023-2024 оны хичээлийн жилд 7 сурагч суралцаж байна. | 90 | |
| | 4 | Монгол бичигт суралцах бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлнэ. | 2021 - 2024 | ЕБС Байгууллагын дарга нар | Орон нутгийн төсөв | 10 | Сумын хэмжээнд хэрэгжүүлж, үр дүнг дээшлүүлж ажиллана 22% | 0,8 | 0,2 | -Төрийн албан хаагчдад Үндэсний бичгийн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, үндэсний бичгийн чадварын түвшинг тогтоосон. Анхан, дунд, ахисан түвшин гэсэн үе шаттайгаар ялгаатай даалгавар өгч ажилласан.<br>- ЕБС-ийн хамт олон Хүмүүн бичиг сонин хамт олноороо захиалан уншиж үндэсний бичгийнхээ мэдлэг чадварыг ахиулан ажиллаж бна.<br>-12-р ангийн суралцагчид 6-11-р ангийн суралцагчидтай хамтран туршлага солилцон ажиллаж бна.<br>-Сурагчид Уран зохиолын хичээлтэй холбогдуулан шүлэг найраглалыг үндэсний бичгээрээ бичин бүтээлийн 3 төрлийн үзэсгэлэнд 94 сурагч оролцсон гаргав. | 90 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | | | | | | | | | -Аймаг, сум, сургуулиас зохион байгуулсан 5 төрлийн уралдаан тэмцээнд давхардсан тоогоор 186 сурагч идэвхтэй хамрагдан оролцож байна.<br>-Албан байгууллагаараа Үндэсний бичгээр бичих цахим челленж зарлан бусад албан байгууллагыг хамруулан ажиллаж бна.<br>- Монгол бичгийн сургалтыг албан хаагчдын дунд зохион байгуулж үр дүнг тооцон ажиллаж байна. Анхан шатанд 14 дунд шатанд 20, гүнзгий шатанд 8 албан хаагч суралцаж байна. Хамт олноороо Хүмүн бичиг сонины нэмэлт захиалга өгсөн. Монгол бичгийн хичээнгүй бичиг, дасгал ажлын дэвтэр, 3 төрлийн цахим толийг ашиглаж хэвшээд байна. Мөн 35 албан хаагч монгол бичгийн цахим бичвэрийн байти фондын ашиглаж байна. Цахим бичгийн сургалтад аймгийн хэмжээнд 2 албан хаагч, сургуулийн хэмжээнд 35 албан хаагч хамрагдсан. Монгол бичгийн судалгаанд 46 албан хаагч хамрагдсан. Байгууллагын хэмжээнд албан бичгийг монгол бичгээр бичих туршилтыг хийж эхлүүлсэн. Албан бланк захиалан ашиглаж байна. чадварыг ахиулан ажиллаж бна.<br>Цахим судалгаанд 46 албан хаагч хамрагдсан. ийн хамт олон | | |
| **1.5 Хүүхэд, залуучууд гэр бүлийн хөгжил** | | | | | | | | | | | | |
| Зорилт 1. Гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын бодлогыг | 1 | Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах гэр бүлийн боловсрол олгох үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулна. | 2021 - 2024 | ЗДТГ-ын нийгмийн бодлогын | Орон нутгийн төсөв | | Гэр бүлийн боловсрол олгох сургалтанд залуу | | | Сумын хэмжээнд нийт 794 гаруй өрх байгаагаас гэр бүлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мэргэжлийн байгууллагын хийсэн судалгаа, нотолгоонд тулгуурлан гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| хэрэгжүүлэн гэр бүлийн хөгжлийг дэмжиж, тогтвортой, чадавхижсан гэр бүлийг төлөвшүүлнэ. | | | | мэргэжилтэн | | | гэр бүлийн 40% хамрагдсан байна. | | | нийт 2021-2023 онд 83 өрхөд дүн шинжилгээ хийлээ. Гэр бүл салалтын хор хөнөөл, гэр бүлийн үнэ цэнийн талаар багийн иргэдийн нийтийн хурлууд дээр 5 багийн нийт өрхийн 50 хувьд нь сургалт мэдээлэл хийж ажилласан. | | |
| | 2 | Гэрлэлтээ батлуулж буй гэр бүлд гэр бүлийн үүрэг хариуцлагын талаар зөвөлгөө , мэдээлэл өгч ажиллана. | 2021 - 2024 | ЗДТГ-ын НБМ | Орон нутгийн төсөв | 10 | 40 гэр бүл зөвөлгөө өгөх | | | 2021 -2024 онд сумын хэмжээнд нийт 29 гэр бүл батлуулсан бөгөөд гэрлэлтээ батлуулж байгаа залуу хосуудад гэр бүлийн үнэ цэнийн талаар тодорхой олголт өгч гарын авлага материалаар хангаж ажилласан. Багийн хурлууд дээр гэр бүлийн үнэ цэнэ , гэр бүлийн тогтвортой байдлын талаар гарын авлага бэлтгэн 5 багийн 46 гэр бүлд олгосон. | 90 | |
| | 3 | Гэр бүлийн хүчирхийллийг бууруулахын тулд түр хамгаалах байртай болно. | 2021 - 2024 | НБМ | Орон нутгийн төсөв | 1 | Түр хамгаалах байртай болох | | 1,335.0 | Түр хамгаалах байраар ЗДТГ-ын арын 1 өрөөг тохижуулан цагдаагийн хамгаалалтад байлгадаг бөгөөд тус байраар 5 иргэн үйлчлүүлсэн. 2021-2024 онуудад гэр бүлийн хүчирхийллийн 9 дуудлага ирсэнээс хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалж аюулгүй байдлыг нь хангаж эрсдэлийн үнэлгээ хийж шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад шилжүүлж ажилласан. Гэр бүлийн хүчирхийлэл архидан согтууралтын байдлаас болж хүн амьны 1 хэрэг бүртгэгдсэнийг шүүхээр шийдвэрлүүлсэн. | 90 | |
| | 4 | Хүүхдийн хөдөлмөрийн мөлжилгөөс сэргийлж сургууль завсардсан хүүхдийг сургуульд хамрагдуулна. | 2021 - 2024 | ЗДТГ-ын НБМ | Орон нутгийн төсөв | 5 хүүхэд сургууль завсардсан | 0 | | | 2021-2024 Сургууль завсардсан 8 хүүхэд байгаа ч ажил хөдөлмөр эрхэлдэггүй өөрийн гэртээ ээж аавын хамт мал маллаж байгаа бөгөөд айлд мал малладаг болоод өөр бусад | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хэлбэрээр хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд байхгүй.<br>Дүйцэх хөтөлбөрийн ахлах ангид 7, дунд ангид 1 сурагч суралцаж байна. | | |
| | 5 | Хүүхдийн амралт, зусланд хөгжлийн бэрхшээлтэй, хамгаалалтанд байдаг хүүхдүүдийг жил бүр хамруулна | 2021 - 2024 | ЗДТГ-ын НБМ | Орон нутгийн төсөв | 0 | 5 хүүхэд амралт зусланд хамруулах | | 1,0 | 2022 онд Хүрэмтийн амралтад 1 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг амраасан. Зорилтот бүгийн 10 хүүхдийг Францын хөрөнгө оруулалттай зуны сургалтад 10 хоног хамруулсан. 2023 онд Зорилтот өрхийн 1 хүүхэд цагаан залаа зусланд амарсан.<br>2024 оны 7 дугаар сард аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын газартай хамтран Архангай аймгийн Тамир зусланд зорилтот өрхийн 1, хөгжлийн бэрхшээлтэй 1 хүүхдийг тус бүр 7 хоног амраасан. | 90 | |
| | 6 | Төр, хувийн хэвшлийн байгууллагуудад “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлж, “Гэр бүлийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, тэмцээн уралдаан зохион байгуулж хэвшинэ. | 2021 - 2024 | ЗДТГ-ын нийгмийн бодлогын мэргэжилтэн | Орон нутгийн төсөв | Гэр бүл рүү чиглэсэн уралдаан тэмцээн жилд 1-2-ийг зохион байгуулж байсан | 4 Арга хэмжээ зохион байгуулсан байна. | | | 2021-2024 онд сумын төр болон аж ахуй нэгжүүдийн гэр бүл хүүхэд хамгааллын салбар зөвлөл байгуулагдан, байгууллага бүрийн гэр бүлийн зөвлөл хүүхэд гэр бүл рүү хандсан 1-2 арга хэмжээг тус тус зохион байгуулан ажиллаж хэвшсэн.<br>Төсвийн 4 байгууллага дээр гэр бүлийн зөвлөл тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Олон улсын гэр бүлийн өдөр болон бусад тэмдэглэлт өдрүүдийг байгууллагын ажилчдын гэр бүлийн дунд уралдаан тэмцээн зохион байгуулах зэрэг ажлыг тогтмол зохион байгуулж хэвшсэн. | 90 | |
| Зорилт 3. Залуучуудын хөгжил, оролцоог дэмжсэн орчин | 1 | Залуучуудын хөгжлийн бүлэг , клубын үйл ажиллагааг болон сайн дурын ажил, | 2021 - 2024 | ЗДТГ-ын нийгмийн бодлогын | Орон нутгийн төсөв хандив | Суурь тавигдсан | залуучуудын 60%-ийг хамруулна | | 0.540 | 2021-2024 оны байдлаар суманд 2 залуучуудын байгууллага үйл ажиллагаа явуулж байна. шинэ жил, мөсний баярын арга хэмжээ зэргийн тогтмол зохион байгуулж хэвшсэн. Эдгээр ажлуудыг сумын Засаг даргын | 70 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| нөхцөлийг бүрдүүлж, тэдний оролцоог хангах олон талт арга хэмжээг зохион байгуулж, нийгмийн идэвхтэй гишүүн болгоход дэмжлэг үзүүлнэ. | | санал санаачилгыг бүх талаар дэмжинэ. | | мэргэж илтэн | | | | | | Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдын хурал зэрэг төсөвт байгууллагууд дэмжин хамтарч ажилладаг.Дээрх 2 арга хэмжээнд сумын нийт залуучуудын 70 хувь нь бүрэн хамрагдсан. | | |
| | 2 | Сумын төрийн болон төрийн бус байгуулагуудтай хамтран хөдөөгийн залуучуудын хөгжүүлэх, эрүүл амьдралын зөв хэв маягт суралцах явуулын үйлчилгээг нэвтрүүлж , залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ. | 2021 - 2024 | ЗДТГ-ын нийгмийн бодлогын мэргэжилтэн | Орон нутгийн төсөв | суурь түвшин тавигдсан | залуучуудын 80%-ийг хамруулна | | | 2022 оны 8-р сарын 4-ны өдөр сумын багуудын дунд эрэгтэй, эмэгтэй гар бөмбөг, дардас, олс таталт,дэмбээ, нийтийн монгол бөх гүүтэй айлын гүзээ хүү, охин, гар барилдаан хөгжөөнт буухиа, дуэт дуу, багийн мэндчилгээ зэрэг төрлүүдээр зохион байгуулсан. Нийт 300 -аад иргэн оролцсон байна. 2023 онд 8 сард багуудын дунд урлаг спортын 6 төрлөөр тэмцээн явуулж нийт 250 иргэн оролцсон. Мөн багуудын өдөрлөгт зориулсан тэмцээнд залуучуудыг түлхүү оролцуулсан. | 70 | |
| Зорилт 4. Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тасралтгүй хөгжүүлэх, тэдний эрэлт хэрэгцээнд суурилсан хөгжил оролцоог хангасан салбар дундын зохицуулалт хийж, нийгмийн | 1 | Ахмадын хөгжлийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулна. | 2020 - 2024 | НБМ Ахмадын хороо | Орон нутгийн төсөв | | Нийт ахмад настаны 36% нь үйлчлүүлсэн байна. | | 8.3 | Сумын ахмадын төв 2018 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн. Одоогоор үйл ажиллагаа нь тогтмолжсон. Ахмадын хорооны дарга Сумын Засаг даргатай жил бүр хамтран ажиллах гэрээ байгуулан гэрээний дагуу арга хэмжээ зохион байгуулан ажилладаг. 2021- 2024 онд ахмадын төвөөр 500 ахмад настан өдрийн үйлчилгээ, дархлаа сэргээх үйлчилгээ, эрүүл мэндийн тоног төхөөрөмж, хийн дасгал , чөлөөт цагаа зөв зохистой өнгөрөөх зэргээр тогтмол үйл ажиллагаа явуулж байна.<br>Сумын ахмадууд аймаг болон бүсийн чанартай уралдаан тэмцээнд тогтмол амжилттай оролцож ирсэн. | 100 | |
| | 2 | Ахмад настны насан туршдаа суралцах боломжоор хангаn, | 2021 - 2024 | НБМ Ахмадын хороо | | ахмадын төвөөр нийт | 55 хувьд хүргэх | | | 2023 онд ахмад настанууд<br>Ахмадын оролцоо чуулган, Аймаг бүсийн спорт тэмцээнд 30 гаруй ахмад | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| идэвх оролцоог нэмэгдүүлнэ. | | насан туршийн боловсрол төв, нэгжүүдтэй хамтарсан сургалт, уулзалт арга хэмжээг тогтмол зохион байгуулж, аж ахуйн нэгж байгууллагуудад ахмадын зөвлөх үйлчилгээг нэвтрүүлнэ. | | | Орон нутгийн төсөв | ахмад настнаы 30% нь үйлчлүүлж байна. | | | | идэвхи санаачлагатай оролцсон. Мөн ..........ахмад настанууд эрт илрүүлэгийн үзлэг оношилгоонд хамрагдсан байна. Мөн ахмад настаны зөвлөх үйлчилгээнд 1 ахмад настан хамрагдсан байна.<br>2024 оны байдлаар өдрийн үйлчилгээнд 19 ахмад настан 14 хоног хамрагдсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нэг ахмад настан 10 сая төгрөгийн төсөл хөтөлбөрт хамрагдсан. | | |
| | 3 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд суурилсан сэтгэлзүйн болон сэргээн засах сургалт арга хэмжээг тогтмол зохион байгуулж, хөгжих оролцох боломжийг сайжруулах багц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | НБМ | Орон нутгийн төсөв | Жилд 1 арга хэмжээ зохион байгуулдаг | Жилд 2 арга хэмжээ зохион байгуулах | | | Сумын хэмжээнд нийт 83 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаагаас 72 нь насанд хүрэгчид 12 нь хүүхэд байна. 6 хүүхэд сумандаа ЕБС-д хэвийн ангид суралцаж байна.<br>Багуудын нэгдсэн өдөрлөгийн үеэр зохион байгуулагдсан арга хэмжээнд 3 хөгжлийн бэрхшээлтэй иргэн оролцсон. Мөн аж ахуй нэгж байгууллагуудын дунд зохион байгуулсан урлаг спортын 6 удаагийн арга хэмжээнд 2 хөгжлийн бэрхшээлтэй иргэн тогтмол оролцож байна. | 100 | |
| **1.6 Хөдөлмөр, нийгмийн хамгаалал** | | | | | | | | | | | | |
| Зорилт 1. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангаж, халамжаас хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх замаар ажилгүйдли | 1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хүрээнд хөнгөлөлттэй зээлд хамруулан, ажилд зуучлах замаар жил бүр 25-аас доошгүй иргэнийг байнгын, 40-өөс доошгүй иргэнийг түр ажилд зуучлана | 2020 - 2024 | ЗДТГ/сум хариуцсан мэргэжилтэн/ | Улсын төсөв | захиалга зуучлал -25 түр ажлын байр - 40 | захиалга зуучлал -25 түр ажлын байр - 40 | 13750000 | 46200,000 | 2021-2024 онуудад сумын хэмжээнд нийт 236 иргэнийг захиалга зуучлал болон шинэ ажлын байранд бүртгэн ажиллаад байна. | 100 | |
| | 2 | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн чиг | 2020 - 2024 | ЗДТГ/сум хариуцс | | Суурь тавигдсан | Иргэдэд ажил мэргэжли | | | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн чиг хандлагад нийцүүлж, ажил мэргэжлийн чиг | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| йн түвшинг бууруулж, нийгмийн дундаж давхаргыг нэмэгдүүлнэ. | | хандлагад нийцүүлж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээнд иргэдийг хамруулна. | | ан мэргэж илтэн/ | Улсын төсөв | | йн баримжаа, зөвөлгөө өгөх Жил бүр 2 иргэн | | | баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээнд 2 иргэнийг хамруулан ажиллаж байна. | | |
| | 3 | Харьцангуй бага хэрэглээтэй, дунджаас доогуур түвшний орлоготой өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн иргэнийг мэргэжил эзэмшүүлэх. | 2020 - 2024 | ЗДТГ/сум хариуцсан мэргэжилтэн/ | улсын төсөв | | Жил бүр 2 иргэнийг мэргэжлийн сургалтад хамруулсан байна | | . | Харьцангуй бага хэрэглээтэй буюу хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг өрхүүдийг шат дараатай хөдөлмөрт зуучлан ХЭБ-ийн үйлчилгээ авдаггүй сум болсон. Малжуулах хөтөлбөр арга хэмжээ, айлд мал маллах. | 100 | |
| | 4 | Эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангийн зээл, төсөл, хөтөлбөрт хамруулан хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | 2020 - 2024 | ЗДТГ/сум хариуцсан мэргэжилтэн/ | Орон нутгийн төсөв | | 8 хүртэл иргэнийг төсөл, хөтөлбөрт хамруулсан байна | 37 | 41,0 | Эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж 2021-2024 онуудад ХЭДСангаас 6 эмэгтэйг төсөлд хамруулсан байна. | 100 | |
| . Зорилт 2. Нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой болгон, | 1 | Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд үндэслэн зорилтот бүлгийн өрхүүдийг оновчтой тодорхойлно. | 2020 - 2024 | ЗДТГ/сум хариуцсан мэргэжилтэн/ | Улсын төсөв | | ирүүлсэн өргөдлийн тоогоор | | 0,08 | Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд 10 өрх хамруулсан | 100 | |
| зорилтот өрх, иргэний амьжиргаанд дэмжлэг үзүүлж, амьдралын чанарыг | 2 | Зорилтот бүлгийн өрхүүдийн дунд бүлэг байгуулан, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээгээр дэмжин ажиллана. | 2020 - 2024 | ЗДТГ/сум хариуцсан мэргэжилтэн/ | Улсын төсөв | 1 бүлэг | 1 бүлэг | 3,0 | 4,995 | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнээс 2 бүл төсөл авч ажиллаж байгаа. Мөн 19 иргэнийг өдрийн үйлчилгээнд хамруулсан. | 100 | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| дээшлүүлнэ . | 3 | .“Нэг өрх-Нэг ажлын байр” хөтөлбөрийн хүрээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн иргэдийг ажлын байраар хангаж, нийгмийн халамж хүртэгчдийн тоог бууруулна. | 2020 - 2024 | ЗДТГ/сум хариуцсан мэргэжилтэн/ | Улсын төсөв | 18 өрх | иргүүлсэн өргөдлийн тоогоор | 12,8 30,0 | 25,75 | Нэг өрх нэг ажлын байр хөтөлбөрийн хүрээнд 3 өрхийг сонгон ажиллаж тухайн 3 өрхийн хөдөлмөрийн насны 6 иргэн ажлын байраар хангагдан ажиллаж байна. | 100 | |
| | 4 | Нийгмийн халамжийн бүрдүүлэх материалыг цахимаар хүлээн авч,иргэдэд шуурхай үйлчилнэ. | 2021 - 2024 | ЗДТГ/ сум хариуцсан мэргэжилтэн | Улсын төсөв | 9 төрлийн 709 иргэн | иргүүлсэн хүсэлтийн тоогоор | | 1,162, 3 | 2021 онд 9 төрлийн үйлчилгээнд давхардсан тоогоор 709 иргэн , 2022 онд 11 төрлийн үйлчилгээнд 720 иргэн , 2023 онд 915 иргэн хамрагдсан, 2024 онд 1061 иргэн хамрагдаад байна. | 100 | |
| Зорилт 3. Нийгмийн даатгалын мэдээллийг бүрэн цахимжуулан, иргэд даатгуулагчдад үйлчилгээг ил тод, шуурхай хүртээмжтэй хүргэх, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдыг нийгмийн даатгалд хамруулж, | 1 | Нийгмийн даатгалын цахим мэдээллийн сан бүрдүүлж, архивын цахим лавлагааны үйлчилгээг жигдрүүлж, иргэд даатгуулагчдад шуурхай үйлчилгээ үзүүлнэ. | 2020 - 2024 | ЗДТГ/сум хариуцсан мэргэжилтэн | Улсын төсөв | | Иргэдийн тоо | | | Нийгмийн даатгал цахим хөтөлбөрт шилжснээр иргэд даатгуулагчид түргэн шуурхай үйлчлэх нөхцөл бүрдсэн. 2021 онд нийгмийн даатгалын аппликейшн ухаалаг гар утсандаа суулгаж баталгаажуулж хэрэглэж эхэлсэн 150 иргэн байна. 2020-2024 онд нийт 167 иргэн өндөр насны тэтгэвэр, ХЧТА-ны тэтгэвэр 22, Тэжээгчээ алдсаны тэтгэвэрээр 7 иргэн тэтгэврээ тогтоолгосон байна. 2021-2023 онд иргэд тэтгэмжийн материалыг цахим болон цаасан хэлбэрээр өгч нийт ажилгүйдлийн тэтгэмж 26, ХЧТА-ны тэтгэмж 32, Жирэмсэн амаржсаны тэтгэмж 62, оршуулгын тэтгэмж 39 иргэний ар гэрт олгоод байна. 2024 онд нийгмийн даатгал бүрэн цахимжин даатгалын системээр тэтгэмж авах хүсэлтээ илгээн нийт 23 иргэн цахимаар | 100 | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| тэдний нийгмийн баталгааг хангана. | | | | | | | | | | хүсэлтээ илгээн тэтгэмжийн үйлчилгээ аваад байна. 13 иргэний оршуулгын тэтгэмжийн материалыг цаасан хэлбэрээр материалыг хүлээн авч ар гэрт нь олгосон. | | |
| | 2 | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлж, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | 2020 - 2024 | ЗДТГ/сум хариуцсан мэргэжилтэн | Хувийн хөрөнгө<br><br>Улсын төсөв | Эрүүл мэнд-452 Сайн дур -304 647 | 2021-700 2022-740 2023-780 2024-820 иргэн тус тус хамрагдсан байна. | | | 2021-2023 онд Нийгмийн даатгалын шимтгэлд малчид хувиараа хөдөлмөр эрхлэгч нарыг сайн дурын даатгалд хамруулж байна.<br>Сайн дурын даатгалд 2021-523, 2022-201, 2023-234, 2024-270 иргэн тус тус хамрагдсан байна. Сайн дурын шимтгэлийн орлого 2021 онд 91 сая орж 55,6%, Эрүүл мэндийн шимтгэлийн орлого 22,6 сая төгрөг орж 57,8%. 2022 онд СДД орлого 90 сая орж 67,8%, ЭМДШимтгэлийн орлого 17 сая төгрөг орж 43,8%, 2023 онд 144 сая төгрөг орж 78%, ЭМДШимтгэлийн орлого 12 сая орж 52%, 2024 онд СДД орлого 709,4 сая төгрөг 100-аас дээш хувиар биелэсэн байна. | 90 | |
| | | | **БҮЛГИЙН ДҮН /Тухайн жилийн хэрэгжилт 93 арга хэмжээ /** | | | | | | | | **84,5** | |